



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 22 он 12
сарын 14 өдөр

Дугаар 311/158

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд



П.ОЮУН-ЭРДЭНЭ

000224000998



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20²² он 11 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар ХТ/2792

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт^{2/4} хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Д.АМАРБАЯСГАЛАН

000225015379



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.11.17 № 1/5846
танай 2022.11.16 -ны № 01/7832 -Т

**САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151605599

A5 Файл.2022



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2022.11.16 № 01/7839

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН
ТАНАА**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН


9761001143

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 55 дугаар тэмдэглэлд:

“III.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль 2000 онд батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах хууль, эрх зүйн үндэслэл бий болсон. Хуулиар энэхүү үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтын хувьд хагас төвлөрсөн тогтолцоотой байхаар тогтоосон. Тус хуулийг 2005 онд шинэчлэн найруулж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баталснаар худалдан авах ажиллагааг захиалагч бие даан зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналт, хариуцлагыг бүрэн хүлээх, төвлөрсөн бус тогтолцоонд шилжсэн.

Хууль батлагдсанаас хойш нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй холбогдуулан төрийн худалдан авах ажиллагааны цар хүрээ ихээр нэмэгдэхийн хэрээр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг боловсронгуй болгох, худалдан авах ажиллагаанд оролцогчдын хоорондын харилцааг зохицуулах, бусад салбар хуулиудын шинэчлэлтэй холбогдсон зохицуулалтыг тусгах зэрэг шалтгаанаар хуульд нийт 32 удаа нэмэлт, өөрчлөлт орсон нь хуулийн зохицуулалтын нэгдмэл байдлыг алдагдуулахад хүргэжээ.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд худалдан авах ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр зорилтууд тусгагдсан. Тухайлбал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлийн хүрээнд тендер шалгаруулалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, гэрээ шууд байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгох, гэрээний үүргээ

биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх зэрэг зорилтууд багтсан. Энэхүү зорилтын хүрээнд 2019 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд цахим худалдан авалттай холбоотой нэмэлт, өөрчлөлт орсон боловч худалдан авах ажиллагааны бүх үе шатыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэхэд хангалтгүй байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тендер шалгаруулалтын үйл ажиллагааг хиймэл оюун ухаан, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгах, мэдээллийн ил тод байдал, худалдан авах ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхээр заасан. Үүнтэй холбогдуулан тендер шалгаруулалтыг төлөвлөх, зарлан мэдээлэх, тендерийн нээлт хийх, тендер шалгаруулалтын үр дүнг нийтлэх ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн боловч тендерийг үнэлэх, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүсэж байна.

Түүнчлэн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.3 дахь зорилт (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх)-ын хүрээнд “төрийн худалдан авалтаар бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих, шаардлагатай түүхий эд, тоног төхөөрөмжөөр хангах, хэрэгцээтэй хүний нөөцийг бэлтгэн, мэргэжилтэй ажилчдын мэдээллийн сан бүрдүүлэх”, хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4 дэх зорилт (Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах)-ын хүрээнд “төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлж, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ” гэж тус тус заасан бөгөөд 2030 он гэхэд Засгийн газрын ногоон худалдан авалтын хүрэх түвшин 30 хувь байхаар тогтоосон.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд төрийн байгууллага цахим худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагдах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс нээлттэй, ил тод худалдан авч, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн зарцуулалтыг хяналттай болгох зохицуулалт тусгагдаж цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглосон нь цахим дэлгүүрийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагыг бий болгож байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасны дагуу Сангийн яамнаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2021 онд үнэлгээ хийсэн ба уг үнэлгээний тайлангийн дүгнэлтэд хуулийг шинэчлэн найруулах гэж зөвлөмж гарсан зэрэг нь хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хууль, эрх зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг шинэчлэн найруулах дараах практик үндэслэл, шаардлага байна. Үүнд:

1.Мэдээллийн технологийн хөгжлийг дагаж тендер шалгаруулалтад бүрдүүлдэг баримт бичгийг тендерт оролцогчоос шаардах бус төрийн мэдээллийн сангийн анхдагч өгөгдөлд үндэслэн тендер шалгаруулалтад хянан үзэх хэлбэрт шилжиж байна. Мөн төрийн мэдээллийн нэгдсэн санг худалдан авах ажиллагааны цахим системтэй холбож хүний оролцоогүйгээр лавлагаа, тодорхойлолт авах боломж бүрдсэн тул тендерт оролцогчдын ерөнхий чадавх, нөөц бололцоо, гэрээ хэрэгжүүлэх чадавхын талаарх мэдээллийг цахим системээр солилцох асуудлыг хуулиар зохицуулснаар тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулах, улмаар субъектив шийдвэр гаргах эрсдэлийг бууруулна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн судалгаанаас үзэхэд¹ 955 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийн 94.5 хувь нь цахим системээр тендер шалгаруулалтын мэдээлэл, урилгатай танилцдаг бол, 78.1 хувь нь нэн тэргүүнд цахим системээс тендер шалгаруулалтын үр дүн, захиалагчийн шийдвэрийг хүлээн авдаг байна.²

Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 2019 онд хийсэн үнэлгээгээр Монгол Улс худалдан авах ажиллагааны цогц цахим системийг нэвтрүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлсэн болохыг онцлохын хамт цахим системийг цаашид машин унших боломжтой нээлттэй өгөгдөл дамжуулдаг байх загвараар хөгжүүлэхийг зөвлөсөн.³

2.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулиар зохицуулж байна. Түүнчлэн Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-аар шалгарсан тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн нууцлаагүй хэсгийг бусад оролцогчдод ил болгох, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-аар тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг тухай бүр цахим системээр олон нийтэд мэдээлэхээр зохицуулсан боловч хувь хүн, байгууллагын нууцад хамаарахгүй мэдээллийг ил болгох эрх зүйн орчны уялдааг хангах шаардлагатай байна.

Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зарласан тендер шалгаруулалтад 2020 онд 7,093 тендерт оролцогчоос 54,051, 2021 онд 6,511 тендерт оролцогчоос 46,489, 2022 онд 4,352 тендерт оролцогчоос 28,869 тендер ирүүлсэн бөгөөд мөн онуудад шалгарсан тендерт оролцогчийн илгээсэн тендерийн хуулиар нууцад хамаарахгүй давхардсан тоогоор 92,912 файлтай бусад тендерт оролцогч танилцсан байна.

¹ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 10 дахь тал.

² Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 27-28 дахь тал.

³ Fourth Round Of Monitoring Mongolia, Page 84, OCED, 2019, Anti-Corruption Reforms in Mongolia (oecd.org)

Түүнчлэн худалдан авах ажиллагааны ил тод байдлыг баталгаажуулж нээлттэй мэдээллийг нуун дарагдуулсан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг нэг мөр журамлах, хууль тогтоомж зөрчигдсөн тохиолдолд буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох нь чухал байна.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний судалгаанд оролцсон иргэн, аж ахуйн нэгж болон захиалагчийн төлөөллөөс худалдан авах ажиллагааны хууль, түүний хэрэгжилтийг сайжруулах зорилгоор нэн тэргүүнд өөрчлөх шаардлагатай асуудлын нэгээр нээлттэй тендер шалгаруулалтын үед тендер хүлээн авах хугацааг багасгах, тендер шалгаруулалтын үйл явцыг хялбарчлах шаардлагатай гэж үзсэн.⁴

Хуулийн төслөөр төрийн мэдээллийн сангийн анхдагч өгөгдлийг хүний оролцоогүйгээр солилцох замаар иргэн, аж ахуйн нэгжүүд тендерт бэлтгэн илгээх баримт бичгийг боловсруулахад зарцуулдаг хугацааг багасгах тул тендер хүлээн авах хугацааг худалдан авах ажиллагааны цар хүрээтэй уялдуулан богино хугацаагаар тогтоох боломж бүрдүүлнэ.

4.Жил бүр давтагддаг нийтлэг ажил, зөвлөхийн бус үйлчилгээ тухайлбал авто зам засвар, арчлалт, даатгал, хоолны үйлчилгээ зэрэг гэрээг төсвийн жилд үндэслэн байгуулдаг нь төрийн байгууллагын хувьд дээрх гэрээг жил бүр шинэчлэн байгуулах шаардлага үүсгэдэг. Төсвийн жил шинээр эхлэх хугацаатай зэрэгцэн дараагийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулдаг нь ажил, үйлчилгээ тасалдах эрсдэлтэй байхын зэрэгцээ төрийн байгууллагад үргүй зардал, цаг хугацаа алдах, нэмэлт гэрээ хийх зэрэг нөхцөлийг үүсгэж байна. Нөгөө талаар, хувийн хэвшлийн хувьд богино хугацаатай гэрээ нь бизнесийн үйл ажиллагааг дунд хугацаанд төлөвлөх, хөрөнгө оруулах боломжийг хязгаарлаж байдаг.

Иймд төрийн байгууллагад шаардлагатай жил бүр давтагддаг нийтлэг ажил, зөвлөхийн бус үйлчилгээг урт хугацаанд авах, барилга байгууламж, оффисын тоног төхөөрөмж, машин механизмын түрээслэх харилцааг боловсронгуй болгох, хэд хэдэн захиалагч хамтран хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг зохион байгуулах асуудлыг зохицуулах боломжийг хуулийн төслөөр бий болгоно

Түүнчлэн үндэслэлгүй бага үнэтэй тендерийг тодорхойлж, батлагдсан төсөвт өртөгтэй харьцуулан үнэлж, үндэслэлгүй бага үнэтэй тендерээс татгалзахыг хуулиар тодорхойлж зохицуулах боломж бүрдэнэ.

5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагаатай холбоотой маргааныг захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг. Сангийн яам 2019, 2020, 2021 онд тендерт оролцогчдоос нийт 2,939 гомдол хүлээн авч, шийдвэрлэсэн бол 2019, 2020 онуудад улсын төсвийн хөрөнгө

⁴ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 15-16 дахь тал.

оруулалтын санхүүжилттэй тендер шалгаруулалтад холбогдох нийт 68⁵ маргааныг шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн байна.

Дээрх тоон мэдээллээс үзэхэд урьдчилсан шийдвэрлэх ажиллагааны журмаар гомдлыг хянан шийдвэрлэх нь шүүхийн шатанд очих гомдол, нэхэмжлэлийг үнэмлэхүй хэмжээгээр бууруулж, маргааныг шуурхай шийдвэрлэх боломжийг хангасан байна.

Нөгөө талаас Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар худалдан авах ажиллагаатай холбогдох гомдлыг тусгай журмаар 30 хоногт шийдвэрлэх зохицуулалттай боловч нотлох баримт цуглуулах, хэргийн оролцогчдын эрх, үүргийг эдлүүлэх болон шүүхийн ачаалал их байдагтай холбоотойгоор ихэнх тохиолдолд шүүхээс хуульд заасан хугацаанд хэрэг хянан шийдвэрлэгдэхгүй байна.

Иймд тендер шалгаруулалтад холбогдох гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх болон шүүхийн шатанд хянан шийдвэрлэх харилцааг шуурхай, цахим системийн мэдээлэлд үндэслэн зохион байгуулах нарийвчилсан зохицуулалтыг хуульд тусгах шаардлага байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтад заасны дагуу шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр, дараах асуудлыг тусгахаар боловсруулна. Үүнд:

- Хуулийн зорилт, хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт;
- Тендер шалгаруулалтын арга, аргыг сонгох, урьдчилсан болон ерөнхий гэрээ байгуулах худалдан авах ажиллагаа, гадаадын этгээд оролцох тендер, тендерт оролцогчдод давуу эрх олгох харилцаа;
- Гэрээ байгуулах, гэрээний хэлбэр, нөхцөл, гэрээ хүчин төгөлдөр бус байх нөхцөл, урьдчилгаа төлбөрийн болон гүйцэтгэлийн баталгаатай холбоотой харилцаа;
- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, удирдлага, чиг үүрэг, худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн бүрэн эрх;
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, захиалагчийн эрх үүрэг, үнэлгээний хороо, түүний гишүүдийн эрх үүрэг, бүртгэлийн тогтолцоо, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах асуудал;
- Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбоотой асуудал;

⁵ Нийслэл, 21 аймгийн шүүхээс албан бичгээр ирүүлсэн тоо мэдээ.

- Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа;

- Хууль зөрчсөн албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудал.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн бий болно. Үүнд:

1.Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалт боловсронгуй болж, хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичигт заасан худалдан авах ажиллагааг ил тод болгох, цахим хэлбэрт шилжих, хүний оролцоог багасгах зорилтууд тодорхой түвшинд хангагдана;

2.Тендер шалгаруулалтын ажиллагаанд ил тод байдлыг нэмэгдүүлснээр тендерт оролцогчоос тавих хөндлөнгийн хяналт сайжирч, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхол хамгаалагдан, улмаар тендер шалгаруулах ажиллагаанд итгэх олон нийтийн итгэл нэмэгдэнэ;

3.Худалдан авах ажиллагааны цахим хэлбэрийг боловсронгуй болгосноор тендер шалгаруулалтад хууль тогтоомжийн дагуу төрийн бусад мэдээллийн сангаас лавлах боломжтой баримт бичгийг тендерт оролцогчоос гаргуулах шаардлагагүй болж худалдан авах ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуй нэгж төдийгүй төрийн байгууллагуудын цаг хугацааг хэмнэж улмаар зардал буурч, тендер шалгаруулалтад оролцоход хялбар, тендер шалгаруулалт шуурхай зохион байгуулагдах боломжтой болно.

4.Тендер шалгаруулалтын маргааныг шүүхээс хянан шийдвэрлэхтэй холбоотой өөрчлөлт оруулснаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа багасаж, хялбар, хурдан шуурхай болгох нөхцөл бүрдэнэ.

5.Гэрээний хэрэгжилтэд захиалагч хяналт тавихаас гадна олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгоно. Гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн мэдээлэлтэй танилцах гэрээний мэдээллийн сантай болж, гэрээний үүрэг биелүүлэх чадваргүй этгээдийг сонгон шалгаруулахаас урьдчилан сэргийлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

---oOo---

ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2000 онд баталснаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг анх хуульчлан зохицуулсан байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 2005 онд шинэчлэн найруулж баталснаар төсвийн хүрээнд хийгдэх худалдан авах ажиллагааг захиалагч бие даан зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналт хариуцлагыг бүрэн хүлээх төвлөрсөн бус тогтолцоонд шилжсэн байна.

2005 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар төрийн худалдан авах ажиллагааг харьцангуй шинэ шатанд гаргах эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч тус хуулийг баталснаас хойш өнөөдрийг хүртэл нийт 32 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Өнгөрсөн 16 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн байдал хурдацтай хөгжин өөрчлөгдөж, техник, технологийн дэвшлийг нийгмийн харилцаанд өргөнөөр ашиглах шаардлага үүссэн энэ үед худалдан авах ажиллагаа ч шинэ шатанд гарах шаардлагатай болсон. Хүний эрх, эрх зүйн суурь зарчимд тулгуурласан, өрсөлдөөн, ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн орчин үеийн хөгжлийн чиг хандлага болох хүний оролцоог бууруулсан худалдан авах ажиллагааг зохион байгуулахад чиглэгдсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгохыг цаг үе шаардаж байна. Түүнчлэн тус хуульд орсон нэмэлт, өөрчлөлт нь зарим талаар хуулийн үндсэн зарчим, үзэл баримтлалаас хазайсан, нөгөө талаар хуулийн зүйл, хэсэг, заалт хоорондоо агуулгын хувьд холилдсон нь хуулийн бүтцийн системчлэл алдагдахад хүргэсэн асуудал байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалт “худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах” гэж заасны дагуу Сангийн сайдын 2021 оны 110 дугаар тушаалаар тус хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг оруулан 26 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Сангийн яам Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж тус хуулийг шинэчлэн найруулах шаардлагыг тодорхойлж энэ дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг Сангийн сайд Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан.

Хуулийн төслийн үзэл баримтлалын зорилгод тодорхойлсноор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах үндсэн асуудлыг тусгасан:

1. Хүний оролцоог бууруулах:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт заасан тендер шалгаруулалтыг цахим хэлбэрт шилжүүлэх хүрээнд тендер шалгаруулалтыг бүрэн цахимаар зохион байгуулах, тендерт оролцогчийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны системээс ирүүлж буй мэдээлэлд үндэслэн үнэлэх, мэдээллийн технологи, цахим шилжилтийг дэмжих тендер шалгаруулалтын дэвшилтэд аргыг ашиглах талаар хуулийн төсөлд тусгасан. Монгол Улсын хэмжээнд зохион байгуулсан тендер шалгаруулалтын 2017 онд 27%, 2018 онд 89%, 2019 онд 98%, 2020, 2021 онд 99%-ийг цахим тендер шалгаруулалтаар зохион байгуулснаас харахад захиалагч, тендерт оролцогчид цахим тендер шалгаруулалт зохион байгуулж, цахимаар тендер илгээж хэвшсэн тул дээрх өөрчлөлт нь нийгэмд эерэг өөрчлөлт авчирна гэж үзэж байна. Дэлхийн банкнаас боловсруулсан 180 улсын нийтийн худалдан авах ажиллагааны зохицуулалтын системд үнэлгээ хийсэн 2017 оны тайланд худалдан авах ажиллагааны цахим системтэй 154 (85.5%) улс байгаагаас цахим системээр тендер хүлээн авдаг 56, цаас болон цахим шуудангаар хүлээн авдаг 123 улс байгааг тэмдэглэсэн байна.¹

2. Нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх:

Худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөх үе шатаас гэрээ дүгнэх хүртэл үе шатны мэдээллийг удирдах мэдээллийн нэгдсэн эх үүсвэрийг худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д төвлөрүүлэн, хөгжүүлэх эрх зүйн үндсийг бий болгосон. Түүнчлэн тендерт оролцогчоос өөрийн тендерийг нууцлан ирүүлэх боломжтой тендерийн материалын хязгаарыг хуульд тусгахын зэрэгцээ шалгарсан тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийг ил тод болгохоос татгалзах тохиолдолд үүсэх эрх зүйн үр дагаврыг хуульд мөн тусгалаа.

3. Шуурхай, хялбар тендер шалгаруулалт:

Мэдээллийн технологи, интернэтэд суурилсан тендер шалгаруулалтын аргуудыг шинээр хуулийн төсөлд тусгасан нь тендер шалгаруулалтыг аль болох богино хугацаанд зохион байгуулах боломж бүрдэнэ гэж үзэж байна. Худалдан авах ажиллагааны бүх үе шатыг цахим системд бүртгэж байгаа нь тендер шалгаруулалтын мэдээлэлтэй тендерт оролцогч цаг алдалгүй танилцах боломжтой тул сонирхсон тендерт эртнээс бэлдэх, орон зайн хязгаараас үл хамааран тендер илгээх боломжтой байхын зэрэгцээ төрийн мэдээллийн санд байгаа мэдээллийг харилцан солилцож, тендер шалгаруулалтын хянан үзэх шатны үнэлгээг цахим системээр хийх боломж бүрдэж шуурхай, хялбар тендер шалгаруулалт зохион байгуулах суурь нөхцөл болсон гэж үзэж байна.

Түүнчлэн худалдан авах ажиллагааны бүх үе шатуудад тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн орчныг хуульд тусгаж өгснөөр тендер шалгаруулалтад

¹ The World Bank (2016). Benchmarking Public Procurement 2017: Assessing Public Procurement Regulatory Systems in 180 Economies.

оролцогч талууд цахимаар мэдээлэл солилцох, харилцах боломжийг бүрдүүлсэн.

4. Хариуцлагын тогтолцоог шинэчлэх:

Худалдан авах ажиллагааны гэрээний мэдээллийн сан бүрдүүлж тендерт оролцогчийн гэрээний үүргийн биелэлтийг бүртгэж, уг мэдээллийн санд үндэслэн тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг хянан үзэхийн зэрэгцээ хариуцлага ногдуулах бодит мэдээллийн эх сурвалжийг үүсгэхээр тусгасан.

Түүнчлэн захиалагч, түүний албан тушаалтны хууль зөрчсөн үйлдэлд ногдуулах хариуцлагыг тодорхой болгосны хамт олон нийтээс худалдан авах ажиллагаанд хяналт тавих механизм болох шүгэл үлээх боломжийг цахим системд бүрдүүлсэн. Ингэснээр худалдан авах ажиллагааны бүх шатанд захиалагч, гүйцэтгэгчийн гэрээний биелэлтийг олон нийтээс давхар хянах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Батлагдсан хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулан төрийн байгууллага, олон нийтээс санал авах, хуулийн төслийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, зардал тооцооны судалгааг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Сангийн яам хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг төрийн болон орон нутгийн байгууллагууд, худалдан авах ажиллагааны сургагч багш нарын нийт 935 төлөөлөлд 2021 оны 10 дугаар сарын 12-аас 14-ний өдрийн хугацаанд, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран тендерт оролцогч иргэн, аж ахуйн нэгжийн танхимаар ирсэн 214, цахимаар оролцсон 186 нийт 400 төлөөллийн дунд 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр, “Монголын авто замчдын холбоо” ТББ, Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн “Эм холбоо” ТББ, “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ, “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо” ТББ, “Металл боловсруулалт инженерчлэлийн холбоо” ТББ-тай тус тус хамтран 2021 оны 11 дүгээр сарын 15-аас 23-ны өдрийн хугацаанд тухайн салбарын аж ахуйн нэгж байгууллага, мэргэжилтнүүдийн 100 гаруй төлөөллийг хамруулан тус тус зохион байгуулсан.

Түүнчлэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран “Монголын сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо” ТББ, “Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоо” ТББ, “Монголын гэр, гэрийн иж бүрдэл үйлдвэрлэгчийн нэгдсэн холбоо” ТББ, “Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл” ТББ, Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм холбоо” ТББ, “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо” ТББ, “Монголын бизнес инкубаторуудын үндэсний нэгдсэн холбоо” ТББ, “Шинэгантиг” ХХК, “Долоонболдог” ХХК, “Гантесла” ХХК, “Чиглэл” ХХК зэрэг 26 төрийн бус байгууллагын 33 төлөөллийг оролцуулан 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан аж ахуйн нэгж, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэгт мөн хэлэлцүүлсэн.

Хуулийн төсөлд олон нийтээс санал авахаар Сангийн яамны цахим хуудас (www.mof.gov.mn), Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-

д 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс нийтэлж санал авсан. Олон нийтээс ирсэн саналын дагуу саналын товъёгийг дээр дурдсан цахим хуудас, цахим системд нийтэлсэн.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн захиргааны байгууллагаас Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 6-1/5936, 2022 оны 09 дүгээр сарын 19-ний 01/6390 тоот албан бичгээр хоёр удаа санал авахад нийт 545 санал, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоос хуулийн төсөлтэй холбогдуулан 329 санал ирүүлснээс холбогдох саналыг хуулийн төсөлд тусгасан.

Төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоос өгсөн холбогдох саналыг тусган Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах хуулийн төслийг тус тус боловсруулсан байна.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, гэрээ байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн
хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан
авах тухай хууль тогтоомж**

2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

3.2.Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг дагаж мөрдөнө.

3.3.Энэ хууль бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой дараах харилцааг зохицуулахад хамаарахгүй:

3.3.1.хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авах ажиллагаа;

3.3.2.Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд тусгайлан заасан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой үнэт цаас, валют худалдан авах, мөнгөн тэмдэгт хэвлүүлэх, хадгалуулах, тээвэрлэх, гадаад валютын улсын нөөцийг бүрдүүлэхтэй холбогдуулан гадаад валют, алт худалдан авах, цэвэршүүлэх,

тээвэрлэх, банкны хяналт, шалгалтын хүрээнд зөвлөх үйлчилгээ авах, үндэсний төлбөрийн системийн программ хангамж, түүний тоног төхөөрөмж, эрдэнэсийн нөөц санг бүрдүүлэхэд хамаарах худалдан авах ажиллагаа;

3.3.3.Засгийн газар, төрийн өмчит эсхүл төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах ажиллагаа;

3.3.4.Сонгуулийн ерөнхий хороо болон аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн хороо батлагдсан төсвийн хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурал, түүнчлэн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зохион байгуулах, сонгуулийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл, сонгогчийн бүртгэлийн техник хэрэгсэл, программ хангамж болон харилцаа холбооны үйлчилгээ худалдан авах ажиллагаа;

3.3.5.Монгол Улсын хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газрын хэрэгцээнд гадаад улсад худалдан авах ажиллагаа;

3.3.6.Засгийн газраас Монгол Улсыг гадаад улсад сурталчлах, гадаад улсаас соёлын биет өв болон түүний хуулбарыг өмчлөгчтэй тохиролцон худалдан авах ажиллагаа.

3.4.Энэ хуулийн 3.3.1-д заасан төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журмыг тагнуулын байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“ажил” гэж барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг барих, засварлах, өргөтгөх, шинэчлэх, геологийн судалгаа хийх болон тэдгээрт холбогдох тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, турших, тохируулах зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг болон түүнийг дагалдан нийлүүлэх барааг;

4.1.2.“аж ахуй эрхлэгч” гэж хуулийн этгээд, хүнийг;

4.1.3.“ашиглалтын хугацааны өртөг” гэж харьцуулах үнэ дээр ашиглалтын хугацаанд гарах зардлыг харгалзан тооцсон тоон утгыг;

4.1.4.“бараа” гэж эдийн засгийн ач холбогдол, үнэ бүхий худалдах, солилцох, түрээслэх боломжтой эд юмс, бэлэн шийдэл бүхий биет бус хөрөнгө болон тухайн барааг дагалдан үзүүлэх ажил, үйлчилгээг;

4.1.5.“бэлэн шийдэл” гэж зах зээлд бэлэн байгаа бөгөөд өөрчлөлт оруулахгүйгээр захиалагчийн хэрэгцээ шаардлагыг хангах боломжтой шийдлийг;

4.1.6.“гадаадын этгээд” гэж гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд, гадаадын иргэн, эсхүл харьяалалгүй хүнийг;

4.1.7.“дотоодын бараа” гэж Монгол Улсад олборлосон, ургуулсан, бойжуулсан, үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, түүний үндсэн шинж чанар, зориулалт, ашиглалтын хэлбэрийг өөрчилж шинээр бүтээсэн барааг;

4.1.8.“ерөнхий гэрээний арга” гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг;

4.1.9.“захиалагч” гэж:

4.1.9.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

4.1.9.2.50 ба түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;

4.1.9.3.Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасан төсөл хэрэгжүүлэгч;

4.1.9.4.худалдан авах ажиллагааг энэ хуулийн дагуу зохион байгуулахаар хуульд заасан бусад этгээд.

4.1.10.“захиалагчаас хараат этгээд” гэж дараах нөхцөлийн аль нэгд хамаарах этгээдийг:

4.1.10.1.тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын бүрэлдэхүүнийг захиалагч томилж, чөлөөлдөг;

4.1.10.2.захиалагч нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлдог, эсхүл тодорхойлоход оролцдог.

4.1.11.“зарлал” гэж тендер шалгаруулалт явуулах тухай цахим систем дэх мэдээллийг;

4.1.12.“оролцогч” гэж энэ хуулийн 6.1-д зааснаар тендер ирүүлсэн аж ахуй эрхлэгчийг;

4.1.13.“өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ” гэж захиалагчийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээг;

4.1.14.“сонирхогч этгээд” гэж тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар оролцох сонирхлоо илэрхийлсэн, эсхүл энэ хуульд заасан урилга хүлээн авсан аж ахуй эрхлэгчийг;

4.1.15.“тендер” гэж бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, эсхүл үйлчилгээ үзүүлэхээр оролцогчийн ирүүлсэн саналыг;

4.1.16.“тендер шалгаруулалт” гэж энэ хуульд заасан журмын дагуу зарлал нийтлэх, урилга хүргүүлэх, тендер хүлээн авах, нээх, хянан үзэх, үнэлэх, захиалагч шийдвэр гаргах үйл ажиллагааг;

4.1.17.“тендер шалгаруулалтын баримт бичиг” гэж захиалагчаас тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлага, аргачлалыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.18.“техникийн тодорхойлолт” гэж худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавигдах технологийн шаардлага, даалгаврыг тодорхойлсон бүрдүүлбэрийг;

4.1.19.“түншлэл” гэж гэрээний дагуу нэг тендер ирүүлсэн хэд хэдэн аж ахуй эрхлэгчийг;

4.1.20.“үйлчилгээ” гэж энэ зүйлийн 4.1.1-д заасан ажил гүйцэтгэхэд хамаарахгүй угсралт, суурилуулалт, туршилт, тохируулгын, эсхүл тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйл ажиллагааг;

4.1.21.“урилга” гэж захиалагчаас аж ахуй эрхлэгчийг тендер шалгаруулалтад оролцохыг урьсан баримт бичгийг;

4.1.22.“харьцуулах үнэ” гэж энэ хуульд заасны дагуу шаардлагад нийцсэн тендерийг эрэмбэлэх зорилготой тоон утгыг;

4.1.23.“худалдан авах ажиллагаа” гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг;

4.1.24.“цахим дэлгүүр” гэж ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан цахим системийн бүрэлдэхүүнийг;

4.1.25.“цахим каталог” гэж бараа, ажил, үйлчилгээний мэдээллийг ангилж тодорхойлсон цахим системийн бүрэлдэхүүнийг;

4.1.26.“цахим систем” гэж программ хангамж ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, интернэтэд суурилсан мэдээллийн системийг.

5 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааны зарчим

5.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

6 дугаар зүйл.Оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч

6.1.Тендер шалгаруулалтад аж ахуй эрхлэгч дангаараа эсхүл түншлэлээр тендер ирүүлж болно.

6.2.Түншлэлийн гишүүн бүрийн гүйцэтгэх үүрэг тендерийн үнийн 20 хувиас дээш байна.

6.3.Түншлэлийн гишүүд дараах шаардлага хангасан гэрээний үндсэн дээр тендер ирүүлнэ:

6.3.1.гэрээний үүрэг гүйцэтгэхэд бүх гишүүний хамтран болон тус бүр хүлээх үүрэг, хариуцлагыг заасан байх;

6.3.2.худалдан авах ажиллагаанд түншлэлийг төлөөлөн оролцох, гэрээний хэрэгжилтийг захиалагч болон бусад этгээдийн өмнө хариуцах эрх бүхий нэг гишүүнийг томилсон байх.

6.4.Оролцогч тендерийн үнийн 20 хүртэл хувийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэхээр санал ирүүлж болно.

7 дугаар зүйл.Оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах

7.1.Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ:

7.1.1.төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах шийдвэр гарсан, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа¹ эхэлсэн, бизнесийн үйл ажиллагааг зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;

7.1.2.Монгол Улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй;

7.1.3.Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн;

7.1.4.тухайн тендер шалгаруулалтад оролцохдоо бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцсон;

7.1.5.энэ хуулийн 4.1.10-т заасан этгээд;

7.1.6.дараах этгээдийн аль нэг нь авлигын, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон:

7.1.6.1.оролцогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд;

7.1.6.2.оролцогчийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан эцсийн өмчлөгч;

7.1.6.3.оролцогчийн Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан.

7.1.7.тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахад зөвлөгөө өгсөн, оролцсон, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, оролцсон этгээдтэй харилцан хамааралтай;

¹ Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтад ““төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа” гэж төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, хуваарилагдах хөрөнгийг худалдах, хуваарилах, үүрэг гүйцэтгэгчийг татан буулгах, дахин зохион байгуулах ажиллагааг,” гэж заасныг.

7.1.8.тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй;

7.1.9.энэ хуулийн 56.5.3-56.5.5-д заасан үндэслэлээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд.

7.2.Оролцогч энэ зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг бичгээр гаргана.

7.3.Энэ зүйлийн 7.1-д заасан нөхцөлийг магадлахтай холбоотой баримт бичиг ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бол оролцогч Монгол Улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргуулан ирүүлнэ.

7.4.Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх бөгөөд холбогдох мэдэгдэл, баримт бичгийг энэ зүйлийн 7.2, 7.3-т зааснаар ирүүлнэ.

8 дугаар зүйл.Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, давуу эрх тооцох

8.1.Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрээс худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

8.2.Энэ зүйлийн 8.1-д заасан барааны нэр, төрлийн жагсаалтыг эдийн засаг, хөгжлийн болон хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, Засгийн газар батална.

8.3.Захиалагч ажлын хувьд 30 тэрбум, барааны хувьд нэг тэрбум, үйлчилгээний хувьд 300 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно.

8.4.Оролцогч энэ зүйлийн 8.2-т зааснаас бусад дараах нөхцөлийн аль нэгийг хангасан дотоодын бараа санал болговол давуу эрх олгоно:

8.4.1.хог хаягдлыг дахин боловсруулсан;

8.4.2.хэрэглээний хог хаягдлыг дахин ашиглах эсхүл боловсруулахаар эргүүлэн авах санал ирүүлсэн;

8.4.3.нийслэл, дүүрэг болон улсын зэрэглэлтэй хотод хамаарахгүй орон нутагт үйлдвэрлэсэн түүхий эд, бараа, материалыг ашиглан үйлдвэрлэсэн;

8.4.4.Инновацийн тухай хуулийн 3.1.4-т заасан инновацийн бүтээгдэхүүн;

8.4.5.ажиллах хүчний 30 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлдэг, 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуй эрхлэгч үйлдвэрлэсэн.

8.5.Оролцогч ажил гүйцэтгэхэд дотоодын бараа ашиглахаар санал болговол давуу эрх олгоно.

8.6.Энэ зүйлийн 8.4, 8.5-д зааснаар давуу эрх олгоход дотоодын барааны хэсгийн үнийн 10 хувиар, энэ зүйлийн 8.4-т заасан оролцогч нь Жижиг, дунд

үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч бол дотоодын барааны хэсгийн үнийн 15 хувиар тендерийн үнээс хийсвэрээр бууруулж тооцно.

8.7.Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтад дараах давуу эрхийн аль нэгийг олгож, тендерийн үнийг хийсвэрээр бууруулж тооцно:

8.7.1.нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотод хамаарахгүй орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зарласан тендер шалгаруулалтын оролцогч сүүлийн хоёроос доошгүй жилийн хугацаанд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж, ажлын байр бий болгосон бол түүний тендерийн үнийн дотоодын бараанаас бусад хэсгийн үнийн таван хувиар;

8.7.2.эцсийн өмчлөгч нь Монгол Улсын иргэн байх оролцогч энэ зүйлийн 8.3-т зааснаас дээш төсөвт өртөгтэй ажлыг дангаар гүйцэтгэхээр, эсхүл гэрээний үүргийн 50-аас доошгүй хувийг гүйцэтгэж энэ хуулийн 6.3.2-т заасан эрх эдлэх түншлэлийн гишүүний хувиар гүйцэтгэхээр санал ирүүлсэн бол тендерийн үнийн дотоодын бараанаас бусад хэсгийн үнийн 7.5 хувиар.

8.8.Энэ зүйлийн 8.1-д заасан бараа худалдан авах болон бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авахад давуу эрх олгохгүй.

8.9.Энэ хуульд зааснаар давуу эрх тооцоход шаардлагатай мэдээлэл, нотлох баримтыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

9 дүгээр зүйл.Худалдан авах ажиллагааны цахим систем

9.1.Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

9.2.Цахим системд мэдээллийг нээлттэй өгөгдөл хэлбэрээр хадгална.

9.3.Худалдан авах ажиллагаанд холбогдох баримт бичгийг Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсгээр баталгаажуулж, энэ хуульд зааснаар цахим системээр илгээсэн бол бичгээр үйлдсэнд тооцно.

9.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмыг баталж, цахим системээр тендер илгээхэд төлөх үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтооно.

9.5.Цахим системийн үйл ажиллагаанаас шалтгаалан тендер шалгаруулалт тасалдсан эсхүл тасалдах нөхцөл байдал байгаа гэж үзсэн бол худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ тухай захиалагчид мэдэгдэж, тендер шалгаруулалтад холбогдох хугацааг сунгана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

10 дугаар зүйл.Тендер шалгаруулалтын зохион байгуулалт

10.1.Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргад үндэслэн зохион байгуулна.

10.2.Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.

10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

10.4.Бараа худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулахад энэ хуулийн 8.2-т заасан барааг бусад бараанаас тусад нь багцална.

10.5.Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно.

10.6.Оролцогч тендер шалгаруулалтын хэдэн багцад тендер ирүүлэхийг захиалагч хязгаарлахгүй.

10.7.Энэ хуулийн 4.1.8-д заасан ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар батална.

10.8.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, хил хамгаалах, онцгой байдлын байгууллага, цагдаа, дотоодын цэрэг, хорих байгууллагын тусгай хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх, эсхүл хорих байгууллагын өөрийн хэрэгцээний ажлыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгүүлэх нь үр ашигтай гэж захиалагч үзсэн бол нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхгүй байж болно.

10.9.Захиалагч энэ хуулийн 12.7-д заасан тусгайлсан шаардлагын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сургах, нийгмийн амьдралд оролцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээр гэрээний үүрэг гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно.

10.10.Засгийн газрын бодлого, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт болон цаг үеийн шинжтэй мэдээллийг яаралтай олон нийтэд хүргэх, мэдээлэхэд шаардлагатай хэвлэл мэдээллийн үйлчилгээ, Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой үндэсний үнэт зүйл, соёлын өвийг таниулсан соёл, урлагийн арга хэмжээ, тоглолт, урлагийн бүтээлийг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхгүй байж болно.

10.11.Энэ хуулийн 31.2-т өөрөөр заагаагүй бол захиалагч байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээний нэгж үнэ болон бусад нөхцөлийг гурав хүртэл жилийн хугацаанд тогтоох нөхцөлтэй тендер шалгаруулалт зохион байгуулж болно.

10.12.Энэ зүйлийн 10.2, энэ хуулийн 34.1-д заасан төсөвт өргийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно.

10.13.Хэрэглээний үнийн индекс 10-аас дээш хувиар өөрчлөгдөх тухай бүр энэ зүйлийн 10.12-т заасан төсөвт өргийн дээд хязгаарыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шинэчлэн тогтооно.

11 дүгээр зүйл.Тендер шалгаруулалтын баримт бичиг

11.1.Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.

11.2.Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.

11.3.Энэ хуулийн 8.3-т зааснаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг монгол хэлээс гадна олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэлээр бэлтгэж болно.

11.4.Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх доор дурдсан үндсэн шалгуурын аль нэгийг сонгон тендер шалгаруулалтын баримт бичигт заана:

11.4.1.харьцуулах үнэ;

11.4.2.ашиглалтын хугацааны өртөг.

11.5.Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний онцлогийг харгалзан дараах шалгуур үзүүлэлтээс аль тохирохыг мөнгөөр илэрхийлэн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж тооцохоор тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно:

11.5.1.бараа хүргэх, ажил, үйлчилгээ дуусгах хугацаа;

11.5.2.гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээ;

11.5.3.байгаль орчинд нөлөөлөх байдал;

11.5.4.энэ хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт.

11.6.Энэ зүйлийн 11.5-д заасан шалгуур үзүүлэлт нь зөвхөн санал болгох бараа, ажил, үйлчилгээнд хамаарна.

11.7.Бараа, ажил, үйлчилгээний үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

11.8.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хэрэгцээ, шаардлагыг хангахуйц хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрөх бол энэ тухай тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

11.9.Захиалагч гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгчээс үл хамаарах шалтгаанаар бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гэрээний үнийг

тохируулах бол тохируулга хийх нөхцөл, аргачлалыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

11.10.Тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулсан тухай бүр цахим системийн холбогдох хэсэгт өөрчлөлтийг тусгана.

11.11.Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг тус хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

11.12.Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгах гэрээний жишиг нөхцөлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12 дугаар зүйл. Техникийн тодорхойлолт

12.1.Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.

12.2.Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

12.3.Техникийн тодорхойлолтод хүний эрүүл мэнд, байгаль орчин, уур амьсгалд нөлөөлөх нөлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх шалгуур үзүүлэлтийг тусгаж болно.

12.4.Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно.

12.5.Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ зүйлийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох ба энэ тохиолдолд “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.

12.6.Барилга байгууламж, дэд бүтэцтэй холбогдох техникийн тодорхойлолтод хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүн, түгээмэл загварыг тусгана.

12.7.Барааг үйлдвэрлэх, нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх явцад баримтлах тусгайлсан шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгаж болно.

12.8.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт бэлтгэхэд өрсөлдөөнийг хязгаарлахгүй зөвлөгөөг тухайн салбарын иргэний нийгмийн байгууллага, аж ахуй эрхлэгчээс авч болно.

12.9.Техникийн тодорхойлолтыг хүрээлэн буй орчинд ээлтэй хэлбэрээр боловсруулах аргачлал, зааврыг байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

13 дугаар зүйл. Техникийн тодорхойлолтод нийцэхийг нотлох баримт, загвар, дээж

13.1.Захиалагч оролцогчоос бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолтод нийцэх эсхүл гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах эсэхийг тогтоох шалгалт, туршилтыг эрх бүхий бие даасан этгээдээр хийлгэсэн нотлох баримт, эсхүл холбогдох мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

13.2.Захиалагч шаардлагатай гэж үзвэл энэ зүйлийн 13.1-д заасан шалгалт, туршилтыг өөрөө зохион байгуулж болно.

13.3.Энэ зүйлийн 13.2-т заасан тохиолдолд шалгалт, туршилтыг хэрхэн зохион байгуулах тухай тендер шалгаруулалтын баримт бичигт зааж, оролцогчийг уг ажиллагаанд оролцох боломжоор хангана.

13.4.Захиалагч хүлээн авсан загвар, дээжийг шалгах, турших үйл явцыг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хадгална.

13.5.Гэрээ байгуулах эрх авсан оролцогчоос бусад оролцогчийн ирүүлсэн загвар, дээжээс хэрэглэх боломжтой барааг тендер шалгаруулалтын эцсийн шийдвэр гарснаас хойш оролцогчдод буцаан олгоно.

13.6.Гэрээ байгуулах эрх авсан оролцогчийн ирүүлсэн загвар, дээжээс хэрэглэх боломжтой барааг гэрээгээр ажил хүлээлцэх үед буцаан олгох эсхүл гэрээний үүргийн гүйцэтгэлд оролцуулан тооцож болно.

14 дүгээр зүйл. Тендерийн баталгаа

14.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч дараах тохиолдолд тендерийн баталгаа ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана:

14.1.1.багцгүй тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол;

14.1.2.багцтай тендер шалгаруулалтын тухайн багцын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол.

14.2.Захиалагч тендерийн баталгааг төсөвт өртгийн 0.5 хувиар тогтооно.

14.3.Оролцогч тендерийн баталгааг банкны, эсхүл Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны баталгаагаар, эсхүл Монгол Улсын даатгагчаас гаргасан баталгаагаар гаргана.

14.4.Тендерийн баталгааны дүнг гадаад валютаар илэрхийлсэн тохиолдолд баталгааг хөрвүүлэх ханшийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Төв банк /Монголбанк/-ны албан ханшаар тодорхойлно.

14.5.Гадаадын этгээд гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан журмын дагуу тендерийн баталгааг хүргүүлнэ.

14.6.Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол захиалагч тендерийн баталгааг улсын орлого болгоно:

14.6.1.оролцогч тендерийг нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсан;

14.6.2.гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй,

14.6.3.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

14.7.Энэ зүйлийн 14.6.3-т заасан тохиолдолд 20 тэрбум төгрөг хүртэлх төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 20 хүртэл сая төгрөгийг, 20-100 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 40 сая төгрөгийг, 100 тэрбумаас дээш төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 60 сая төгрөгийг тус тус улсын орлого болгоно.

14.8.Тендерийн баталгаа гэрээ байгуулах хүртэл эсхүл тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хугацаанд хүчинтэй байна.

15 дугаар зүйл. Чадавхын болон туршлагын шаардлага тавих үндэслэл

15.1.Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

15.2.Цахим системээр дамжуулан шалгах боломжтой, түүнчлэн хууль тогтоомжид зааснаар эрх бүхий байгууллагаас хөтөлж, бүрдүүлсэн мэдээллийн санд байгаа олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй.

15.3.Энэ зүйлийн 15.2 дахь хэсэг гадаадын этгээдийн гадаад улсаас бүрдүүлэх баримт бичигт хамаарахгүй.

15.4.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч гэрээний үүргийн гүйцэтгэлд үл хамаарах шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт заахыг хориглоно.

15.5.Гэрээний үүргийг гүйцэтгэхэд хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл эсхүл гэрчилгээ шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

15.6.Захиалагч оролцогчийн хэрэгжүүлж байгаа гэрээний талаарх мэдээлэл ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно.

16 дугаар зүйл. Санхүүгийн чадавхын шаардлага

16.1.Захиалагч санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно.

16.2.Оролцогч санхүүгийн чадавхыг дараах баримт бичгээр нотолж болно:

16.2.1.харилцагч банкны мэдэгдэл;

16.2.2.сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан;

16.2.3.сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.

16.3.Захиалагч энэ зүйлийн 16.2-т заасан баримт бичгийн аль шаардлагатайг ирүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

16.4.Хуулийн дагуу санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчоос санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шаардаж болно.

16.5.Оролцогч захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг хангасан байна.

16.6.Түншлэлийн гишүүн тус бүрийн болон хамтдаа хангавал зохих санхүүгийн чадавхын доод шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

17 дугаар зүйл.Техникийн чадавх болон туршлагын шаардлага

17.1.Захиалагч техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно.

17.2.Техникийн чадавх, туршлагын талаарх мэдээллийг дараах баримт бичгээр нотолж болно:

17.2.1.ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;

17.2.2.бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;

17.2.3.гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл;

17.2.4.гэрээний үүргийг гүйцэтгэхтэй холбоотой машин механизм, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн байрны мэдээлэл;

17.2.5.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан нотлох баримт, дээж.

17.3.Захиалагч энэ зүйлийн 17.2-т зааснаас аль шаардлагатайг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

17.4.Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

17.5.Түншлэлийн гишүүн тус бүрийн болон хамтдаа хангавал зохих техникийн чадавх, туршлагын доод шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

17.6.Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхээр гэрээнд заасан үүргийг гүйцэтгэхэд энэ хуулийн 15.5-д зааснаар зөвшөөрөл эсхүл гэрчилгээ шаардах бол туслан гүйцэтгэгч энэ шаардлагыг хангасан байна.

18 дугаар зүйл.Тендер шалгаруулалтын зарлал

18.1.Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана.

18.2.Энэ хуулийн 11.3-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын зарлалыг цахим системээс гадна гадаад улсын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудаст нийтэлж болно.

18.3.Тендер шалгаруулалтын зарлалд дараах мэдээллийг тусгана:

- 18.3.1.захиалагчийн нэр, хаяг;
- 18.3.2.тендер шалгаруулалтын нэр, дугаар, төсөвт өртөг;
- 18.3.3.тендер шалгаруулалтын арга;
- 18.3.4.тендер хүлээн авах эцсийн хугацаа;
- 18.3.5.тендер нээх хугацаа;
- 18.3.6.тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх;
- 18.3.7.гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх;
- 18.3.8.тендерийн баталгаа шаардах эсэх;
- 18.3.9.тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол багцын мэдээлэл.

19 дүгээр зүйл.Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

19.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлтийг захиалагчид тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр гаргаж болно.

19.2.Захиалагч тодруулга авах хүсэлт хүлээн авснаас хойш тодруулгыг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө бичгээр гаргана.

19.3.Тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

19.4.Захиалагч тендер ирүүлэхийн өмнө сонирхогч этгээд, түүний төлөөлөлтэй тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол энэ тухай тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

20 дугаар зүйл.Тендер хүлээн авах хугацаа

20.1.Захиалагч сонирхогч этгээдэд тендер бэлтгэж ирүүлэх ижил хугацаа олгож, тендер хүлээн авах эцсийн хугацааг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт тусгайлан зааснаас багагүй хугацаагаар тогтооно.

20.2.Тендер бэлтгэх зорилгоор ажлын талбайтай танилцах шаардлагатай бол түүнд шаардагдах хугацааг энэ зүйлийн 20.1-д заасан хугацаанд оруулан тооцно.

20.3.Тендер хүлээн авах эцсийн хугацааг зарлал нийтэлсэн өдрөөс эхлэн тоолно.

20.4.Оролцогч тендерийг энэ зүйлийн 20.1-д заасан хугацааны дотор ирүүлэх ба уг хугацаанаас өмнө тендерийг өөрчлөх эсхүл буцаах эрхтэй.

20.5.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендерийг өөрчлөх, эсхүл буцаахыг хориглоно.

20.6.Захиалагч тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж, цахим системд нийтэлсэн бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

20.7.Энэ зүйлийн 20.6-д заасан тендер нээх хугацаа тухайн нэмэлт, өөрчлөлтийг цахим системд нийтэлсэн өдрөөс хойш ажлын таваас дээш өдөр бол тендер нээх хугацааг сунгахгүй байж болно.

21 дүгээр зүйл.Тендер бэлтгэх

21.1.Сонирхогч этгээд болон оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт нийцүүлэн техникийн болон үнийн саналыг бэлтгэх ба тендер нь дараах шаардлагыг хангасан байна:

21.1.1.тендерийн хүчинтэй байх хугацаа тендер нээснээс хойш ажлын 30-аас доошгүй өдөр байхаар заах;

21.1.2.тендерийг хянан үзэх, үнэлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээллийг эрх бүхий байгууллагаас гаргуулах, холбогдох этгээдээс лавлагаа, тодорхойлолт авахыг зөвшөөрсөн байх;

21.1.3.тендер шалгаруулалтын баримт бичигт заасан мэдээллийг цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээх.

21.2.Сонирхогч этгээд болон оролцогч тендер бэлтгэх, илгээх, тендер шалгаруулалтад оролцохтой холбогдох зардлыг бүрэн хариуцна.

21.3.Энэ зүйлийн 21.1.3-т зааснаар илгээсэн мэдээлэл тендерийн бусад баримт бичигтэй зөрсөн бол цахим системийн мэдээллийг баримтална.

21.4.Хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрсөн бол хувилбарт саналыг үндсэн тендерийн хамт ирүүлж болно.

21.5.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын оролцогч тендерийн үнийг төсөвт өртгийн 80 хувиас доош үнэ санал болгох бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22 дугаар зүйл.Тендер илгээх

22.1.Хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулж, цахим системээр илгээнэ.

22.2.Оролцогч тендер шалгаруулалтад нэг тендер ирүүлнэ.

22.3.Энэ хуулийн 11.8, 21.4-т зааснаар тендерийг хувилбарт саналтайгаар ирүүлсэн нь энэ зүйлийн 22.2-т заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

22.4.Энэ хуулийн 8.3-т заасан тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд Монгол Улсад тоон гарын үсгийн гэрчилгээгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу гадаад улсын тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглаж болно.

22.5.Оролцогч хуульд заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг нууцалж, бусад хэсгийг ил болгохоор илгээнэ.

22.6.Оролцогч тендерийн дараах баримт бичиг, мэдээллийг ил болгохыг зөвшөөрч илгээнэ:

22.6.1.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага хангасныг нотлох баримт бичиг;

22.6.2.тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл;

22.6.3.энэ зүйлийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл;

22.6.4.тендер шалгаруулалтын баримт бичигт ил болгохоор заасан бусад баримт бичиг.

22.7.Оролцогч тендерийн баталгааг цахим системээр дамжуулан хүргүүлж, тендер илгээнэ.

22.8.Энэ хуулийн 54.6-д зааснаар цахим системд баталгаажуулж, бүртгэсэн туршлага, гэрээний үүргийн гүйцэтгэлийн мэдээллийг сонгон илгээх ба тухайн мэдээллийг нотлох баримт илгээх шаардлагагүй.

22.9.Захиалагч шалгалт, туршилт зохион байгуулах тохиолдолд оролцогч өөрийн санал болгож байгаа бараа, ажил, үйлчилгээнд холбогдох загвар, дээжийг тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хүргүүлнэ.

22.10.Оролцогч цахим системээр тендер илгээхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон үйлчилгээний хураамжийг төлнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

23 дугаар зүйл.Тендер нээх

23.1.Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш нэг цагийн дотор тендерийг нээнэ.

23.2.Тендерийг нээж, дараах мэдээллийг цахим системээр зарлана:

23.2.1.оролцогчийн нэр;

23.2.2.тендерийн үнэ;

23.2.3.санал болгосон үнийн хөнгөлөлт;

23.2.4.хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ;

23.2.5.тендерийн баталгаа шаардсан тендер шалгаруулалтад тендерийн баталгаа ирүүлсэн эсэх.

23.3.Тендерийн баталгаа шаардсан нөхцөлд түүнийг энэ хуулийн 22.7-д зааснаар ирүүлээгүй нь тендер нээхээс татгалзах үндэслэл болно.

24 дүгээр зүйл.Захиалагч шийдвэр гаргах хугацаа

24.1.Захиалагч тендер нээсэн даруй тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлж, энэ хуулийн 28.1-д заасан шийдвэрийн аль нэгийг тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор гаргана.

24.2.Захиалагч энэ хуулийн 35.1-д заасан үндэслэлээр гэрээ байгуулах бол энэ хуулийн 28.1-д заасан шийдвэрийн аль нэгийг тендер нээснээс хойш ажлын таван өдрийн дотор гаргана.

24.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 59.10-т заасан шийдвэр гаргасан, эсхүл гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас шалтгаалан захиалагч энэ зүйлийн 24.1-д заасан хугацааг ажлын 15 хүртэл өдрөөр нэг удаа сунгаж болно.

24.4.Захиалагч энэ зүйлийн 24.1-д заасан хугацаанд шийдвэр гаргаагүй бол тухайн төсвийн жилд тухайн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа дахин зохион байгуулахыг хориглоно.

24.5.Тендер шалгаруулалтад нэг ч тендер ирээгүй бол захиалагч тендер ирээгүй шалтгааныг судалж, худалдан авах ажиллагаа дахин зохион байгуулах эсэхийг шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл.Тендерийн талаар тодруулга авах

25.1.Захиалагч тендерийн тодорхойгүй эсхүл зөрчилдөөнтэй асуудлаар тодруулга авах нь бусад оролцогчийн өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөхгүй бол оролцогчоос бичгээр тодруулга авах хүсэлт хүргүүлэх ба хүсэлтэд хариу ирүүлэх хугацааг заана.

25.2.Захиалагч энэ зүйлийн 25.1-д заасан мэдээллийг холбогдох бусад этгээдээс цахим систем, цахим шуудангаар эсхүл албан бичгээр тодруулж болно.

25.3.Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэх зорилгоор нэмэлт баримт бичиг, загвар, дээж ирүүлэхийг шаардахгүй.

25.4.Захиалагч энэ хуулийн 27.3-т заасан арифметик алдааг залруулснаас бусад тохиолдолд тендерийн үнэ, үнийн хөнгөлөлтийн талаар тодруулга авах хүсэлт гаргахгүй.

25.5.Тендерийн талаар тодруулга авах захиалагчийн хүсэлтэд заасан хугацааны дотор оролцогч хариу ирүүлээгүй нь хянан үзэх, үнэлэх ажиллагааг хойшлуулах үндэслэл болохгүй.

25.6.Энэ зүйлийн 25.1, 25.2-т заасан захиалагчийн хүсэлт, түүний хариуг тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хадгална.

26 дугаар зүйл.Тендер хянан үзэх

26.1.Захиалагч оролцогчоос ирүүлсэн тендерийг шаардлагад нийцэх эсэхийг энэ зүйлд зааснаар хянан үзнэ.

26.2.Захиалагч оролцогчийн ерөнхий шаардлагыг энэ хуулийн 7.2-т заасан мэдэгдэл, 7.3-т заасан баримт бичиг, 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн хянан үзнэ.

26.3.Оролцогч тендерт холбогдох баримт бичиг болон ирүүлсэн мэдэгдлийн үнэн зөвийг хариуцна.

26.4.Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ:

26.4.1.энэ хуулийн 15-17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлага хангасан байх;

26.4.2.санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх;

26.4.3.захиалагчаас тогтоосон эсхүл холбогдох гэрээний нөхцөлөөр тодорхойлсон талуудын эрх, үүргийг хүлээн зөвшөөрсөн байх;

26.4.4.тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх.

26.5.Оролцогчийн чадавхын болон туршлагын мэдээлэл төрийн эрх бүхий байгууллагад тайлагнаж баталгаажсан санхүү, нийгмийн даатгалын тайлангийн мэдээлэлтэй нийцсэн эсэхийг хянан үзэж болно.

26.6.Оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заагаагүй баримт бичгийг ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

26.7.Захиалагч тендерийг энэ зүйлийн 26.4.2, 26.4.3-т зааснаар хянан үзэхэд хэрэв дараах зөрүүг хүлээн зөвшөөрөх нь өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг харгалзан үзнэ:

26.7.1.бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй;

26.7.2.захиалагчийн санал болгосон гэрээний нөхцөлд хуульд үл нийцэх хязгаарлалт оруулаагүй;

26.7.3.захиалагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зорилгод нийцсэн эсэх.

26.8.Энэ хуулийн 12.5-д зааснаар “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт бичгээр эсхүл бусад зохих хэлбэрээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ.

26.9.Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

26.10.Энэ зүйлийн 26.9-д зааснаас бусад тендер болон дараах тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана:

26.10.1.тендерийн үнэ төсөвт өртгөөс эсхүл энэ хуулийн 10.11-д заасан болон ерөнхий гэрээний нэгж дээд үнээс хэтэрсэн;

26.10.2.энэ хуулийн 8.1-д заасны дагуу зохион байгуулсан дотоодын барааны багцад импортын бараа санал болгосон;

26.10.3.тендер шалгаруулалтын баримт бичигт шаардсан оролцогчийн хүлээх үүрэг, хариуцлагыг хүлээн зөвшөөрөөгүй эсхүл мэдэгдлийг үнэн зөвөөр гаргаагүй;

26.10.4.бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд энэ хуулийн 21.5-д заасан холбогдох тайлбар ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн.

27 дугаар зүйл.Тендер үнэлэх

27.1.Захиалагч шаардлагад нийцсэн тендерийг энэ хуулийн 11.4-т заасан үнэлгээний үндсэн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

27.2.Тендерийн нээлтэд зарлагдсан тендерийн үнэ, үнийн хөнгөлөлтөд үндэслэн харьцуулах үнийг дараах байдлаар тооцно:

27.2.1.үнийн хөнгөлөлтийг оролцогчоос ирүүлсэн аргачлалын дагуу тооцох, аргачлал ирүүлээгүй бол тендерийн үнээс тооцох;

27.2.2.тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар гадаад валютаар ирүүлсэн тендерийн үнийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Төв банк /Монголбанк/-ны албан ханшаар тооцож хөрвүүлэх;

27.2.3.давуу эрх олгож харьцуулах үнийг хийсвэрээр бууруулах;

27.2.4.энэ хуулийн 11.5-д заасны дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт хэрэглэхээр тусгасан бол мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх.

27.3.Үнэлж буй тендерийн үнэд арифметик алдаа байвал захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар залруулж, энэ тухай оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрөх эсэх талаар бичгээр хариу ирүүлэхийг шаардана.

27.4.Оролцогч энэ зүйлийн 27.3-т заасан мэдэгдлийн дагуу арифметик алдааг хүлээн зөвшөөрсөн бол залруулсан үнийг энэ зүйлийн 27.2-т зааснаар үнэлнэ.

27.5.Тендерийг энэ хуулийн 11.4.1-д зааснаар үнэлэхэд харьцуулах үнийг, энэ хуулийн 11.4.2-т зааснаар үнэлэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу тооцсон үнийг тус тус өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.

27.6.Хоёр ба түүнээс дээш тооны тендерийн харьцуулах үнэ тэнцүү бол хугацааны хувьд цахим системд түрүүлж ирсэн тендерийг эхэнд эрэмбэлнэ.

27.7.Хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрсөн бол хамгийн сайн тендерийн хувилбарт саналыг хянан үзэж, уг саналын харьцуулах үнэ тендерийн харьцуулах үнээс ихгүй бол сонгож болно.

27.8.Багцтай тендер шалгаруулалтын багц тус бүрд үнэлгээ хийх ба оролцогч хоёр ба түүнээс дээш багцад хамгийн сайн тендер ирүүлсэн бол оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадавхыг магадална.

27.9.Хэд хэдэн багцад шалгарсан оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадавхыг магадлахад аль нэг багцад шаардлага хангахгүй бол түүний чадавхын шаардлага хангах багцуудаас гэрээний үнэ хамгийн өндөр байх нэг эсхүл түүнээс дээш тооны багцад гэрээ байгуулах эрх олгоно.

27.10.Ерөнхий гэрээний аргын нэгдүгээр үе шатанд тендерийг хянан үзэж, шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн оролцогчдод ерөнхий гэрээ байгуулах эрх олгоно.

27.11.Захиалагч тендерийн харьцуулах үнийг хийсвэрээр тооцсон нь гэрээний үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

27.12.Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан нөхцөлөөр гэрээний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай татвар, даатгал, тээвэрлэлтийн болон бусад бүх зардлыг тендерийн үнэд багтсан гэж үзнэ.

27.13.Оролцогч чадавхын болон туршлагын шаардлагыг давуулан хангах нь түүний тендерт давуу байдал олгох үндэслэл болохгүй.

27.14.Энэ хуулийн 10.11-д заасан тендер шалгаруулалт болон ерөнхий гэрээний аргаар худалдан авахад энэ зүйлийн 27.2-т заасныг баримтлахгүй.

27.15.Тендер үнэлэх, давуу эрх олгох, ашиглалтын хугацааны өртөг тооцох аргачлал, зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28 дугаар зүйл.Захиалагч шийдвэр гаргах, түүнийг мэдэгдэх

28.1.Захиалагч тендер тус бүрд дараахаас аль тохирох шийдвэрийг гаргана:

28.1.1.хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох;

28.1.2.шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн боловч хамгийн сайн тендер ирүүлээгүй бусад оролцогчийн тендер шалгараагүй тухай;

28.1.3.шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзах.

28.2.Энэ зүйлийн 28.1.2, 28.1.3-т заасан шийдвэрт гэрээ байгуулах эрх олгосон оролцогчийн нэр, гэрээ байгуулах үнэ, түүний тендер шалгараагүй эсхүл татгалзсан үндэслэлийг зааж оролцогч тус бүрд нэгэн зэрэг мэдэгдэнэ.

28.3.Захиалагч энэ зүйлийн 28.1-д заасан шийдвэрийг цахим системд нийтэлснээр мэдэгдсэнд тооцно.

28.4.Захиалагч бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулах эсэх мэдээллийг энэ зүйлийн 28.1.3-т заасан шийдвэрт заана.

28.5.Захиалагч бүх тендерээс татгалзсантай холбоотойгоор дахин тендер шалгаруулалт зарлах тохиолдолд энэ хуулийн 59.1-д зааснаар гомдол гаргах хугацаа дуусаагүй байхад дараагийн тендер нээхийг хориглоно.

28.6.Энэ хуулийн 14.6.2-т заасан нөхцөл бий болсноор захиалагч гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгож, удаах эрэмбэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

28.7.Захиалагч хамгийн сайн тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсэн бол уг үнийг гэрээний үнээр тогтоож, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт заана.

28.8.Захиалагч шийдвэр гаргах эсхүл гэрээ байгуулах хүртэл хугацаанд оролцогчийг тендерийн хүчинтэй байх хугацааг сунгуулах хүсэлтийг гаргаж болох ба оролцогч хугацааг сунгах бол захиалагчид бичгээр мэдэгдэнэ.

28.9.Оролцогч тендер хүчинтэй байх хугацааг сунгаагүй нь түүний тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болохгүй.

29 дүгээр зүйл.Тендер шалгаруулалтын мэдээллийг оролцогчид ил болгох

29.1.Хуульд өөрөөр заагаагүй бол тендер хянан үзэх, үнэлэх үйл явц, тендерийн мэдээлэл, баримт бичгийг энэ хуулийн 28.1-д заасан шийдвэр гаргах хүртэл хугацаанд задруулахгүй.

29.2.Шалгарсан оролцогчийн тендерийн нууцлаагүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулгыг гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын таван өдрийн хугацаанд цахим системээр бусад оролцогчид ил болгоно.

29.3.Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг энэ хуулийн 28.1-д заасан шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн хугацаанд хүсэлт гаргасан оролцогчид танилцуулна.

29.4.Оролцогч, түүний төлөөлөгч шалгарсан тендерийг аливаа хэлбэрээр хуулбарлах, түгээхийг хориглоно.

30 дугаар зүйл.Гэрээ байгуулах

30.1.Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ.

30.2.Захиалагч доор дурдсан тохиолдолд энэ зүйлийн 30.1-д заасан ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа гэрээ байгуулах хугацааг баримтлахгүй байж болно:

30.2.1.тендер шалгаруулалтад нэг оролцогч тендер ирүүлж шалгарсан;

30.2.2.энэ хуулийн 35.1-д заасан үндэслэлээр гэрээ байгуулах;

30.2.3.ерөнхий гэрээ байгуулах, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах.

30.3.Захиалагч доор дурдсанаас бусад тохиолдолд шалгарсан оролцогчтой гэрээ байгуулна:

30.3.1.энэ хуулийн 14.6.2-т заасан нөхцөл үүссэн;

30.3.2.энэ хуульд заасан гомдол хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага эсхүл шүүхийн шийдвэрээр тендер шалгаруулалтыг түдгэлзүүлсэн, гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгосон эсхүл тендер шалгаруулалтыг хүчингүйд тооцсон.

30.4.Захиалагч шалгарсан оролцогчийн баталгаажуулан ирүүлсэн гэрээг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор, энэ хуулийн 49.4.12-т заасан мэдэгдлийн дагуу гэрээ байгуулах бол ажлын 10 өдрийн дотор тус тус гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцно.

30.5.Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар тухайн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хэрэгцээ шаардлага байхгүй болсон, эсхүл бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах санхүүжилтийн эх үүсвэргүй болсон тохиолдолд энэ зүйлийн 30.4 дэх хэсэг хамаарахгүй.

30.6.Санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тодотгол хийснээс бусад тохиолдолд захиалагч энэ зүйлийн 30.5-д заасан үндэслэлээр худалдан аваагүй бараа, ажил, үйлчилгээг тухайн төсвийн жилд дахин худалдан авахыг хориглоно.

30.7.Энэ хуульд зааснаар нээлттэй тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулсан бол холбогдох зээл, тусламжийн гэрээ байгуулагдах хүртэл худалдан авах гэрээ байгуулахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА

31 дүгээр зүйл.Тендер шалгаруулалтын арга

31.1.Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:

- 31.1.1.нээлттэй;
- 31.1.2.харьцуулалт;
- 31.1.3.гэрээ шууд байгуулах;
- 31.1.4.нэг эх үүсвэрээс худалдан авах.

31.2.Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна.

31.3.Энэ хуулийн 32-38 дугаар зүйл дэх тухайн тендер шалгаруулалтын аргад хамаарах зохицуулалтад тусгайлан өөрөөр заагаагүй асуудлаар энэ хуулийн хоёр, гуравдугаар бүлэгт заасныг баримтална.

31.4.Захиалагч энэ хуулийн 10.8, 10.10-т заасан тохиолдолд энэ зүйлийн 31.1.3, 31.1.4-т заасан аргаар тендер шалгаруулалт зохион байгуулж болно.

32 дугаар зүйл.Нээлттэй тендер шалгаруулалтын арга

32.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

32.2.Нээлттэй тендер шалгаруулалтын зарлалыг энэ хуулийн 18.1-д заасны дагуу нийтэлнэ.

32.3.Нээлттэй тендер шалгаруулалтын тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын 15-аас дээш, энэ хуулийн 8.3-т заасан тендер шалгаруулалтад ажлын 20-оос дээш өдөр байхаар заана.

32.4.Энэ хуулийн 33 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтыг нэг үе шаттай зохион байгуулна.

32.5.Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг холбогдох Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, эсхүл Засгийн газар тусгайлсан хэлэлцээрийг байгуулахаас өмнө урьдчилан зохион байгуулж болно.

32.6.Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

33 дугаар зүйл.Нээлттэй тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулах

33.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээний цар хүрээ, төсөвт өртөг өндөр, хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн бараа, ажил, үйлчилгээг цогцоор нь гүйцэтгэх шаардлагатай бөгөөд техникийн тэгш бус санал ирэх магадлалтай эсхүл шаардлага хангах, ижил хэмжээнд хүлээн зөвшөөрөхүйц хоёр ба түүнээс дээш техникийн шийдэл байх боломжтой гэж үзсэн бол нээлттэй тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж болно.

33.2.Нээлттэй тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулахад захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон техникийн тодорхойлолт бүхий тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, энэ хуулийн 18.3-т заасан зарлалд тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулах талаар заана.

33.3.Нэгдүгээр үе шатанд техникийн санал ирүүлэх сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангах бараа, ажил, үйлчилгээний шийдлийг санал болгоно.

33.4.Захиалагч нэгдүгээр үе шатанд ирүүлсэн техникийн шийдлийг судалж, шаардлагатай бол сонирхогч этгээдээс тодруулга авсны үндсэн дээр тендер шалгаруулалтын баримт бичгийг эцэслэн боловсруулж, тендер шалгаруулалтын урилгыг нэгдүгээр үе шатанд оролцсон этгээдэд хүргүүлнэ.

33.5.Энэ зүйлийн 33.4-т заасан урилгын дагуу зохион байгуулах тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд энэ хуулийн 32.3-т заасан хугацааг баримтална.

33.6.Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд тендер ирүүлнэ.

34 дүгээр зүйл.Харьцуулалтын арга

34.1.Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно.

34.2.Захиалагч зарлалд энэ хуулийн 18.3-т зааснаас гадна дараах мэдээллийг тусгана:

34.2.1.үнийн санал дуудах ажиллагаа хүчин төгөлдөр байхад шаардлагатай оролцогчийн тоо;

34.2.2.үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам, хугацаа.

34.3.Захиалагч энэ хуульд заасан цахим системд бүртгэлтэй аж ахуй эрхлэгчдэд үнийн санал дуудах урилга хүргүүлнэ.

34.4.Урилга хүргүүлсэн өдрөөс хойш ажлын таваас доошгүй өдрийн дараа үнийн санал дуудах ба үргэлжлэх хугацааг хоёроос доошгүй цаг байхаар урилгад заана.

34.5.Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээд уг ажиллагаанд оролцох эрхтэй.

34.6.Бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хүрээгүй бол захиалагч үнийн санал дуудах ажиллагааг цуцалж, цахим системээр мэдэгдэнэ.

34.7.Сонирхогч этгээд тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендерийг цахим системд ирүүлнэ.

34.8.Үнийн санал дуудах ажиллагааны туршид оролцогчийн мэдээлэл нууц байх бөгөөд оролцогч цахим системээс олгосон ялгах дугаарыг ашиглаж, заасан хугацаанд үнийн саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно.

34.9.Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно.

34.10.Энэ зүйлийн 34.9-д зааснаар хянан үзэхэд тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.

34.11.Энэ хуулийн 9.5-д заасан нөхцөлд захиалагч үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах хугацааг оролцогчид цахим системээр мэдэгдэнэ.

34.12.Харьцуулалтын аргаар худалдан авах бараа цахим каталогт бүртгэгдсэн байна.

35 дугаар зүйл.Гэрээ шууд байгуулах арга

35.1.Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно:

35.1.1.захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;

Тайлбар: Энэ заалтын дагуу гэрээ шууд байгуулахад өмнөх тендер шалгаруулалт амжилтгүй болсон, захиалагчаас хамаарах шалтгаанаар худалдан авах ажиллагаа удааширсан, эсхүл төсвийн жил дуусах нөхцөл байдал хамаарахгүй.

35.1.2.онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй.

35.2.Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ.

35.3.Захиалагчаас бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүчин чадал, нөөц бололцоотой гэж үзсэн гадаадын этгээдэд хэлэлцээ хийх урилгыг цахим системд зарлал нийтэлсэн өдөрт багтаан хүргүүлж болно.

35.4.Хэлэлцээнд оролцох сонирхлоо илэрхийлэх хугацааг зарлал нийтэлж, урилга хүргүүлснээс хойш ажлын таван өдөр байхаар, хэлэлцээ эхлүүлэх хугацааг сонирхлоо илэрхийлэх эцсийн хугацаанаас хойш ажлын гурваас доошгүй өдөр байхаар зарлал, урилгад тус тус заана.

35.5.Захиалагч хэлэлцээг зарлалд заасан хугацаанд сонирхогч этгээдтэй нэгэн зэрэг хийнэ.

35.6.Захиалагч хэлэлцээ хийхэд баримтлахаар тогтоосон дэгийг сонирхогч этгээдэд танилцуулж, хэлэлцээний тэмдэглэл хөтөлнө.

35.7.Сонирхогч этгээд зарлалд заасан хугацаанд хүрэлцэн ирээгүй, оролцоогүй нь хэлэлцээг хойшлуулах үндэслэл болохгүй.

35.8.Хэлэлцээгээр техникийн тодорхойлолт, санхүүжилтийн болон гэрээний нөхцөлийн талаар мэдээллийг солилцоно.

35.9.Захиалагч хэлэлцээний үндсэн дээр баталсан тендер шалгаруулалтын баримт бичгийг худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлж, тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын долоогоос доошгүй өдөр байхаар заана.

35.10.Хэлэлцээнд оролцсон этгээд тендер ирүүлэх эрхтэй байна.

35.11.Энэ зүйлийн 35.1-д заасан нөхцөлийг даван туулах, эсхүл түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг авран хамгаалахад энэ зүйлд заасан доод хугацаа, журмыг баримтлах боломжгүй бодитой нөхцөл байгаа бол шаардлагатай хугацаагаар багасгаж, урилга хүргүүлэх, хэлэлцээ хийх, тендер хүлээн авах журмыг баримтлахгүй байж болно.

35.12.Тендер нээснээс хойш захиалагч энэ хуулийн 25 дугаар зүйлд зааснаар тодруулга авах эрхгүй байна.

35.13.Энэ зүйлд заасны дагуу байгуулах гэрээний тоо хэмжээ, хугацаа нь уг аргыг сонгох болсон яаралтай нөхцөл байдлыг даван туулахад шаардлагатай тоо хэмжээ, хугацаанд нийцсэн байна.

35.14.Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тоо хэмжээ, хугацааг энэ зүйлийн 35.13-т заасанд нийцүүлэн хязгаарласны дараа үлдэх төсөвт өртөг энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрэх бол худалдан авах ажиллагааг аль болох богино хугацаанд эхлүүлнэ.

35.15.Захиалагч энэ зүйлийн 35.1-д зааснаар зохион байгуулсан тендер шалгаруулалтад бүх тендерээс татгалзсан үндэслэлээр дахин тендер шалгаруулалт зарлах бол энэ хуулийн 28.5-д заасныг мөрдөхгүй байж болно.

35.16.Энэ зүйлд заасан захиалагч хэлэлцээ хийхэд баримтлах дэгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

36 дугаар зүйл.Нэг эх үүсвэрээс худалдан авах арга

36.1.Захиалагч дараах нөхцөлд нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж болно:

36.1.1.оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэгч оюуны өмчийн эрх эзэмшигч, эсхүл түүнээс лицензийн гэрээний дагуу ашиглах эрх авсан албан ёсны нэг этгээд гүйцэтгэх боломжтой бол;

36.1.2.хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгсэл, яаралтай дархлаажуулалтад шаардагдах вакциныг үйлдвэрлэгчээс эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай бол;

36.1.3.нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;

36.1.4.нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан ажлын нэмэлт ажлын өртөг анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол;

36.1.5.төрийн өмчийн музей болон галерейн сан хөмрөгийг баяжуулах зорилгоор түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг нэг өмчлөгчөөс худалдан авах шаардлага үүссэн бол;

36.1.6.төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах үед үйлдвэрлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах нөхцөлд тухайн бараа, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс худалдан авах бол.

36.2.Энэ зүйлд заасан тендер шалгаруулалтын зарлалыг энэ хуулийн 18.1-д заасны дагуу нийтлэхгүй байж болно.

36.3.Энэ зүйлд заасан аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа шаардахгүй байж болно.

37 дугаар зүйл.Ерөнхий гэрээний арга

37.1.Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авахад дараах хоёр үе шаттайгаар зохион байгуулна:

37.1.1.нэгдүгээр үе шатанд худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага захиалагчийн худалдан авах бараа, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг хангах бараа нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулж, шалгарсан оролцогчтой ерөнхий гэрээ байгуулан, цахим дэлгүүрт бүртгэх;

37.1.2.хоёрдугаар үе шатанд захиалагч бараа, үйлчилгээг үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авах.

37.2.Ерөнхий гэрээний аргын нэгдүгээр үе шатанд ерөнхий гэрээ байгуулах тендер шалгаруулалтыг дараах нөхцөлтэйгөөр энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, захиалагчийн хэрэгцээнд үндэслэн бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг урьдчилан тогтооно:

37.2.1.гурав хүртэл жилийн хугацаанд хүчинтэй байх;

37.2.2.гэрээ байгуулах оролцогчийн тоог хязгаарлахгүй байх;

37.2.3.гэрээ хүчинтэй байх хугацаанд шаардлага хангасан оролцогчийг нэмж оруулах боломжтой байх;

37.2.4.үйл ажиллагааны салбар, газар зүйн байрлалд үндэслэн захиалагчийг тодорхойлсон байх.

37.3.Ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны тендер шалгаруулалтын зарлалд энэ хуулийн 18.3-т заасан мэдээллээс гадна гэрээний хүчинтэй байх хугацааг тусгана.

37.4.Энэ зүйлийн 37.2-т заасан тендер шалгаруулалтад оролцогчийн ирүүлсэн тендерийг энэ хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу хянан үзэж, энэ хуулийн 27.10-т заасны дагуу гэрээ байгуулна.

37.5.Шалгарсан оролцогчтой байгуулсан ерөнхий гэрээний дагуу худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт нэгж үнээр байршуулна.

37.6.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах ерөнхий гэрээнд энэ зүйлийн 37.2, энэ хуулийн 39.3-т заасан нөхцөлийг тусгана:

37.7.Ерөнхий гэрээнд энэ хуулийн 39.4, 39.5, 41 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

38 дугаар зүйл.Цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах

38.1.Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна.

38.2.Ерөнхий гэрээ байгуулсан тухайн бараа, үйлчилгээний гүйцэтгэгчид үнийн санал дуудах урилгыг цахим системээр хүргүүлнэ.

38.3.Урилга хүргүүлсэн өдрөөс хойш ажлын хоёроос доошгүй өдрийн дараа үнийн санал дуудах ба үргэлжлэх хугацааг хоёроос доошгүй цаг байхаар урилгад заана.

38.4.Энэ хуулийн 34.8-д заасан журмын дагуу зохион байгуулагдсан үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал ирүүлсэн гүйцэтгэгчтэй захиалагч гэрээ байгуулна.

38.5.Цахим дэлгүүрт нэг гүйцэтгэгч байгаа, эсхүл үнийн санал дуудахад үнийн санал ирээгүй бол захиалагч цахим дэлгүүрт бүртгэгдсэн хамгийн бага үнийн санал бүхий бараа, үйлчилгээг худалдан авч болно.

38.6.Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авахад энэ хуулийн 14.1, 42.1-д заасан тендерийн болон тендерийн баталгаа шаардахгүй ба тендерийг оролцогч, гүйцэтгэгчийн гаргасан мэдэгдлээр баталгаажуулна.

38.7.Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендер шалгаруулалтын аргачлал, зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ТАВДУГААР БҮЛЭГ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

39 дүгээр зүйл.Худалдан авах гэрээ

39.1.Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ (цаашид “худалдан авах гэрээ” гэх)-ний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна.

39.2.Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно.

39.3.Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

- 39.3.1.гэрээний үнэ;
- 39.3.2.гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл;
- 39.3.3.төлбөрийн нөхцөл, хугацаа;
- 39.3.4.урьдчилгаа төлбөрийн болон гүйцэтгэлийн баталгааны дүн;
- 39.3.5.захиалагчийн хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэр;
- 39.3.6.бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх хуваарь;
- 39.3.7.давуу эрх тооцсон бараа, материал, ажиллах хүчний мэдээлэл;
- 39.3.8.гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал;
- 39.3.9.түншлэл, туслан гүйцэтгэгчийн мэдээлэл;
- 39.3.10.гэрээ цуцлах болон гэрээнээс татгалзах үндэслэл, журам;
- 39.3.11.тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл.

39.4.Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна.

39.5.Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийн харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна.

40 дүгээр зүйл.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

40.1.Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

40.1.1.захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах;

40.1.2.энэ хуулийн 11.9-д заасан нөхцөл, аргачлалын дагуу гэрээний үнийг тохируулах.

40.2.Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараахыг хориглоно:

40.2.1.энэ зүйлийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

40.2.2.гүйцэтгэгч гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэх.

40.3.Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулснаар гүйцэтгэгч энэ хуулийн 7.1.1, 7.1.6, 7.1.8, 7.1.9-д заасан ерөнхий шаардлага хангахгүй болсон бол гэрээний үүргийг зөрчсөнд тооцно.

40.4.Энэ хуулийн 10.11-д заасны дагуу байгуулсан гэрээний хугацааг сунгахыг хориглоно.

41 дүгээр зүйл.Илт хууль бус гэрээ

41.1.Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна:

41.1.1.энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан;

41.1.2.энэ хуулийг зөрчиж нэг эх үүсвэрээс худалдан авсан;

41.1.3.хуульд зааснаар зарлал нийтлээгүй, эсхүл урилга хүргүүлээгүй;

41.1.4.энэ хуулийн 29.2-т зааснаар тендертэй танилцах эрхийг хязгаарласан;

41.1.5.тендер хүлээн авах эцсийн хугацааг эсхүл энэ хуулийн 30.1-д заасан гэрээ байгуулах хугацааг баримтлаагүй;

41.1.6.захиалагчийн энэ хуульд заасан бусад зөрчил нь тендер шалгаруулалтын эцсийн дүнд илт нөлөөлсөн.

41.2.Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасныг баримтлаагүй бол уг нэмэлт, өөрчлөлт илт хууль бус байна.

42 дугаар зүйл. Гүйцэтгэлийн болон зүгшрүүлэх, тохируулах хугацааны баталгаа

42.1.Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.

42.2.Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.

42.3.Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг дараах хэлбэрээр ирүүлж болно:

42.3.1.энэ зүйлийн 42.2-т заасан дүнгээс багагүй мөнгөн төлбөрийн үүргийг захиалагчийн шаардлагаар гүйцэтгэх тухай банкны баталгаа;

42.3.2.энэ зүйлийн 42.2-т заасан дүнгээс багагүй нэрлэсэн үнэтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг захиалагчийн шаардлагаар шилжүүлэх тухай эрх бүхий этгээдийн баталгаа;

42.3.3.гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгээгүйгээс учирч болох энэ зүйлийн 42.2-т заасан мөнгөн дүнгээс багагүй бүх эрсдэлийг даатгуулж, төлбөр хүлээн авагчаар захиалагчийг тодорхойлсон Монгол Улсын даатгагчаас гаргасан баталгаа.

42.4.Гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах эрхийг гадаадын этгээд эдлэх бөгөөд энэ тохиолдолд баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдээр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагыг заасан байна.

42.5.Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.

42.6.Гүйцэтгэгч энэ зүйлийн 42.5-д заасан барьцааг энэ зүйлийн 42.3-т заасан хэлбэрээр гаргаж болно.

42.7.Энэ хуульд зааснаар гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан эсхүл гэрээний хүчинтэй хугацаанд гүйцэтгэлийн баталгаа хүчингүй болох нөхцөл үүсвэл гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг зохих шаардлагад нийцүүлэн шинэчлэн гаргуулах, хүчинтэй гүйцэтгэлийн баталгаагаар солих үүрэг хүлээнэ.

42.8.Төсвийн жил дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааны хугацаа дуусахаас өмнө захиалагчид гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлнэ.

42.9.Гүйцэтгэгч энэ зүйлийн 42.8-д заасан гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол түүнийг гэрээний үүргээ зөрчсөнд тооцож, гүйцэтгэлийн баталгааг захиалагчийн орлого болгоно.

43 дугаар зүйл.Урьдчилгаа төлбөр, түүний баталгаа

43.1.Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлөх бол баталгаа шаардана.

43.2.Баталгаа урьдчилгаа төлбөрөөс багагүй дүнтэй байна.

43.3.Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно.

43.4.Урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнд энэ хуулийн 42 дугаар зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгааны дүнг оруулан тооцож болно.

43.5.Урьдчилгаа төлбөрийн баталгааг энэ хуулийн 42.3-т заасан хэлбэрээр гаргана.

43.6.Энэ хуулийн 42, 43 дугаар зүйлд заасан баталгааг гадаад валютаар илэрхийлэх бол баталгаа гаргасан өдрийн Төв банк /Монголбанк/-ны албан ханшаар тодорхойлно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА

44 дүгээр зүйл.Худалдан авах ажиллагааг төлөвлөх

44.1.Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.

44.2.Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна.

44.3.Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ.

44.4.Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ.

44.5.Худалдан авах ажиллагааг төлөвлөх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

45 дугаар зүйл.Худалдан авах ажиллагаа зохион байгуулах

45.1.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын баталсан

жагсаалтад тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна.

45.2.Энэ зүйлийн 45.1-д заасан төсөл, арга хэмжээний жагсаалтыг дараа оны төсвийн тухай хууль албан ёсоор нийтлэгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор Засгийн газар батална.

45.3.Энэ зүйлийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна.

45.4.Энэ зүйлийн 45.1-45.3-т зааснаас бусад улсын төсвийн хөрөнгө, захиалагчийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг захиалагч өөрөө зохион байгуулна.

45.5.Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч байна.

45.6.Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг энэ зүйлийн 45.5-д заасан захиалагч өөрийн хэрэгцээнд худалдан авахаас бусад тохиолдолд тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж зохион байгуулна.

45.7.Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ зүйлийн 45.1-45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ.

46 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааг тайлагнах

46.1.Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.

46.2.Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана.

46.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, дараа оны эхний улиралд Засгийн газарт тайлагнана.

46.4.Засгийн газар жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг тусгана.

46.5.Худалдан авах ажиллагааг тайлагнах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

47 дугаар зүйл.Тендер шалгаруулалтыг төвлөрүүлэн, нэгтгэн зохион байгуулах

47.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрснөөр харьяа байгууллагын төсвийн хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагч нь цахим дэлгүүрт байршуулаагүй нэг төрлийн бараа, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг төвлөрүүлэн зохион байгуулж болно.

47.2.Хоёр ба түүнээс дээш тооны төсвийн шууд захирагч дараах нөхцөлийн аль нэгд үндэслэн тендер шалгаруулалтыг хамтран зохион байгуулах хүсэлтийг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлж болно:

47.2.1.тодорхой зорилгыг хамтран хэрэгжүүлэх;

47.2.2.ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулах нь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх боломжтой.

47.3.Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.

48 дугаар зүйл.Захиалагчийн эрх, үүрэг

48.1.Төсвийн шууд захирагч болон бусад захиалагчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд энэ хуульд заасан захиалагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

48.2.Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулахад дараах эрх, үүрэгтэй:

48.2.1.худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;

48.2.2.үнэлгээний хороо байгуулах;

48.2.3.үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих;

48.2.4.энэ хуульд заасан хугацаанд шийдвэр гаргах;

48.2.5.тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх;

48.2.6.худалдан авах гэрээ байгуулах;

48.2.7.худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх;

48.2.8.энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах;

48.2.9.энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах;

48.2.10.энэ хуулийн 56.5-д заасан нөхцөл илэрсэн оролцогчийн талаарх мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт худалдан авах ажиллагааны улсын

байцаагчид хянуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

48.2.11.гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх;

48.2.12.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасан зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах;

48.2.13.хуульд заасан бусад эрх, үүрэг.

48.3.Захиалагчийг төлөөлөх этгээд энэ хуулиар олгогдсон эрх, үүргийг тухайн байгууллагын холбогдох бусад этгээдэд шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

48.4.Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

48.4.1.санхүүжилтийн эх үүсвэр баталсан шийдвэр;

48.4.2.нээлттэй тендер шалгаруулалтын аргаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгосон үндэслэл;

48.4.3.захиалагчийн баталсан тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;

48.4.4.захиалагч, оролцогчтой харилцсан албан бичиг;

48.4.5.оролцогчдын ирүүлсэн тендер;

48.4.6.үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж;

48.4.7.тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл;

48.4.8.захиалагчийн шийдвэр;

48.4.9.худалдан авах гэрээ;

48.4.10.бусад баримт бичиг.

48.5.Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална.

48.6.Захиалагч шалгарсан оролцогчийн тендерт ирүүлсэн загвар, дээжийг гэрээний үргэлжлэх хугацааны туршид хадгалж, гэрээний үүргийг гүйцэтгэлийг хянахад ашиглаж болно.

48.7.Захиалагч энэ хуулийн 35, 36 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.

48.8.Захиалагч энэ хуулийн 7.1.4-т заасан нөхцөл үүссэн, эсхүл энэ хуулийн 52 дугаар зүйлд заасан ажилтан, албан тушаалтанд нөлөөлсөн гэж үзэх үндэслэл байгаа тохиолдолд захиалагч холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

49 дүгээр зүйл.Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага

49.1.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэх ба аймаг, нийслэл, дүүрэгт худалдан авах ажиллагааны нэгжтэй байна.

49.2.Аймаг, нийслэл, дүүрэг дэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг тухайн шатны Засаг дарга худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай, дүүрэг дэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг дүүргийн Засаг дарга нийслэлийн Засаг даргатай тус тус зөвшилцөн томилж, чөлөөлнө.

49.3.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгжийн дарга нь ял шийтгүүлж байгаагүй, төрийн албанд зургаагаас дээш жил, үүнээс худалдан авах ажиллагааны чиглэлээр гурваас дээш жил ажилласан туршлагатай, сүүлийн гурван жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй байна.

49.4.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуульд заасан худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

49.4.1.худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

49.4.2.захиалагчийн энэ хуулийн 48.2.6, 48.2.7, 48.2.11-д зааснаас бусад эрх эдэлж, үүргийг хүлээх;

49.4.3.ерөнхий гэрээ байгуулахтай холбоотойгоор энэ хуулийн 48.2.11-д зааснаас бусад заасан захиалагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх;

49.4.4.худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

49.4.5.цахим системийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч, оролцогчийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, сургалт зохион байгуулах;

49.4.6.цахим систем, түүний бүрэлдэхүүн хэсгийн хэвийн үйл ажиллагааг хариуцан, цахим системийн аюулгүй байдал, нууцлалыг хангах, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг тогтмол нэмэгдүүлэх;

49.4.7.энэ хуулийн 22.10-т заасан төлбөрийн 30 хүртэл хувийг цахим системийн найдвартай ажиллагаа, шинэчлэл сайжруулалт, аюулгүй байдлыг хангахад зарцуулах;

49.4.8.энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан бүртгэлийн тогтолцоо үүсгэх, хөтлөх, боловсронгуй болгох;

49.4.9.цахим системийн ашиглалтад дүгнэлт хийж, холбогдох мэдээ, тоо баримтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

49.4.10.бараа, ажил, үйлчилгээний жишиг техникийн тодорхойлолт боловсруулах, ерөнхий гэрээ байгуулах бараа, үйлчилгээг тодорхойлох зорилгоор зах зээлийн судалгаа хийж, судалгаанд үндэслэн ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийн дээд хязгаарыг тогтоох, ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулах;

49.4.11.Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк болон баталгаа гаргах эрх бүхий бусад этгээдтэй энэ хуульд заасан баталгааг цахим системээр дамжуулан гаргах гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

49.4.12.шалгарсан оролцогчтой худалдан авах гэрээ байгуулах тухай мэдэгдлийг гэрээ байгуулах эрх бүхий этгээдэд хүргүүлэх;

49.4.13.захиалагч, эрх бүхий этгээдээс ирүүлсэн мэдэгдлийн дагуу худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг хүчингүй болгох;

49.1.14.энэ хуульд заасан бусад чиг үүрэг.

49.5.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

49.6.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 49.5-д зааснаар чиг үүргээ бусад этгээдэд шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

49.7.Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж энэ хуулийн 45.6-д заасан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зохион байгуулна.

49.8.Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

49.8.1.худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, саналаа худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

49.8.2.захиалагчийн энэ хуулийн 48.2.6, 48.2.7, 48.2.11-д зааснаас бусад эрх эдэлж, үүргийг хүлээх;

49.8.3.ерөнхий гэрээ байгуулах бараа, үйлчилгээг тодорхойлох зорилгоор зах зээлийн судалгаа хийж, саналаа худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

49.8.4.цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахад дэмжлэг үзүүлж, сургалт зохион байгуулах;

49.8.5.энэ зүйлийн 49.4.12-т заасан чиг үүрэг.

49.9.Гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг тухайн байгууллагын хүсэлтэд үндэслэн худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

50 дугаар зүйл. Үнэлгээний хороо

50.1.Захиалагч энэ хуулийн 10.2-т зааснаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаас бусад тохиолдолд үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:

50.1.1.100 сая төгрөг хүртэл төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтын үнэлгээний хороог гурваас доошгүй;

50.1.2.ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны эсхүл энэ зүйлийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй.

50.2.Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

50.2.1.тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах;

50.2.2.тендерийг нээх, хянан үзэх, үнэлэх;

50.2.3.захиалагчид энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргах зөвлөмж хүргүүлэх.

50.3.Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байна.

50.4.Үнэлгээний хорооны гишүүний гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус, хөндлөнгийн гишүүн байна.

50.5.Энэ зүйлийн 50.3-т заасан шаардлагад нийцэх, тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарын мэргэжлийн хүнийг үнэлгээний хороонд томилон ажиллуулж болно.

50.6.Захиалагч мэргэжлийн хүнийг үнэлгээний хороонд томилон ажиллуулах боломжгүй гэж үзсэн бол тодорхой асуудлаар зөвлөгөө авч, санал дүгнэлтийг сонсож болно.

50.7.Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүнийг тухайн салбарын холбоо, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс сонгоно.

50.8.Үнэлгээний хороонд тухайн салбарын холбоо, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах боломжгүй бол хөндлөнгийн гишүүнээр иргэнийг оруулж болно.

50.9.Үнэлгээний хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон, энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан үүргээ зөрчсөн бол захиалагч түүнийг үнэлгээний хорооны гишүүний үүргээс чөлөөлж, шинэ гишүүн нөхөн томилно.

50.10.Захиалагч үнэлгээний хорооны хараат бус, бие даасан байдлыг хангах зорилгоор энэ зүйлийн 50.2.1-д заасан чиг үүргийг гүйцэтгэснээр үнэлгээний хорооны чиг үүрэг дуусгавар болохоор байгуулж болно.

50.11.Энэ зүйлийн 50.10-т заасан тохиолдолд энэ зүйлийн 50.2.2, 50.2.3-т заасан чиг үүрэгтэй үнэлгээний хороог шинээр байгуулна.

50.12.Үнэлгээний хорооны дарга үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хурлыг товлон, тогтоосон хугацаанд шуурхай шийдвэр гаргаж, захиалагчид хүргүүлэх, үнэлгээний хороог захиалагчийн өмнө төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

50.13.Үнэлгээний хороо тендер шалгаруулалттай холбоотой асуудлаар захиалагчаас бусад этгээдтэй харилцахыг хориглоно.

50.14.Үнэлгээний хороо шаардлагатай асуудлаар захиалагчаар дамжуулан харилцана.

50.15.Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшуулал олгох, мэргэшсэн ажилтан бэлтгэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

51 дүгээр зүйл. Үнэлгээний хорооны хурал

51.1.Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хурал байна.

51.2.Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ.

51.3.Үнэлгээний хороо нийт гишүүний дөрөвний гурваас багагүй тооны гишүүний ирцтэй хуралдсанаар хурлыг хүчинтэйд тооцно.

51.4.Тендер хянан үзэх, үнэлэхэд энэ хуульд заасан үндэслэлээр холбогдох этгээдээс тодруулга авах шаардлагатай гэж үзвэл үнэлгээний хорооны хурлыг хойшлуулж болно.

51.5.Хууль тогтоомжид заасан үндэслэлээр эрх бүхий байгууллагаас тогтоосон бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон болон түүнтэй адилтгах бусад нөхцөл байдлаас шалтгаалан хуралд үнэлгээний хорооны бүх эсхүл зарим гишүүд биечлэн оролцох боломжгүй бол тухайн гишүүдийг хуралд цахим хэлбэрээр оролцуулж болно.

51.6.Үнэлгээний хорооны хуралд цахимаар оролцсон гишүүнийг ирцэд оруулан тооцож, хурлын тэмдэглэлд цахим системээр баталгаажуулна.

51.7.Үнэлгээний хорооны хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

51.8.Үнэлгээний хорооны гишүүд хуралд биечлэн оролцсон эсэхээс үл хамааран зөвлөмжтэй танилцаж, түүнийг дэмжих эсэх саналаа тусган цахим системээр баталгаажуулах үүрэгтэй.

52 дугаар зүйл.Худалдан авах ажиллагаанд оролцох ажилтан, албан тушаалтны үүрэг

52.1.Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх болон бусад үүргийг хүлээнэ.

52.2.Энэ зүйлийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан энэ хуульд зааснаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад цаг тухайд нь оролцох үүрэгтэй.

52.3.Захиалагч, түүнийг төлөөлөх аливаа этгээд худалдан авах ажиллагаанд холбогдох асуудлаар сонирхогч этгээд, оролцогч, тэдгээрийн төлөөлөлтэй хуульд өөрөөр заагаагүй бол бичгээр харилцана.

52.4.Захиалагч, түүнийг төлөөлөх ажилтан, албан тушаалтан болон үнэлгээний хорооны гишүүн худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар энэ хуульд зааснаас бусад үндэслэл, журмаар сонирхогч этгээд, оролцогч болон тэдгээрийг төлөөлж буй аливаа этгээдтэй уулзах, холбоо тогтоохыг хориглоно.

52.5.Энэ зүйлийн 52.1-д заасан этгээд дараах үүргийн аль нэгийг хэрэгжүүлээгүй нь түүнийг тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой чиг үүргээс чөлөөлж, эрх бүхий этгээд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно:

52.5.1.ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд захиалагчид мэдэгдээгүй эсхүл худал мэдүүлсэн;

52.5.2.ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар гаргаагүй эсхүл худал мэдүүлсэн;

52.5.3.худалдан авах ажиллагаанд холбогдох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн.

53 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, мэргэшсэн ажилтан

53.1.Худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажилтан, албан тушаалтан худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдсан байна.

53.2.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохих сургалтад хамрагдсан иргэнээс шалгалт авч, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээ олгоно.

53.3.Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллага, түүний багш, ажилтанд тавигдах шаардлага, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, шалгалтын журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

54 дүгээр зүйл.Бүртгэлийн тогтолцоо

54.1.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахим системээр дараах бүртгэлийг хөтөлнө:

54.1.1.захиалагч;

54.1.2.худалдан авах ажиллагаанд оролцох аж ахуй эрхлэгч;

54.1.3.худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан;

54.1.4.бараа, ажил, үйлчилгээний каталог.

54.2.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 54.1-д заасан бүртгэлийг цахим системд нээлттэй байршуулна.

54.3.Захиалагч цахим системд бүртгүүлснээр худалдан авах ажиллагаа зохион байгуулна.

54.4.Аж ахуй эрхлэгч цахим системд бүртгүүлж, тус системд холбогдсон төрийн эрх бүхий байгууллагын мэдээллийн сангаас оролцож байгаа тендер шалгаруулалттай холбоотойгоор түүний мэдээллийг цахим системээр харилцан дамжуулахыг хүлээн зөвшөөрсөн байна.

54.5.Цахим системд бүртгүүлсэн аж ахуй эрхлэгч энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага, энэ хуулийн 15-17 дугаар зүйлд заасан чадавх, туршлагын шаардлагыг хангасан талаарх мэдээлэл, баримт бичгийг оруулан өөрийн хувийн бүртгэлийг үүсгэнэ.

54.6.Аж ахуй эрхлэгчийн туршлага, гэрээний үүргийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг холбогдох төрийн эрх бүхий байгууллага болон захиалагч баталгаажуулснаар худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахим системд бүртгэнэ.

54.7.Аж ахуй эрхлэгч цахим систем дэх өөрийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт орох тухай бүрд шинэчлэх үүрэгтэй ба мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

54.8.Захиалагч энэ хуульд зааснаар хүргүүлэх урилгыг тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, цахим системд бүртгүүлсэн аж ахуй эрхлэгчид нэгэн зэрэг илгээнэ.

54.9.Энэ зүйлийн 54.8-д зааснаар урилга хүргүүлсэн нь урилга хүлээн авсан этгээдэд давуу байдал олгох, энэ хуульд заагаагүй бол бусад сонирхогч этгээд тендер ирүүлэхийг хориглох үндэслэл болохгүй.

54.10.Энэ зүйлийн 54.1-д зааснаар бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

55 дугаар зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

55.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагааны талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

55.1.1.худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах;

55.1.2.худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагчийн хүсэлтээр мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;

55.1.3.худалдан авах ажиллагаатай холбоотой журам, аргачлал, заавар, тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг, гэрээний загварыг батлах;

55.1.4.энэ хуульд зааснаар тендерийн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргах, тендерийн баталгааг улсын орлого болгох журмыг батлах;

55.1.5.тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам батлах;

55.1.6.худалдан авах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, заавар, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх;

55.1.7.худалдан авах ажиллагааны тайланг улсын хэмжээнд нэгтгэж, тоо баримт, мэдээлэл гаргах;

55.1.8.худалдан авах ажиллагаанд оролцох ажилтан, албан тушаалтны чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах;

55.1.9.худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хяналт тавих чиглэлээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;

55.1.10.худалдан авах ажиллагааны асуудлаар олон улсын байгууллага, гадаад улсын бусад байгууллагатай хамтран ажиллах;

55.1.11.энэ хуулийн 56.6-д заасан жагсаалт хөтлөх, хяналт тавих, мэдээлэх;

55.1.12.хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр энэ хуулийн хэрэгжилттэй холбогдуулж тодорхой асуудалд зөвлөмж өгөх;

55.1.13.хуульд заасан бусад бүрэн эрх.

55.2.Энэ зүйлийн 55.1.8-д заасан сургалт зохион байгуулах этгээдтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болно.

56 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааны улсын байцаагч

56.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, байцаагч (цаашид “улсын байцаагч” гэх) байна.

56.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагч байна. Ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

56.3.Худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагч улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэр гаргана.

56.4.Засгийн газар худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгааг тогтоож, улсын байцаагчийн дүрмийг батална.

56.5.Улсын байцаагч оролцогчтой холбоотой дараах нөхцөлийн талаар дүгнэлт гаргана:

56.5.1.худалдан авах ажиллагаанд оролцоход оролцогчийн ерөнхий болон чадавхын шаардлага, туршлагыг хангах талаар хуурамч баримт бичиг, эсхүл бусад этгээдийн баримт бичгийг өөрчилж тендерт ирүүлсэн;

56.5.2.энэ хуулийн 7.1.3, 7.1.6, 7.1.7, 7.1.9-д заасан нөхцөлийн талаар худал мэдүүлсэн тендер ирүүлсэн;

56.5.3.улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр худалдан авах гэрээний үүргээ гүйцэтгээгүйн улмаас гэрээ цуцлагдсан, гэрээнээс татгалзсан, эсхүл захиалагч хохирол шаардсан;

56.5.4.худалдан авах гэрээний үүргээ гүйцэтгэхэд мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эсхүл эрх бүхий бусад этгээд тогтоосон;

56.5.5.энэ хуулийн 10.9-д зааснаар эсхүл давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг зохих ёсоор оролцуулаагүй, эсхүл давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй.

56.6.Улсын байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

56.6.1.энэ зүйлийн 56.5-д заасан тохиолдолд оролцогчийг тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх санал гаргах;

56.6.2.энэ хууль зөрчсөн зөрчлийг арилгах, хариуцлага хүлээлгэх талаар дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

56.6.3.гэрээний үүргийн гүйцэтгэлд гарсан алдааг залруулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлэх.

56.7.Энэ зүйлийн 56.6.2, 56.6.3-т зааснаар улсын байцаагчийн гаргасан санал, дүгнэлтийг холбогдох эрх бүхий албан тушаалтан, байгууллагад хүргүүлснээс

хойш ажлын 15 өдрийн дотор биелэлтийн талаар улсын байцаагчид хариу мэдэгдэнэ.

56.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор тушаал гаргаж, аж ахуй эрхлэгчийг тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад гурван жилийн хугацаагаар бүртгэх шийдвэрийг гаргана.

56.9.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтыг хөтөлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

56.10.Холбогдох этгээд улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагчид гаргана.

56.11.Худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагч гомдлыг ажлын 20 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ.

56.12.Энэ зүйлийн 56.5-д заасан нөхцөл байдал бий болсноос хойш гурван жилийн хугацаанд худалдан худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн хяналт шалгалтыг эхлүүлж болно.

56.13.Энэ зүйлийн 56.12-т заасан хугацааны дотор эхлүүлсэн хяналт шалгалтад холбогдох асуудлыг эрх бүхий байгууллагаар шалган тогтоолгох зорилгоор хяналт шалгалтыг хойшлуулсан бол уг хугацаа тасалдсанд тооцно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ГОМДОЛ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

57 дугаар зүйл.Захиалагчид гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

57.1.Захиалагч тендер шалгаруулалттай холбоотой хуульд заасан үүргээ зөрчсөн гэж үзвэл сонирхогч этгээд, оролцогч энэ тухай мэдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд зөрчлийг нотлох баримтыг хавсаргана.

57.2.Захиалагч гомдлыг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор гомдол гаргагчийн нэрийг дурдалгүйгээр гомдлын агуулгыг цахим системд нийтэлнэ.

57.3.Захиалагч гомдлыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрт үндэслэл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дурдана.

57.4.Нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс тендер шалгаруулалтыг зогсоолгүйгээр үргэлжлүүлэх шаардлагатай гэж захиалагч шийдвэрлэснээс бусад тохиолдолд гомдол хянан шийдвэрлэх хугацаанд захиалагч гэрээ байгуулах эрх олгохгүй.

57.5.Энэ зүйлийн 57.4-т заасан үндэслэлээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэх шийдвэр гаргасан бол холбогдох үндэслэлийг гомдол гаргагчид мэдэгдэнэ.

57.6.Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэнтэй холбоотойгоор тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулсан бол энэ хуулийн 20.6-д заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгана.

57.7.Захиалагч энэ хуулийн 28.1-д заасан шийдвэр гарснаас хойш гомдол хүлээн авахгүй.

58 дугаар зүйл.Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гомдол гаргах

58.1.Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тендер шалгаруулалтын баримт бичиг өрсөлдөөн хязгаарласан тухай сонирхогч этгээдийн үндэслэл бүхий гомдлыг тендерийн нээлтээс нээлттэй тендер шалгаруулалтын хувьд ажлын таваас доошгүй өдрийн өмнө, тендер шалгаруулалтын бусад аргын хувьд ажлын гурваас доошгүй өдрийн өмнө тус тус хүлээн авна.

58.2.Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гомдол хянан шийдвэрлэж дуусах хүртэл хугацаанд захиалагчийг үйлдэл хийхгүй байхыг даалгах, захиалагчийн шийдвэрийг түдгэлзүүлэх шийдвэр гаргана.

58.3.Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана.

58.4.Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан гомдлын үндэслэлийн хүрээнд хянан шийдвэрлэнэ.

58.5.Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гомдлыг хянан үзэж, захиалагч энэ хуулийг зөрчсөн гэж үзвэл дараах шийдвэр гаргана:

58.5.1.тендер шалгаруулалтын баримт бичиг, шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, эсхүл өөрчлөлт оруулах;

58.5.2.зөрчлийг арилган, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг даалгах.

58.6.Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гомдол шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг сар бүр цахим системд нийтэлнэ.

59 дүгээр зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

59.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиалагчийн энэ хуулийн 28.1-д заасан шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлыг уг шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор, захиалагчид гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй тухай гомдлыг энэ хуулийн 57.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш ажлын таван өдрийн дотор тус тус хүлээн авна.

59.2.Энэ хуулийн 30.2-т заасан үндэслэлээр гэрээ байгуулах доод хугацааг мөрдөлгүй гэрээ байгуулсан захиалагчийн шийдвэрийг мэдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор гомдол гаргах оролцогчийн эрхийг хязгаарлахгүй.

59.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах гомдол үндэслэл бүхий байна.

59.4.Тендерийн баталгаа шаардсан тендер шалгаруулалтад оролцогчийн гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд тендерийн баталгаа хүчинтэй байна.

59.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 59.3, 59.4-т заасан шаардлагыг хангахгүй эсхүл шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзаж буцаана.

59.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдол хянан шийдвэрлэж дуусах хүртэл хугацаанд захиалагчийг үйлдэл хийхгүй байхыг даалгах, захиалагчийн шийдвэрийг түдгэлзүүлэх шийдвэр гаргана.

59.7.Захиалагчийг үйлдэл хийхгүй байхыг даалгасан, шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлснээс хойш гомдол хянан шийдвэрлэх хүртэл хугацаанд энэ хуулийн 24.1-д заасан хугацаа зогсоно.

59.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендер шалгаруулалтад холбоотой цахим системд байршуулсан баримт бичиг, мэдээлэл, тендер шалгаруулалтын хувийн хэрэгт үндэслэн гомдлын үндэслэлийн хүрээнд ажлын 10 өдөрт багтаан гомдлыг хянан шийдвэрлэнэ.

59.9.Захиалагч гомдол хянан шийдвэрлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээллийг цахим системд үнэн зөв, бүрэн байршуулах үүргийг хүлээнэ.

59.10.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдлыг хянан үзэж, захиалагч энэ хуулийг зөрчсөн гэж үзвэл дараах шийдвэр гаргана:

59.10.1.тендер шалгаруулалт эсхүл захиалагчийн шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, эсхүл өөрчлөлт оруулах;

59.10.2.зөрчлийг арилган, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг даалгах;

59.10.3.тухайн асуудалд хуулийн ямар заалт хэрэглэхийг заах.

59.11.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т заасантай адилтгах шалтгаанаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдлыг хянан шийдвэрлэх боломжгүй бол гомдлыг хүлээн авахаас татгалзаж буцааж болно.

59.12.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдол шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг сар бүр цахим системд нийтэлнэ.

60 дугаар зүйл.Шүүхэд гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

60.1.Сонирхогч этгээд эсхүл оролцогч гомдол хянан шийдвэрлэх байгууллагын эсхүл худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

60.2.Энэ хуулийн 59.2-т зааснаар урьдчилан шийдвэрлүүлэх журмаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдол хянан шийдвэрлэхээс бусад тохиолдолд худалдан авах гэрээ байгуулснаас хойш гаргасан гомдлыг шүүхэд гаргана.

60.3.Шүүх захиалагчийн шийдвэр, худалдан авах гэрээний биелэлтийг түдгэлзүүлэх нь нийтийн ашиг сонирхолд илтэд сонирхолтой гэж үзсэнээс бусад тохиолдолд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар түдгэлзүүлж болно.

60.4.Захиргааны гэрээнд хамаарах худалдан авах гэрээг Захиргааны ерөнхий хуульд үндэслэн цуцалснаас бусад гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргааныг иргэний хэргийн шүүхэд харьяалан шийдвэрлүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД

61 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх

61.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол буруутай албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн 48.1, хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2-т заасан сахилгын шийтгэлийг зөрчлийн шинж байдалд тохируулан ногдуулна.

61.2.Энэ зүйлийн 61.1-д зааснаар холбогдох этгээдэд сахилгын шийтгэл ногдуулсан нь түүнд энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хуульд зааснаар хариуцлага хүлээлгэх, хохирол нөхөн төлүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

61.3.Энэ хуулийн 24.1, 24.2-т заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй бол оролцогч тендер шалгаруулалтад оролцохтой холбогдсон бодит зардлыг буруутай ажилтан, албан тушаалтан төлнө.

61.4.Эрх бүхий байгууллага эсхүл шүүхээс энэ хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтныг энэ хуулийн 52 дугаар зүйлд заасан үүргээ зөрчсөн гэж тогтоосон бол Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг хүчингүй болгоно.

62 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

62.1.Энэ хуулийг 2023 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГА/ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөхөөс өмнө зарласан тендер шалгаруулалтыг 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж дуусгана.

2 дугаар зүйл.2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн этгээд бүртгэлийн үлдсэн хугацаагаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэлтэй байна.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “болох бөгөөд түүнийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу харьцуулалтын аргаар сонгон шалгаруулна” гэснийг “болно” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын нөөцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болсон тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ** ✓

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дараах хэсэг, заалтыг нэмсүгэй.

1/62 дугаар зүйлийн 62.1.5 дахь заалт:

“62.1.5.тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх шийдвэр бол.”

2/112 дугаар зүйлийн 112.10, 112.11 дэх заалт:

“112.10.Шүүх энэ зүйлийн 112.4.2-т заасан маргааныг хянан шийдвэрлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан цахим системээс нотлох баримтыг цахимаар татан авч шинжлэн судлах ба захиалагч болон бусад этгээд тоон гарын үсгээр баталгаажуулж цахим системд байршуулсан баримт бичгийг нотлох баримтын шаардлага хангасанд тооцно.

112.11.Энэ зүйлийн 112.4.2-т заасан маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг энэ хуулийн 80.2-т заасан үндэслэл болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар хойшлуулах бол дараагийн шүүх хуралдааны товыг хэргийн оролцогчдын саналыг харгалзан тогтоож, нэгээс илүүгүй удаа хойшлуулна.”

3/113 дугаар зүйлийн 113.7 дахь хэсэг:

“113.7.Шүүх энэ хуулийн 112.4.2-т заасан маргааныг хянан шийдвэрлээд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар гэрээ илт хууль бус болохыг тогтоосон бол гэрээний үүргийн гүйцэтгэлийг буцаах эсхүл тэр даруй зогсоох нь нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол гэрээ эрх зүйн үйлчлэлгүй болох хугацаа, журмыг зохигчдын саналыг харгалзан тогтооно.”

2 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6 дахь хэсгийн “Шүүх” гэсний дараа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан цахим системд байршуулсан баримт бичгээс бусад нотлох баримт гаргуулах, эсхүл цахим систем дэх баримт бичгийн үнэн зөвийг нотлох” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн “үндэслэл болгоно.” гэснийг “тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар сонгон шалгаруулна.” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “сонгохдоо” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 17.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,**

1 дүгээр зүйл.Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.5 дахь хэсэг нэмсүгэй:

“13.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулахад энэ зүйлийн 13.2-т заасан үйл ажиллагаа явуулах бол зөвхөн тус хуульд заасан үндэслэл, журмыг баримтална.”

2 дугаар зүйл.Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтын “ажиллагаанд оролцохдоо бараа бүтээгдэхүүний үнэ болон бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцох.” гэснийг “ажиллагаа, түүний нэг багц, хэсэгт харилцан хамаарал бүхий этгээдтэй хамт оролцсон, эсхүл бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцсон.” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсгийн “43.6-д” гэснийг “42.6-д” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.2 дахь хэсэг нэмсүгэй:

“17.2.Олон нийтийн радио, телевиз дуу-дүрсний болон радиогийн хөтөлбөр, нэвтрүүлэг худалдан авах, дангаар болон бусадтай хамтран бүтээхэд холбогдолгүй үйлчилгээ авах, бараа, ажил худалдан авахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуульд дараах агуулгатай 6¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“6¹ дүгээр зүйл. Даатгагч худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах

6¹.1. Даатгагч дараах шаардлагыг хангасан бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан баталгааг гаргаж болно:

6¹.1.1. давхар даатгалд хамрагдсан байх;

6¹.1.2. эрсдэлийн үнэлгээ хийсэн байх;

6¹.1.3. баталгаанд заасан мөнгөн хөрөнгийн хэмжээгээр даатгалын нөөц санг нэмэгдүүлсэн байх;

6¹.1.4. баталгааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.26-д заасан цахим системээр гаргах;

6¹.1.5. баталгааны төлбөр хүлээн авагчаар захиалагчийг тодорхойлсон байх.

6¹.2. Даатгагч энэ зүйлийн 6¹.1-д заасан баталгааны дагуу төлбөр төлөх нөхцөл үүссэн тухай захиалагчийн шаардлагыг хүлээн авсан бол төлбөрийг үл маргах журмаар төлнө.

6¹.3. Энэ зүйлд заасан баталгаанд энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмыг баримтлахгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

АГУУЛГА

Нэг.Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх болсон шалтгаан	2
Хоёр.Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүрээ	9
Гурав.Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	10
Дөрөв.Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний харьцуулах хэлбэр	10
Тав.Мэдээлэл цуглуулах	11
Зургаа.Үнэлгээний дүгнэлт	12
6.1.Хуулийн үйлчлэх хүрээ, зарчим	16
6.2.Худалдан авах ажиллагааны журам, тэдгээрийн хэрэглээ	22
6.3.Тендерийн урилга зарлах, тендерийн баримт бичиг, тэдгээртэй холбоотой мэдээллийг олгох хэлбэр	25
6.4.Тендер ирүүлэх хэлбэр	30
6.5.Тендерт оролцогчийн чадварын үнэлгээ	42
6.6.Тендерийг хянан үзэх шат, тендерийн үнэлгээ	47
6.7. Худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт	52
6.8.Маргаан шийдвэрлэлт	57
6.9.Хариуцлага	64
Долоо.Үнэлгээний зөвлөмж	65
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	68
ХАВСРАЛТ-1	70
ХАВСРАЛТ-2	72

2021 он

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улсын Их Хурал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр баталж, 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Өнгөрсөн 15 жилийн хугацаанд тус хуульд 28 удаа нэмэлт, өөрчлөлт орж төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа харилцааг зохицуулж байна.

Нэг.Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх болсон шалтгаан

Монгол Улс төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг анх хуульчлан зохицуулснаас хойш 20 жил өнгөрсөн ч төрийн худалдан авах ажиллагааны эрх зүй нь эдийн засгийн эрх зүйн хүрээнд харьцангуй шинэ тутам хөгжиж байгаа салбар эрх зүйн нэг байна.

Монгол Улсын Их Хурлаас 2000 онд баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн дагуу төрийн худалдан авах ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж удирдлага, зохион байгуулалтын хувьд хагас төвлөрсөн тогтолцоог хэрэгжүүлж байсан бол 2005 онд шинэчилсэн найруулгаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу төсвийн хүрээнд хийгдэх худалдан авах ажиллагааг захиалагч бие даан зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналт, хариуцлагыг бүрэн хүлээх, төвлөрсөн бус тогтолцоонд шилжсэн байна.

Тус хуулийг баталснаас хойш хуульд тасралтгүй нэмэлт, өөрчлөлт орж ирсэн. Тодруулбал, 2007 онд 17 зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орсон бол 2009 онд 2, 2010 онд 5, 2011 онд нийт 90, 2012 онд 1, 2014 онд 2, 2015 онд 32, 2016 онд 19, 2017 онд 4, 2018 онд 1, 2019 онд 77, 2020 онд 4, 2021 онд 1 нийт 28 удаа хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байна. Хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн судалгааг хавсралт-2-оос харна уу.

Дээрх байдлаас харвал хуульд жил бүр зарим жилд хэд хэдэн удаа их, бага тодорхой хэмжээний өөрчлөлтүүд орсон байна. Энэ нь нэг талаас уг хуулийн зохицуулж буй харилцааны онцлогтой нөгөө талаас нийгэм, эдийн засгийн хөгжилтэй холбоотой юм. Хуулийн зохицуулах харилцааны онцлог гэсний учир нь энэ хууль нь төрийн болон орон нутгийн өмч болох хязгаарлагдмал нөөц баялгийг үр ашигтай зарцуулах, хэмнэлтэйгээр худалдан авалт хийх, мөн тендерт оролцогчийн өрсөлдөх тэгш боломжийг хангах улмаар төсвийн болон бусад олон хуулийн зохицуулалттай уялдах шаардлагатай юм. Түүнчлэн төр, эдийн засгийн харилцааг зохицуулж, хөндлөнгөөс хянахын зэрэгцээ бас өөрөө оролцогч нь болдог онцлог харилцааг зохицуулдагт оршиж байна.

Эрх зүйн хэм хэмжээ нь нийгэм, эдийн засгийн хөгжилтэй зэрэгцэн боловсронгуй болох шаардлагатай хэдий ч тогтвортой байх шинжийг тодорхой түвшинд агуулах учиртай. Мөн олон удаа нэмэлт, өөрчлөлт орох нь хуулийн системчлэл, логик уялдаа холбоо алдагдах нөхцөлийг бий болгох талтай.

Түүнчлэн тухайн харилцааг бүхэлд нь зохицуулж байгаа хуулийг хууль хэрэгжүүлэгчид нэг мөр ойлгож практикт хэрэглэх, хуулийн зохицуулалт тухайн харилцааг зохицуулах зорилго, зарчимд нийцэж байгаа тохиолдолд зохицуулалтын зорилгод нийцсэн гэж дүгнэдэг.

Иймээс хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал нь эрх зүйн суурь зарчим, үзэл санаа, зохицуулалтын зорилгодоо нийцсэн эсэх хүрээнд хийсэн дүн шинжилгээгээр дараах дүгнэлт гарсан байна. Үүнд:

1. Хуулийн зохицуулалт нь эрх зүйн зарчимд нийцсэн байдал:

Хуулийн эрх зүйн суурь зарчим нь хууль дээдлэх зарчимд нийцсэн эсэх нь өмнө батлагдсан хуулиудтай зөрчилдөөнгүй байх, эрх зүйн онол, үзэл баримтлалд нийцсэн байдлаар тодорхойлогддог. Тус хууль нь бусад хуультай зөрчилдөж буй байдлыг бусад хуулийн холбогдох зарим заалттай харьцуулж жишээ болгон орууллаа.

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтад “Монгол Улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй” нь тендерт оролцогчийн ерөнхий шаардлага хангаагүй гэж үзэх үндэслэл болохоор заасан байна. Татварын ерөнхий хуулийн 28 дүгээр зүйлийн 28.1 дэх хэсэгт “Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө” гэж заасан. Энэ заалтын “хуулиар тогтоосон хугацаанд” гэдгийг үндэслэвэл татвар төлөгчид хуулиар тогтоосон хугацаа дуусахаас өмнө хэдийд ч татвараа төлж болохоор заасан байна. Татвар төлөх эцсийн хугацаа дуусахаас өмнө татвар төлөгчийг татварын өртэй гэж үзэх боловч тухайн татвар нь хугацаа хэтрээгүй болохыг анхааран хуулийн 14.1.3-т “Монгол Улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй” гэж заасныг “Монгол улсын эсхүл үүсгэн байгуулсан улсын хууль тогтоомжийн дагуу төлөх татвар, хураамж төлбөрөө хууль тогтоомжид заасан хугацаанд төлөөгүй” гэж зохицуулсан бол зохицуулалтын зорилгодоо нийцэх байжээ. Учир нь тендерт оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах нь тендерт оролцогчийн хувийн байдлыг тогтоох зорилготой. Тодруулбал, тендерт оролцогчийн татвар төлсөн эсэхийг хянан үзэж байгаа нь хуульд заасан хугацаанд төлсөн эсэхийг шалгаж хариуцлагатай байдлыг нь тогтоох зорилготой болохоос санхүүгийн чадавхыг үнэлэх шалгуур биш тул зохицуулалтын зорилгод нь нийцүүлж, энэ заалтад агуулгын өөрчлөлт оруулбал зохистой.

Хуулийн 28 дугаар зүйлийн 28.12 дахь хэсэгт “Тендерийн үнэлгээнд гадаад валют ашиглах бол энэ талаар тендерийн баримт бичигт заана” гэж мөн зүйлийн 28.13 дахь хэсэгт “Тендерийн баримт бичигт зааснаас өөр гадаад валютыг төлбөр тооцоонд хэрэглэх бол түүнийг хөрвүүлэх ханшийг тендер зарласан өдрийн Монголбанкнаас зарласан ханшаар тооцно” гэж тус тус заасан байна. Гэтэл 2009 онд баталсан Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөвт төлөх, төсвөөс санхүүжүүлэх аливаа төлбөр тооцоог зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгүүлэх бөгөөд эдгээр төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгүүлэхийг хориглоно” гэж гадаад валютаар гүйцэтгүүлэхийг туйлын тодорхой хориглосон. Дээрх зөрчилдөөнтэй байдал нь хууль дээдлэх зарчимд нийцэхгүй байна.

Хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.5 дахь заалтад “эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад чанар ба үнэлгээний харьцуулалтаар өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ.” гэсэн заасан. 2010 онд баталсан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд эм, эмнэлгийн хэрэгсэл гэдгийг тодорхойлсон тул эмнэлгийн тоног төхөөрөмжийн тендер шалгаруулалтад хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.5 дахь заалтад зааснаар үнэлгээ хийх нь зохистой эсэх нь тодорхойгүй байна. Иймээс эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичгийг ашиглан тендер зарлаж, хуулийн хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтад “хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер гэж үзнэ.” гэж заасныг баримтлан тендер шалгаруулалтын үнэлгээ хийх байдал нийтлэг байна. Мөн эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн баримт бичигт заасан оноогоор зөвхөн “эм”-ийг үнэлэх боломжтой бөгөөд эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үнэлэх боломжтой байна.

Хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт “Захиалагч тендерийн баталгааг хүчингүй болгох нөхцөлийг зохицуулсан байна. Энэ нь баталгааны хууль зүйн агуулгад нийцэхгүй зохицуулалт болжээ. Тендер шалгаруулалт нь захиалагч гэрээ байгуулах эрх олгосон этгээдтэй гэрээ байгуулснаар дуусгавар болдог. Тендерийн баталгаа нь тендерт хариуцлагатай оролцохыг баталсан санхүүгийн хариуцлагын хэлбэр тул тендер шалгаруулалт дуусгавар болсноор тендерийн баталгаа хүчингүй болох учиртай. Өөрөөр хэлбэл хэн нэг этгээд захиалагч хүчингүй болгох нь баталгааны хууль зүйн агуулгад нийцэхгүй байна.

Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.3 дахь хэсэгт “...хуульд заасан нөхцөл”-ийг гэрээний гол нөхцөл гэж тодорхойлсон бөгөөд хуулиар гэрээнд үүрэг болгож байгаа нөхцөл болохын хувьд тодорхой байх шаардлагатай байна. Тодорхойгүй нөхцөлийг гэрээнд тусгах боломжгүй юм. Гэтэл хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3.4 дэх заалтад “Захиалагчийн хяналт болон бусад нөхцөл”-ийг гэрээний гол нөхцөл байхаар заасан байна. Энд “...бусад нөхцөл” гэж заасан нь туйлын тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл бусад нөхцөл гэдэгт юуг ойлгох нь тодорхойгүй байдлаар ерөнхий заасан тул хэрэгжих боломжгүй заалт гэж үзэж байна.

Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3.6 дахь заалтад “худалдааны нөхцөлүүд” гэрээний гол нөхцөл байхаар заасан байна. “Худалдааны нөхцөл” гэдэгт юуг ойлгох нь мөн тодорхойгүй хэт ерөнхий зохицуулсан байна. Практикт Олон улсын худалдааны танхимаас боловсруулсан гадаад худалдааны нийлүүлэлтийн нөхцөл болох “Инкотермс”-ийн нөхцөл гэж ойлгох хандлага түгээмэл байна. Хэрэв инкотермсийн нөхцөл гэж ойлговол энэ нь импортын бараанд л хамаарах бөгөөд дотоодоос нийлүүлэх бараанд хамаарахгүй. Гэтэл хуульд бараа, ажил, үйлчилгээнд аль алинд нь хамаарахаар зохицуулсан байна.

Хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1.1-д заасан захиалагчийг төлөөлж төсвийн ерөнхий менежер, 4.1.2-т заасан захиалагчийг төлөөлж гүйцэтгэх захирал энэ хуулийн 46.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.” гэж заасан бөгөөд Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөж эхэлснээр Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад “ерөнхий менежер” гэж төсвийн

ерөнхийлөн захирагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр төсвийн байгууллагыг өдөр тутмын удирдлагаар хангах үүрэг бүхий албан тушаалтныг” гэж заасан төсвийн ерөнхий менежер гэсэн нэр томъёог хэрэглэхгүй болсон нь хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг ойлгож тайлбарлахад зөрүүтэй байдлыг үүсгээд байна.

Хуулийн 52¹ дүгээр зүйлийн 52¹.2.3 дахь заалт нь Иргэний хууль болон хувийн эрх зүйн онолын суурь ойлголтод нийцээгүй байна. Учир нь хуулийн 42 дугаар зүйлд гэрээ хүчин төгөлдөр бус болох үндэслэлийг заасан бөгөөд уг үндэслэлийн аль нэг бүрдсэн тохиолдолд тухайн гэрээ хүчин төгөлдөр бус болно. Гэрээ хүчин төгөлдөр бус болохын үр дагавар нь тухайн гэрээ анхнаасаа байгуулагдаагүй гэж үздэг. Харин “гэрээг цуцлах” ойлголт нь хүчин төгөлдөр гэрээг дуусгавар болгож буй ойлголт юм. Өөрөөр хэлбэл хувийн эрх зүйд гэрээ нэгэнт хүчин төгөлдөр бус болсон тохиолдолд түүнийг цуцлах тухай ойлголт байхгүй тул хэрэгжих боломжгүй зохицуулалт байна.

2. Хуулийн зохицуулалт нь тодорхой, ойлгомжтой, зөрчилдөөнгүй байх шаардлагад нийцсэн байдал.

2.1. Тодорхой, ойлгомжтой байх шаардлага: Эрх зүйн нэгдмэл байх зарчмын үүднээс нэр томъёог нэг утгаар ойлгох учиртай. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд мөнгөн хөрөнгөөс бусад бүх төрлийн хөрөнгийг бараа гэж тодорхойлсон боловч хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10-т “Бараа”-г тодорхойлохдоо бусад хуулийн тодорхойлолттой уялдуулаагүйн зэрэгцээ барааг оновчтой тодорхойлоогүй байна. Зүй нь бараа нь өөрөө эдийн баялгийн эрх болохын хувьд хувийн эрх зүйн эдийн баялгийн эрх зүйн үүднээс тодорхойлогдох учиртай.

Гэрээний үүргийг ноцтой зөрчсөнийг тогтоох нь мөн л хувийн байдлыг тогтоох шалгуур үзүүлэлтийн хүрээнд тендерт оролцогч нь бусдын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлдэг эсэхийг тогтоох зорилготой. Энэ шалгуур бол ерөнхий нөхцөлийг магадлах чухал шалгуур боловч өмнө нь гэрээний үүргээ зөрчиж байсан эсэхийг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байна. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтад “Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, энэ хуулийн 52¹.1-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон” гэж заасан. Энд заасан “гэрээний үүргээ ноцтой зөрчсөн” нь шүүхээр тогтоогдсон байх шаардлагатай юу? эсхүл үнэлгээний хороо нь мэдээлэл болон бусад баримтад үндэслэн тогтоох ёстой уу? гэдэг нь тодорхойгүй байдлаар зохицуулагдсан байна. Ийнхүү тодорхойгүй байгаа нь энэ заалтыг захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхүүд өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж байгаагаас тодорхой харагдаж байна. Тодруулбал, анхан шатны шүүх “гэрээний үүргээ ноцтой зөрчсөнийг шүүхээс тогтоосон байх шаардлагатай” гэж тайлбарласан бол давж заалдах шатны шүүх “шүүхээс тогтоосон байхыг шаардахгүй” гэж тайлбарласан тохиолдол байна. Энэ нь уг заалт ойлгомжгүй байгааг илэрхийлнэ.

Хуулийн 42 дугаар зүйлд заасан “Хүчин төгөлдөр бус гэрээ”-ний зохицуулалт нь нэг талаас нэгэнт Иргэний хуулиар зохицуулсан

харилцааг дахин зохицуулсан нөгөө талаас нэг нь нөгөөдөө багтах нэг агуулгыг хоёр өөр нөхцөл болгон зохицуулсан байна. Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1 дэх заалтад хууль зөрчиж байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр бус байхаар заасан байгаа. Хэрэв хуулийн 27, 28, 29 дүгээр зүйлийг зөрчиж гэрээ байгуулсан бол энэ нь Иргэний хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан хууль зөрчиж байгуулсан гэрээ болно. Мөн худалдан авах ажиллагааны журмыг хэрэгжүүлэхэд гаргасан зөрчил нь тендер шалгаруулалтын эцсийн дүнд илт нөлөөлсөн тохиолдолд энэ нь хуулийн 27, 28, 29 дүгээр зүйлийг зөрчсөн гэдэгт багтах харилцаа байна. Иймээс энэ хуулиар гэрээ хүчин төгөлдөр бус болох тохиолдлыг зохицуулах шаардлагатай гэж үзвэл илүү нарийвчилж зохицуулах шаардлагатай байсан байна.

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6 дахь заалтад “илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг энэ хуулийн 52¹.1-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон” гэж заасан ч “илт худал мэдээлэл” гэж юу болохыг хуульд тодорхой заагаагүй нь хууль хэрэглээний явцад уг асуудлыг субъектив байдлаар хандаж тайлбарлаж, хэрэглэж боломжийг олгосны зэрэгцээ хууль хэрэглээнд ойлголтын зөрүү үүсгэж байна.

- 2.2. Хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөөнгүй байх шаардлага: Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “сонирхсон этгээдүүдийн ерөнхий нөхцөлийг магадална” гэжээ. Гэтэл тендер ирүүлсэн этгээд нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтад зааснаар бол “тендерт оролцогч” гэсэн статустай байна. Ийнхүү хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалттай зөрчилдсөнөөр оролцогч болон сонирхогч этгээд гэх нэр томъёог тодорхойгүй болгож байна.

Хуулийн 46 дугаар зүйлд захиалагчийн эрх, үүргийг заахдаа хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.7 дахь заалтад “хууль, гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулахгүй байх” үүргийг хуульчилсан байна. Нэгэнт хуулийн 41 дүгээр зүйлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглосон байхад хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.7 дахь заалтад “гэрээнд зааснаас бусад тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй” байхаар заасан нь гэрээгээр “нэмэлт өөрчлөлт оруулах” нөхцөлийг чөлөөтэй зааж болох мэт ойлгогдож байна. Энэ утгаараа Бараа нийлүүлэх тендерийн жижиг баримт бичиг дэх “гэрээний ерөнхий нөхцөл”-д “Захиалгыг солих” эрхтэй байх, улмаар захиалгыг сольсноор гэрээнд нэмэлт өөрчлөлт орж болохоор заасан байна.

Бараа нийлүүлэх тендерийн жижиг баримт бичиг дэх гэрээний заалт нь хуулийн 41 дүгээр зүйлийг үндэслэвэл Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1 дэх заалтад заасан хууль зөрчиж хийсэн хэлцэл болох үр дагавартай бол, харин эсрэгээрээ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.7 дахь заалтад заасныг үндэслэвэл гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдлыг зохицуулж болохоор байна. Энэ тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахгүй байх хуулийн зохицуулалтын зорилгод нийцэхгүй байхаас гадна гэрээ байгуулсан нөгөө тал болох

нийлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх улмаар гэрээ хэрэгжих боломжгүй нөхцөл байдалд хүрэхээр байна.

3. Хэл найруулга, логик зүй тогтлыг хангах болон бүрэн байх шаардлага

3.1. Хэл найруулга, логик зүй тогтлыг хангах шаардлага:

Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “хянан үзэх шатанд шаардлага хангасан, үнэлэх шатнаас шалгарсан этгээд байхаар заажээ. Логик утгаараа хянан үзэх шатнаас шаардлага хангасан этгээдийн тендерийг үнэлж, шалгарсан этгээдэд гэрээ байгуулах эрх олгож байгаа тул хоёр дах шатанд шаардлага хангасан байхыг тусгайлан заах нь ач холбогдолгүй байна.

Хуулийн 41 дүгээр зүйлд худалдан авах гэрээнд нэмэлт өөрчлөлт хийхийг хориглосон тохиолдлыг зохицуулсан. Хуулийн 41 дүгээр зүйлийн гарчгаас харвал энэ зүйл нь “Худалдан авах гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах” харилцааг зохицуулсан зүйл болох нь тодорхой байна. Гэтэл тухайн харилцаанд хамааралгүй асуудлыг хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт зохицуулсан байна. Хуулийн гарчиг нь хуулийг системчлэх зорилготой бөгөөд хуульд системчлэлийн тайлбар хийхэд ашиглах зорилготой байдаг. Гэтэл ийнхүү зохицуулсан нь хууль нь системчлэлийн алдаатай байна.

Хуулийн 23 дугаар зүйлд тендерийн баримт бичгийг бэлтгэх хэлийг зохицуулахдаа Монгол хэлнээс гадна олон улсын худалдаанд өргөн ашиглагддаг хэл дээр бэлтгэх хоёр үндэслэлийг тодорхой заасан байна. Үүний нэг нь “гадаадын этгээд оролцох эрхтэй бол” гэж заасан байхад нөгөө үндэслэл нь “гадаадын этгээдийн сонирхлыг татна гэж захиалагч үзэж байгаа бол” өөр хэл дээр бэлтгэхээр заасан байна. Гэтэл эхний үндэслэлд дараагийн үндэслэл нь багтахаар байна. Өөрөөр хэлбэл зөвхөн гадаадын этгээд оролцох эрхтэй буюу зөвшөөрсөн тохиолдолд л гадаадын этгээд оролцоно. Харин гадаадын этгээдийн сонирхлыг татсан ч гадаадын этгээд оролцох эрхгүй тул тендерийн баримт бичгийг Монгол хэлнээс гадна өөр хэлээр бэлтгэх нь ач холбогдолгүй юм. Иймээс энэ заалт нь ач холбогдолгүй зохицуулалт болжээ.

3.2. Бүрэн байх шаардлага:

Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Захиалагч...“хамгийн сайн” тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай ... түүнд мэдэгдэнэ” гэж заасан. Энд гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэх болон мэдэгдэх хугацааг тодорхой зохицуулаагүй орхигдуулжээ. Хуульд зааснаар захиалагч тендерийн хүчинтэй байх хугацаанд багтаан гэрээ байгуулах үүрэгтэй. Гэтэл практикаас харахад захиалагч тодорхойгүй шалтгааны улмаас уг хугацаанд гэрээ байгуулах боломжгүй байдлыг бий болгож байна.

Тухайлбал захиалагч гэрээ байгуулахад хангалттай хугацааны өмнө үнэлгээний хорооноос зөвлөмж ирсэн байтал тендерийн хүчинтэй байх хугацааг дуусахын өмнөхөн гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлснээр гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүлээн авсан этгээд тендерийн хүчинтэй байх хугацаанд багтаан гэрээ байгуулах боломжгүй байдал бий болох тохиолдол түгээмэл байна.

Хэдийгээр хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт “Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулах боломжгүй болсон бол захиалагч төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган, зөвшөөрөл авсны үндсэн дээр уг хугацааг нэг удаа 15 хоногоор сунгуулж болно” гэж заасан боловч энэ нь захиалагчаас үл хамаарах шалтгаанд хамаарахгүй юм.

Хуульд гэрээ байгуулахаар шийдвэрлэх болон гэрээ байгуулахыг мэдэгдэх хугацааг захиалагчид үүрэг болгон тодорхой зохицуулаагүйгээс тендер шалгаруулалтын гэрээ байгуулах үе шатанд тендер шалгаруулалт амжилтгүй болж байна. Энэ нь нөгөө талаас худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг зөрчсөн төрийн байгууллагын албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт хэрэгжих боломжгүй байгаатай холбоотой байна.

Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх механизм, эрх зүйн зохицуулалт байхгүй буюу зохицуулалтгүй орхигдсон гэж үзэхээр байна. Учир нь хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасан хариуцлагын заалт нь зөвхөн хууль зөрчсөн тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Гэтэл төрийн худалдан авах ажиллагаа нь хуулиар хязгаарлагдахгүй хэм хэмжээ тогтоосон актаар зохицуулагддаг харилцаа бөгөөд уг хэм хэмжээний актыг зөрчсөн тохиолдолд хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болохооргүй байна.

Худалдан авах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж байгаа төрийн байгууллагын албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх механизм, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь худалдан авах ажиллагаанд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ төр болон бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж байна.

Дээр дурдсан асуудлыг нэгтгэн дүгнэхэд тус хууль нь өнөөдрийг хүртэл хуулийн зорилтын дагуу худалдан авах ажиллагааг зохицуулж ирсэн боловч хуулийн зарим зохицуулалтын ойлгомжгүй, тодорхойгүй байдлын улмаас маргаан үүсэж, улмаар хууль хэрэгжүүлэгчид тухайн заалтыг харилцан адилгүй тайлбарлаж буй нөхцөл үүссэн байна. Энэ нь тендерт оролцогчид болон тодорхой хүрээний захиалагч байгууллагуудын эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөс гадна худалдан авах ажиллагааны зорилго хангагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн хуулийн зарим зохицуулалт нь эрх зүйн үндсэн зарчимд нийцээгүй, нэр томъёог оновчтой тодорхойлоогүй, бусад хуультай болон хуулийн заалтууд хоорондоо зөрчилдсөн, зохицуулах шаардлагатай харилцааг зохицуулаагүй орхигдуулсан зэрэг нөхцөл байдлууд байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдалд үндэслэн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх дараах шалтгааныг тодорхойлсон. Үүнд:

- Хууль нь хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан зорилтын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах харилцааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх;

- Хуулийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдал, санхүү, төсвийн харилцаанд нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, төрийн үйл ажиллагаа дахь цахим шилжилтэд нийцүүлэн өөрчлөх, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, тэдгээрээс улбаалан сөрөг үр дагавар бий болсон эсэх;

- Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжээс хуульд заасан чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн эсэх.

Түүнчлэн худалдан авах ажиллагаанд оролцогч талууд захиалагч, тендерт оролцогч, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллахаар заасан этгээдээс хуулийн хэрэгжилт, хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, хэрэгжилтийг боловсронгуй болгох саналыг тандан судлах зорилгоор Сангийн яамнаас авсан анкетын судалгаанд оролцогчдоос дараах асуудлыг хөндсөн байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх;
2. Тендер шалгаруулалтын журам тухайлбал хязгаарлагдмал тендер шалгаруулалтын арга, харьцуулалтын арга, гэрээ шууд байгуулах арга, зөвлөх сонгох журам, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын үед тендер хүлээн авах хугацааг бууруулах;
3. Тендерийн үнэлгээг боловсронгуй болгох, хүний оролцоог багасгах;
4. Тендер баримт бичигт заасан шаардлагыг анхаарч, баримт бичгийн шаардлагыг бууруулах;
5. Төрд байгаа мэдээллийг тендерт оролцогчоос шаардаж буй байдлыг бууруулах;
6. Орон нутаг дахь худалдан авах ажиллагааны чиг үүргийг тодорхой болгох.

Дээрх шалтгаан нь хуулийн үйлчлэх хүрээ, тендер шалгаруулалтын журам, тендерийн баримт бичиг бэлтгэх, тендер хянан үзэх, үнэлэх, худалдан авах ажиллагааны удирдлагын асуудлын хүрээнд байх тул эдгээр харилцааг хуулиар бүрэн зохицуулж чадаж байгаа эсэхийг тогтоохоор хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийлээ.

Хоёр.Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг үнэлгээ хийх зорилго, шалтгаанд тулгуурлан агуулгын ач холбогдол, нөлөөлөл үзүүлэх байдлыг харгалзан дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Хуулийн үйлчлэх хүрээ, зарчим (Нэгдүгээр бүлэг);
- Худалдан авах ажиллагааны журам, тэдгээрийн хэрэглээ (Нэгдүгээр бүлэг, Хоёрдугаар бүлэг);
- Тендерийн урилга зарлах, тендерийн баримт бичиг, тэдгээртэй холбоотой мэдээллийг олгох хэлбэр (Хоёрдугаар бүлэг);
- Тендер ирүүлэх хэлбэр (Хоёрдугаар бүлэг);
- Тендерт оролцогчийн чадварын үнэлгээ (Нэгдүгээр бүлэг, Хоёрдугаар бүлэг);
- Тендерийг хянан үзэх шат, тендерийн үнэлгээ (Хоёрдугаар бүлэг, Дөрөвдүгээр бүлэг);
- Худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт (Зургаадугаар бүлэг);

- Маргаан шийдвэрлэлт (Долоодугаар бүлэг);
- Хариуцлага (Долоодугаар бүлэг).

Гурав.Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

№	Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт
1.	Зорилгод хүрсэн түвшин	Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.
2.	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Иргэд, хуулийн этгээдээс хуулийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тогтооно.
3.	Практикт нийцэж байгаа байдал	Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.
4.	Зардлын бууралт өсөлт,	Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаа дахь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага болон улсын төсөвт үүсэж байгаа зардлын өсөлт, бууралтыг тодорхойлох боломжгүй тул зардлын өсөлт, бууралт гэсэн шалгуур үзүүлэлтийг зөвхөн цахим тендер шалгаруулалт дахь захиалагч, тендерт оролцогчийн зардалд үндэслэн хийхээр тогтсон болно.

Дөрөв.Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний харьцуулах хэлбэр

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хамрах хүрээг дээр дурдсан үнэлгээний шалгуур үзүүлэлтээр дараах харьцуулах хэлбэрийг ашиглахаар тогтсон. Үүнд:

№	Харьцуулах хэлбэр	Тодорхойлолт
1.	Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.
2.	Тохиолдол судлах.	Хууль эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулна.

Хуулийн үйлчлэх хүрээ, зарчим (Нэгдүгээр бүлэг)-г зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш болон тохиолдол судлах гэсэн харьцуулах хэлбэрээр үнэлнэ.

Тендер ирүүлэх хэлбэр, арга (Хоёрдугаар бүлэг)-г практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр тохиолдол судлах гэсэн харьцуулах хэлбэрээр, мөн зардлын өсөлт, бууралт гэсэн шалгуур үзүүлэлтийг цахим тендер шалгаруулалт дахь захиалагч, тендерт оролцогчийн зардлын хүрээнд хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гэсэн харьцуулах хэлбэрээр үнэлнэ.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх худалдан авах ажиллагааны журам, тэдгээрийг сонгох, хэрэглэх (Нэгдүгээр бүлэг, Хоёрдугаар

бүлэг), тендерийн урилга зарлах, тендер баримт бичиг, тэдгээртэй холбоотой мэдээллийг олгох (Хоёрдугаар бүлэг), тендерт оролцогчийн чадварыг үнэлэх (Нэгдүгээр бүлэг, Хоёрдугаар бүлэг), тендерийг хянан үзэх, үнэлэх (Хоёрдугаар бүлэг, Дөрөвдүгээр бүлэг), худалдан авах ажиллагааны удирдлага (Зургаадугаар бүлэг), маргаан шийдвэрлэх (Долоодугаар бүлэг), хариуцлага ногдуулах (Долоодугаар бүлэг)-ыг хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтээр тохиолдлыг судлах, харьцуулах хэлбэрээр үнэлнэ.

Тав.Мэдээлэл цуглуулах

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт дээр дурдсан шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэрт үндэслэн дараах чанарын болон тоон судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилтийг шүүхийн практикт хэрхэн хэрэглэж байгааг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт үндэслэн тандан судалсан.
2. Тендерт оролцогч аж ахуйн нэгжээс хуулийн хэрэгжилт, түүний тендерт оролцогчдод үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, цаашид хуулийг боловсронгуй болгох арга замыг тандан судлах судалгааг анкетын аргаар худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) (цаашид “цахим систем” гэх)-д бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэдээс 2021 оны 7 дугаар сарын 26-аас 30-ны өдрийн хооронд авсан.
3. Худалдан авах ажиллагааны захиалагч болох төрийн байгууллага, албан газар, төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой үйлдвэрийн газар, компанийн албан хаагч, ажилтнуудаас хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад тулгамдаж буй асуудал, цаашид хуулийг боловсронгуй болгох арга замыг тандан судлах судалгааг анкетын аргаар цахим системд бүртгэлтэй захиалагчдаас 2021 оны 7 дугаар сарын 26-аас 30-ны өдрийн хооронд авсан.
4. Худалдан авах ажиллагааны бодлого, тогтолцоо, хууль тогтоомжийн талаарх гадаад улс, олон улсын байгууллагуудын хууль, дүрэм журмын харьцуулсан судалгааг хийлээ. Үүнд:
 - a. Нэгдсэн үндэстний байгууллага (цаашид “НҮБ” гэх)-ын 2020 оны Цахим засаглалын судалгаагаар цахим засаглалын хөгжлөөр дэлхийд тэргүүлж буй Дани, БНСУ, Эстони, ИБУИНВУ, Сингапур болон худалдан авах ажиллагааны цахим системийг амжилттай хэрэгжүүлсэн Гүрж, Казакстан, Итали улсуудын худалдан авах ажиллагааны хууль тогтоомж;
 - b. Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссоос 1994 онд баталсан Нийтийн худалдан авах ажиллагааны загвар хуулийг удиртгал болгон шинэчлэн найруулсан¹ тул 2011 оны Нийтийн худалдан авах ажиллагааны загвар хууль (UNCITRAL Model Law on Public Procurement 2011) (цаашид “загвар хууль” гэх);
 - c. Дэлхийн худалдааны байгууллагын Засгийн газрын худалдан авалтын хэлэлцээрт манай улс 1999 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс ажиглагчийн статустайгаар оролцож байгаа бөгөөд тус хэлэлцээрт гишүүнээр элсэхээр амлалт өгсөн тул Дэлхийн худалдааны байгууллагын Засгийн газрын худалдан авалтын хэлэлцээр;

¹ Review of the Public Procurement Legal Framework of Mongolia: 2016, p.11

- d. Европын холбооны удирдамж, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын худалдан авах ажиллагааны зарчим, Дэлхийн банк (цаашид “ДБ” гэх), Азийн хөгжлийн банк (цаашид “АХБ” гэх)-ны худалдан авах ажиллагааны журам.

Зургаа.Үнэлгээний дүгнэлт



Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд захиалагч байгууллагын төлөөллөөс судалгаа авах зайлшгүй шаардлагатай тул цахим системд бүртгэлтэй захиалагч болох төрийн байгууллага, албан газар, төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой үйлдвэрийн газар, компанийн албан хаагч, ажилтнуудаас хуулийн хэрэгжилт, түүнийг ханган ажиллахад тулгамдаж буй асуудал, цаашид хуулийг боловсронгуй болгох арга замыг тандан судлах судалгаа (цаашид “захиалагчаас авсан судалгаа” гэх)-г цахим системээр дамжуулан мэдээлэл цуглууллаа.

Цахим системд нийт 2,544 захиалагч байгууллага бүртгүүлж, цахим системээр дамжуулан тендер шалгаруулалт зохион байгуулж байна. 2021 оны 7 сарын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлээс харахад тухайн онд төлөвлөгдсөн нийт худалдан авах ажиллагааны 99.3 хувь нь цахим системээр дамжин хэрэгжсэн байна.

Хаалттай болон нээлттэй нийт 9 асуулт бүхий анкетын судалгаанд нийт захиалагч байгууллагын 288 төлөөлөгч (цахим системд бүртгэлтэй захиалагчийн 11.3 хувь) оролцсон ба тэдний 10 хүн тутмын 4-5 нь 3-аас дээш жил, 2-3 нь 1-3 жил, 3 нь 1 хүртэлх жил худалдан авах ажиллагааны чиглэлээр ажилласан байна.


Судалгаанд хамрагдсан захиалагч байгууллагын төлөөллийн ажилладаг байгууллагын дэлгэрэнгүй мэдээлэл, худалдан авах ажиллагааны чиглэлээр ажилласан хугацааг доорх зургаас харна уу.





Хуулийг хэрэгжүүлж буй захиалагч байгууллагын төлөөллөөр тус хуулийн хэрэгжилтийг үнэлүүлэхэд дундаж (3.73) үнэлгээ өгчээ. Ажиллаж буй байгууллагаар харвал орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой үйлдвэрийн газрын төлөөлөл хамгийн өндөр оноо (4), орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудын төлөөлөл хамгийн бага оноо (3.4)-г тус тус өгсөн байна.


Одоогийн хэрэгжиж буй хуулийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээ (1-5 оноогоор), ажиллаж буй байгууллагаар



Хуулийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээний дундаж хангалттай сайн төвшинд биш байгаагаас үзэхэд цаашид хууль, түүний хэрэгжилттэй холбоотой сайжруулах асуудал байна гэж дүгнэж болохоор байна. Тиймээс судалгаанд оролцогчдоос хууль, түүний хэрэгжилтийг сайжруулах зорилгоор нэн тэргүүнд өөрчлөх, сайжруулах шаардлагатай зүйлсийг тодрууллаа. Үүнээс хамгийн их саналыг дараах 5 асуудал авсан байна. Үүнд:

1. Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх нөхцөлийг тодорхой болгох;
2. Тендер шалгаруулалтыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх, тендерийн үнэлгээг боловсронгуй болгох, хүний оролцоог багасгах;
3. Нээлттэй тендер шалгаруулалтын үед тендер хүлээж авах хугацааг багасгах;
4. Харьцуулалтын аргыг шинэчлэх;
5. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмыг шинэчлэх.

Хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай хамгийн чухал асуудал



Хамгийн их санал авсан асуудал тус бүрийг тодруулж, яагаад сонгосон талаар дэлгэрэнгүй тайлбар авлаа.

Захиалагч байгууллагын төлөөлөгчид гэрээ шууд байгуулах аргыг хэрхэн хэрэглэх нь тодорхой бус байгаагаас үүдэн хууль зөрчих тохиолдол гарч байгааг дурдсан байна. Тодруулбал хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.18 дахь хэсэгт заасны дагуу гэрээ шууд байгуулахад цахим системээр нийтэлж, тендер хүлээж авах хугацааг багадаа ажлын 5 ба түүнээс дээш хоногоор тогтоон, ирсэн саналуудыг хуулийн 27, 28 дугаар зүйлийн дагуу үнэлж, гэрээ байгуулах эрхийг 29 дүгээр зүйлийн дагуу өгч байгаа нь харьцуулалтын аргаас ялгарахгүй байна, хуулийн 34 дүгээр зүйлийн хуулийн 34.1.5 дахь заалтад заасны дагуу цар тахлын үед худалдан авалт хийх заавар ойлгомжгүй мөн хуулийн 34 дүгээр зүйлд заасан бусад заалтыг хэрэглэх нөхцөл, заавар тодорхой бус байна гэжээ.

Сайжруулах, өөрчлөх шаардлагатай зүйлсийн 2-т “Тендер шалгаруулалтыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх, тендерийн үнэлгээг боловсронгуй болгох, хүний оролцоог багасгах” асуудлууд орсон байна. Захиалагчийн зүгээс тендер шалгаруулалтыг хуульд нийцүүлэн шударга, түргэн шуурхай зохион байгуулахын тулд тендер шалгаруулалтын процессыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлж, тендерийг цахим системээр үнэлж, хүний оролцоог багасгах шаардлагатай гэж үзжээ. Мөн тэд тендер шалгаруулалт бүрэн цахим хэлбэрт шилжсэнээр авлигад автахгүй эрсдэлийг бууруулна гэжээ.

Удаах байранд “нээлттэй тендер шалгаруулалтын үед тендер хүлээн авах хугацааг багасгах” гэсэн санал орсон байна. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын үзэж байгаагаар жилийн 4 улиралтай, улирлын онцлогтой ажил

гүйцэтгүүлэх үед тендер хүлээж авах хугацааг 30 ба түүнээс дээш хоногоор тогтоох нь хэтэрхий урт, гомдол гарах, тендер шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд дахин зарлаж, мөн ижил хугацаагаар тендер хүлээж авах хугацааг тогтоож байгаа нь оновчгүй зохицуулалт гэж дүгнэсэн байна. Харин барааны тендер шалгаруулалтын хувьд барааны онцлогоос хамааран тендер хүлээж авах хугацааг багасгах боломжтой гэжээ.

Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулаад амжилтгүй болсон тохиолдолд дахин харьцуулалтын аргыг хэрэглэх, гэрээ шууд байгуулах боломжгүй болсон нь оновчгүй зохицуулалт мөн харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулахад мөрдөгдөх тендерийн жишиг баримт бичиг хэт ерөнхий, шаардлага хангахгүй байгаагаас тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийг боловсруулахад төвөгтэй байна гэсэн шалтгаанаар харьцуулалтын аргыг нэн тэргүүнд шинэчлэх шаардлагатай гэж үзжээ.

Харин зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмыг хэрэглэх практик цөөхөн байдаг хэдий ч зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зарлахад төвөгтэй асуудлууд их байдаг байна. Тодруулбал хураангуй жагсаалтад заавал 3 байгууллага орсон байх шаардлагатай, хуулийн 36 дугаар зүйлийн 36.5 дахь хэсгийн дагуу дэлгэрэнгүй жагсаалтад зөвлөх нэмэх, түүнээс хураангуй жагсаалтыг хэрхэн үүсгэх нь хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, жишиг баримт бичигт нарийвчлан заагаагүй, хураангуй жагсаалтад орсон эсэх үр дүн, техникийн саналын үр дүнг хэрхэн мэдэгдэх нь тодорхойгүй, гомдол гаргах нөхцөл тодорхойгүй байна гэжээ. Мөн санхүүгийн саналыг нээх хугацааг техникийн саналын үр дүн өгснөөс хойш ажлын 5 буюу түүнээс дээш өдрөөр тогтоож байгаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанд тендер шалгаруулалт явуулах боломжийг хязгаарлаж байгааг дурдсан байна.

Одоогийн үйлчилж буй хуулийн хэрэгжилт нь нийгэм-эдийн засгийн амьдралд аливаа сөрөг нөлөөтэй байгаа эсэхийг тодруулахад нийт судалгаанд хамрагдсан албан хаагчдын 45.5% нь ямар нэг сөрөг нөлөөгүй, 6.2% нь сөрөг нөлөөтэй, 48.3% нь мэдэхгүй гэж хариулжээ. Сөрөг нөлөөтэй гэж хариулсан 18 хүнээс хэрхэн сөрөг нөлөөллийг арилгах талаар тодруулахад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах” гэж хариулсан байна. Тодруулбал хуулийн үйлчлэх хүрээг гэрээ байгуулахаар эцэслэх бус, гэрээ дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээлгэн өгснөөр эцэслэх, өмнө дурдсанчлан гэрээ шууд байгуулах арга, харьцуулалтын арга, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмыг сайжруулах шаардлагатайг дурджээ.

Ерөнхийдөө хуульд өөрчлөлт оруулах нэн шаардлагатай заалтуудыг тодруулахад хуулийн 1, 2, 4, 5, 10, 14, 16, 24, 28, 30-34, 36, 43, 44, 47, 51, 55 дугаар зүйлүүдийг нэрлэсэн байна. Захиалагч байгууллагын төлөөлөгч нараас ирсэн саналыг хавсралт-1-ээс харна уу.

Иймээс хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр тогтсон үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэрийн дагуу доорх байдлаар нарийвчилсан үнэлгээг хийж, дүгнэсэн болно.

6.1.Хуулийн үйлчлэх хүрээ, зарчим

Хуулийн үйлчлэх хүрээг зохицуулж буй 3 дугаар зүйлд 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар тус зүйлийн 1 хэсэгт, 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр хуулиар тус зүйлийн 4 хэсэгт, 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар тус зүйлийн 1 хэсэгт, 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар тус зүйлийн 2 хэсэгт, 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар тус зүйлийн 1 хэсэгт, 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар тус зүйлийн 1 хэсэгт, 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар тус зүйлийн 4 хэсэгт, 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар тус зүйлийн 1 хэсэгт, 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар тус зүйлийн 1 хэсэгт, 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар тус зүйлийн 1 хэсэгт нийт 17 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Тус хуульд нийт 28 удаа нэмэлт, өөрчлөлт орсны 11 удаагийн буюу 39.2 хувийн нэмэлт, өөрчлөлт нь хуулийн 3 дугаар зүйл болох хуулийн үйлчлэх хүрээнд хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад тус хуулийг баримтлахгүй байх хэсгийг удаа дараа нэмж оруулсан байна. Тухайлбал, хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой багаж хэрэгсэл худалдан авах, Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах (уг хэсгийг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмж, 2019 оны 3 дугаар сарын 22-ний өдрийн хуулиар хүчингүйд тооцсон.), Зөвлөлдөх санал асуулга болон сонгуулийн төв байгууллагаас Сонгуулийн тухай хуулийн 38.1-д заасан төсвийн хүрээнд сонгууль зохион байгуулахтай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах (уг хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмж, 2019 оны 3 дугаар сарын 22-ний өдрийн хуулиар хүчингүйд тооцсон.), Ирээдүйн өв сан, Ирээдүйн өв сан корпорацын үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах (уг хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмж, 2019 оны 3 дугаар сарын 22-ний өдрийн хуулиар хүчингүйд тооцсон.), Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд тусгайлан заасан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой үнэт цаас, валют худалдан авах, мөнгөн тэмдэгт хэвлүүлэх, хадгалуулах, тээвэрлэх, гадаад валютын улсын нөөцийг бүрдүүлэхтэй холбогдуулан гадаад валют, алт худалдан авах, цэвэршүүлэх, тээвэрлэх, банкны хяналт, шалгалтын хүрээнд зөвлөх үйлчилгээ авах, үндэсний төлбөрийн системийн программ хангамж, түүний тоног төхөөрөмж, эрдэнэсийн нөөц санг бүрдүүлэхэд хамаарах харилцаа (уг хэсгийг 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн.), Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авах (уг хэсгийг 2019 оны 3 дугаар сарын 22-ний өдрийн хуулиар нэмсэн.), Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч оролцуулж, зөвлөх үйлчилгээ авах (уг хэсгийг 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн.), Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх нийслэл хотын хот тохижилт, авто замын засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах (уг хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн.) харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

Гадаад орнуудын худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн харьцуулсан судалгаанаас үзэхэд Эстони, ИБУИНВУ, Гүрж, Казакстан зэрэг улсын худалдан авах ажиллагааны хуульд төрийн нууц, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой болон хүн амын тодорхой бүлгийн эрүүл мэндийн төлбөргүй үйлчилгээ үзүүлэх эмнэлгүүдэд эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийг худалдан авах, олон улсын байгууллагын хөрөнгөөр хэрэгжүүлэх худалдан авах

ажиллагаанд худалдан авах ажиллагааны хуулийг баримтлахгүй байхаар тодорхой ажил үйлчилгээ тоочсон зохицуулалт байхад мөн тухайн харилцааг тухайн зохицуулсан хуульд худалдан авах ажиллагааг хэрхэн зохицуулахаар тусгасан бол тэр хуулийг хэрэглэхээр заалтыг БНСУ², Казакстан³ улсын хуульд заасан байна.

Түүнчлэн НҮБ-ын Загвар хуульд тус хуулийг нийтийн өмчийн бүх худалдан авах ажиллагаанд мөрдөхөөр заасан байна.⁴ Загвар хуулийн дагуу зохион байгуулах батлан хамгаалах болон аюулгүй байдалтай холбоотой худалдан авах ажиллагаанд худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбоотой заалтуудыг өөрчилж тусгасан байна. Түүнчлэн батлан хамгаалах болон төрийн нууцтай холбоотой худалдан авах ажиллагаанд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг ашиглахгүй бусад журмыг хэрэглэхийг зөвшөөрсөн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт худалдан авах ажиллагааны зарчмыг дараах байдлаар тогтоосон: Үүнд.

1. Ил тод байх
2. Өрсөлдөх тэгш боломжтой байх
3. Үр ашигтай байх
4. Хэмнэлттэй байх
5. Хариуцлагатай байх.

Хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар бүх төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой (50 буюу түүнээс дээш хувь) байгууллага, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч этгээд (Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол) хуулийн дагуу худалдан авах ажиллагаагаа зохион байгуулах үүрэгтэй бөгөөд хуулийн дээр дурдсан зарчмыг баримтлахаар заасан. Өөрөөр хэлбэл худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, урилга, тендер шалгаруулалтын үр дүн, гэрээний хэрэгжилт, гэрээний үр дүн ил тод байх, өрсөлдөөнийг дэмжиж тендерт оролцогч нарыг тендерт оролцох тэгш боломжоор хангах, төсвийг хэмнэсэн, үр ашигтай худалдан авалт хийх, худалдан авалт хийхэд хуульд нийцүүлэх, хариуцлагатай байх зарчмыг баримтлах юм.

Гэвч хуулийн дагуу захиалагч бүр худалдан авах ажиллагааг зохион байгуулахад төсөв хэмнэсэн, үр ашигтай худалдан авалт хийх механизм бүрдээгүй байна. Ялангуяа одоогийн хэрэгжиж буй хууль нь бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын ашигт ажиллагааг бууруулах, зардлыг өсгөх магадлал өндөр байна. Жишээлбэл тухайн байгууллага үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийг нэг төрлийн үйлдвэрийн бүтээгдэхүүнээр дагнан худалдан авалт хийх боломжгүй, үйлдвэрлэгчээс шууд худалдан авалт хийх боломж хязгаарлагдмал (орлох бүтээгдэхүүнтэй) байгаа нь хангамжийн бараа материалын нэр төрлийг нэмэгдүүлэх, түүнтэй холбоотой зардлыг өсгөхөөс гадна, доголдолтой бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна. Хууль нь бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн

² БНСУ-ын Худалдан авах ажиллагааны тухай хууль, 4 дүгээр зүйл.

<https://www.pps.go.kr/kor/content.do?key=00176> (сүүлд үзсэн 2021.07.28)

³ The Law of the Republic of Kazakhstan No. 303-III "On Government Procurement" of 21 July 2007, Article 3.1.

⁴ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 1.

оролцоотой байгууллагын хөгжил, дэвшил саад тотгор болох учиргүй тул худалдан авах ажиллагааны эрх зүйн орчныг шинэчлэхдээ анхаарах нь зүйтэй байна.

Хуульд заасан дээрх худалдан авах ажиллагааны зарчим нь мөн гадаад орнуудын худалдан авах ажиллагааны хууль тогтоомжид заасан нийтлэг зарчим болох нь судалгаанаас харагдаж байна. Судалсан гадаад орнуудын ихэнх хууль тогтоомжид зарчмыг тухайлан нэрлэсэн байх нь нийтлэг байгаа бол зарим орны хувьд зарчмыг хэрхэн ойлгох талаар тодорхойлж томъёолсон байна. Тухайлбал, АХБ-ын худалдан авах ажиллагааны журамд худалдан авах ажиллагааны хэмнэлт, үр ашиг, шударга тэгш байдал, ил тод байдал, чанар гэсэн 6 зарчмыг заасны хамт зарчмыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:⁵


1. Хэмнэлт: Төслийн хэрэгжилтэд сөрөг үр нөлөө үзүүлэхгүйгээр үнэ, чанар болон үнийн бус бусад хүчин зүйлсийг харгалзан үзэх.
2. Үр ашиг: Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүчин чадал, цаг хугацаа, зардлын үр өгөөжийг харгалзан, шаардлагатай үр дүн ба төслийн үйл ажиллагааны үнэ цэнэ, эрсдэлийн харьцааг хангах замаар худалдан авах ажиллагааг баталгаажуулах.
3. Шударга тэгш байдал: (i) Эрх бүхий тендерт оролцогч нарт ижил тэгш боломж олгох; (ii) зээлдэгч болон бараа, ажил, үйлчилгээний нийлүүлэгчийн хооронд эрх үүргийг харилцан тэнцвэртэй хуваарилах; (iii) худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол гаргах, мэдээлэл авах найдвартай механизмыг бий болгох. АХБ нь тендер шалгаруулалтад шударга тэгш байдлыг нэмэгдүүлэхийн тулд нээлттэй тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны үндсэн арга байлгах бодлогыг дэмждэг.
4. Ил тод байдал: Холбогдох баримт бичгийг бэлтгэх, худалдан авах ажиллагааны явцыг хянах замаар (i) сонирхсон бүх этгээдийг худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг үнэ төлбөргүйгээр (эсхүл бодит өртгөөр нь), шаардлагын дагуу, цаг тухайд нь олон нийтэд нээлттэй мэдээллийн хэрэгслээр дамжуулан авах боломжоор хангах; (ii) худалдан авах ажиллагааны талаар тайлагнах тодорхой системтэй байх; ба (iii) зөвхөн хуулийн үндэслэлтэй нөхцөлд гэрээнд нууцлалтай холбоотой заалт оруулах зэргээр баталгаажуулах.
5. Чанар: Худалдан авах ажиллагааны агуулга, эрсдэл, өртөг, нарийн төвөгтэй байдлыг харгалзан, тухайн төслийн үр дүн, хөгжлийн зорилтод хүрэхийн тулд стандартын дагуу цаг хугацаанд нь үр ашигтайгаар нөөцийг ашиглах; үр дүнтэй болгох зорилгоор худалдан авах ажиллагааны хэлбэрийг зохион байгуулах.
6. Мөнгөний үнэ цэнэ: Худалдан авах ажиллагааны үндсэн зарчмыг горимын дагуу хэрэглэх замаар зээлдэгчийн нийгэм-эдийн засаг, хүрээлэн буй орчны хөгжлийн зорилтууд зэрэг бусад асуудлыг харгалзан нөөцийг үр дүнтэй, ашигтай, мөн хэмнэлттэйгээр ашиглах, үр өгөөжийг оновчтой хүртэх боломжоор зээлдэгчийг хангах. Үнэ нь дангаараа мөнгөний үнэ цэнийг хангалттай илэрхийлэх боломжгүй байж болно.

Цахим системд бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэнээс 2021 оны 7 дугаар сарын 26-аас 30-ны өдрийн хооронд хуулийн хэрэгжилтийн талаар, хуулийг боловсронгуй болгох асуудлыг тандан судлах анкетын судалгааг авсан (цаашид “тендер оролцогчоос авсан судалгаа” гэх). Хаалттай болон нээлттэй нийт 14 асуулт бүхий

⁵ АХБ-ны зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журам.1.4-р хэсэг.

уг анкетын асуулгаар судалгаанд нийт 955 оролцогч оролцсон бөгөөд тэдгээрийн 94 хувь нь тендер шалгаруулалтад оролцож байсан байна.

Тендерт оролцогчоос авсан судалгааны нийт оролцогчдоос худалдан авах ажиллагааны зарчмын хэрэгжилтийн талаар асуусан асуултад тендер шалгаруулалтад өрсөлдөх тэгш боломжоор хангадаг гэсэн хариултыг хамгийн олон буюу 357 (37.4%) удаа, харин захиалагч тендер шалгаруулалтыг явуулахдаа хариуцлагатай ханддаг гэсэн хариултыг хамгийн цөөн буюу 149 (15.6%) удаа сонгосон байна.



Түүнчлэн захиргааны хэргийн шүүхээр 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хооронд шийдвэрлэгдсэн маргааны анхан шатны шүүхийн 41 шийдвэр, давж заалдах шатны шүүхийн 21 магадлал, хяналтын шатны шүүхийн 31 тогтоол, мөн ач холбогдолтой гэж үзсэн 2014 оны давж заалдах шатны шүүхийн 1 магадлал, хяналтын шатны шүүхийн 1 тогтоол, 2017 оны анхан шатны шүүхийн 2 шийдвэр, давж заалдах шатны шүүхийн 1 магадлал, хяналтын шатны шүүхийн 1 тогтоолыг шүүхийн шийдвэрийн цахим сан (www.new.shuukh.mn), (www.shuukh.mn)-аас түүвэрлэн хийсэн судалгаа (цаашид “шүүхийн шийдвэрийн судалгаа” гэх)-аас харахад хуульд заасан худалдан авах ажиллагааны зарчмыг шүүхийн практикт дараах байдлаар дүгнэсэн байна. Үүнд:

- хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан өрсөлдөх тэгш боломжтой байх худалдан авах ажиллагааны зарчим нь мөн хуулиар тавигдсан бүхий л шаардлагуудыг адил хангасан этгээдүүдийн хувьд хамаарах бөгөөд материал дутуу ирүүлснээс тендерийн баримт бичигт заасан чадавхын шаардлага тодорхойлох шалгуур үзүүлэлт хангаагүй үндэслэлээр тендерээс хасагдсан оролцогч бусад оролцогчийн шаардлага хангасан эсэхтэй маргах байдлаар хамгаалуулах эрх биш гэж дүгнэсэн байна.⁶
- хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-д “шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй” бол тендерээс татгалзахаар хуульчилсан байхад тендерийн шаардлага хангаагүй компаниудыг тендерт оруулж, тендерт оролцогчдод

⁶ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 128/ШШ2020/0752 дугаар шийдвэр. https://shuukh.mn/single_case/7654?daterange=2019-01-01%20-%202020-12-31&id=1&court_cat=3&bb=1. (сүүлд үзсэн 2021.07.30)

тэгш бус хандсан нь хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчимд нийцээгүй гэж дүгнэсэн байна.⁷

- Толгой компани нь өөрийн хараат компанитай нэг тендерт оролцсон нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан зарчимд нийцээгүй тухай нэхэмжлэлийн шаардлагыг Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс “СМГ” ХХК болон “М” ХХК-ууд нь тус тендер шалгаруулалтад тус тус оролцсон, тэдгээрийн хооронд хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6.б-д заасанчлан хамтран ажиллах гэрээ байгуулаагүй ...” гэж дүгнэсэн⁸ бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасан нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа нь төсвийн хөрөнгийг хариуцлагатайгаар, эдийн засгийн хэмнэлттэй, үр ашигтай байдлаар тендерт оролцогчдод ил тод байх, өрсөлдөх тэгш боломжийг олгохыг ойлгоно. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д “тендерт оролцогч” гэж захиалагчаас хараат бус дараах этгээдийг ойлгоно”, 5.1.6.а-д “дангаараа тендер ирүүлсэн этгээд”, 5.1.6.б-д “хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендер ирүүлсэн хэд хэдэн этгээд” гэж зааснаас үзэхэд гомдолд заасан тендерт оролцогч “М” ХХК, “СМГ” ХХК нь захиалагчаас хараат бус, дангаараа тендер ирүүлсэн этгээдүүд байх тул хуулийн шаардлагад нийцсэн байна” гэж дүгнэсэн байна.⁹
- Хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт зааснаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь “захиалагч хууль зөрчсөн” гэх үндэслэлээр тендерийг хүчингүй болгох эрхтэй болохоос “шаардсан баримтыг ирүүлээгүй” гэх үндэслэлээр тендерийг хүчингүй болгох эрхгүй тул хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар худалдан авах ажиллагаанд үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг Сангийн яам зөрчиж, өөрт олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн, хуульд заагаагүй үндэслэлээр тендерийг хүчингүй болгосон гэж Улсын дээд шүүхийн тогтоолд дүгнэсэн байна.¹⁰

Хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, энэхүү хуулийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан нь хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан захиалагчийн зөвхөн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах харилцааг зохицуулж байгаа гэж үзэх нөхцөл үүссэн байгаа тул захиалагчийн төсвийн хөрөнгөөс бусад өөрийн хөрөнгө, зээл, тусламж, хандивын хөрөнгө, бусад эх үүсвэрийн дагуу худалдан авах харилцааг уг хуулиар зохицуулахаар тусгах нь зүйтэй байна.

Түүнчлэн төрийн нууц, үндэсний аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөхгүй өөр

⁷ Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 15 дугаар шийдвэр. <http://new.shuukh.mn/zahirgaanhan/6838/view> (сүүлд үзсэн 2021.07.30)

⁸ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 128/ШШ20200367 дугаар шийдвэр. <http://new.shuukh.mn/zahirgaanhan/6647/view> (сүүлд үзсэн 2021.07.30)

⁹ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 480 дугаар магадлал. <http://new.shuukh.mn/zahirgaadah/3737/view> (сүүлд үзсэн 2021.07.30)

¹⁰ Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх худалдааны 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 09 дүгээр тогтоол. <http://new.shuukh.mn/zahirgaahyanal/660/view> (сүүлд үзсэн 2021.07.30)

журмаар зохион байгуулах, тэдгээр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбоотой зохих хязгаарлалтыг хуульд оруулах зэрэг НҮБ-ын Загвар хуулийн үзэл баримтлалыг хуульд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан худалдан авах ажиллагааны зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх хэрэгжүүлэх талаар хуульд тусгах, ингэхдээ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн зарчмыг хэрэгжүүлэх зарчимд нийцүүлэн боловсруулах нь зүйтэй байна.

6.2.Худалдан авах ажиллагааны журам, тэдгээрийн хэрэглээ

Хуулийн 7 дугаар зүйлд захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад баримтлах тендер шалгаруулалтын дараах журмыг заасан байна. Үүнд:

1. нээлттэй тендер шалгаруулалтын журам;
2. тендер шалгаруулалтын онцгой журам;
3. зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам.
4. олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам.

Мөн захиалагч ерөнхий гэрээ байгуулан бараа, үйлчилгээ худалдан авах талаар хуулийн 8 дугаар зүйлийн 8.11 дэх хэсэгт, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар сонгон шалгаруулж болохыг хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт, бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авч болох талаар мөн зүйлийн 7.3 дахь хэсэг тус тус заасан байна.

Хуульд тендер шалгаруулалтын онцгой журам, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам, олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөхөөр заасан байна.

Тендер шалгаруулалтын онцгой журмыг хуулийн гуравдугаар бүлэгт хуульчилж, уг журмын дагуу тендер шалгаруулалтыг явуулахад хязгаарлагдмал тендер шалгаруулалт, харьцуулалт, гэрээ шууд байгуулах гэсэн 3 аргыг хэрэглэхээр зааж, тус бүрийг хуулийн 32, 33, 34 дүгээр зүйлд заасан байна.

Дэлхийн банкнаас боловсруулсан 180 улсын нийтийн худалдан авах ажиллагааны зохицуулалтын системд үнэлгээ хийсэн 2017 оны тайланд¹¹ Узбекистан, Мавритан улсын хувьд мэдээлэл байхгүй, 22 улс¹² тендер шалгаруулалтын арга ашигладаггүй бол 156 (86.6%) улсын хувьд тендер шалгаруулалтын аргыг худалдан авах ажиллагаанд ашигладаг байна.

Түүнчлэн гадаад орнуудын худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн харьцуулсан судалгаанаас үзэхэд худалдан авах ажиллагаанд баримтлах өрсөлдөөнт болон өрсөлдөөнд бус дараах журам, аргыг хэрэглэж байна. Үүнд:

1. Нээлттэй тендер шалгаруулалт
2. Хязгаарлагдмал тендер шалгаруулалт

¹¹ The World Bank (2016). Benchmarking Public Procurement 2017: Assessing Public Procurement Regulatory Systems in 180 Economies.

¹² Antigua and Barbuda, Bahamas, The Barbados, Belize, Central African Republic, Djibouti, Equatorial Guinea, Guatemala, Guinea-Bissau, Indonesia, Iraq, Jordan, Kiribati, Mozambique, Myanmar, Namibia, Nigeria, Saudi Arabia, Sudan, Suriname, Swaziland, Vanuatu

3. Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалт
4. Гэрээ шууд байгуулах
5. Цахим үнийн санал дуудах ажиллагаа
6. Инновацийн түншлэл
7. Нэг эх үүсвэрээс шууд худалдан авах
8. Зөвлөх сонгох
9. Өрсөлдөөнт хэлэлцээ
10. Ерөнхий гэрээ.

НҮБ-ын Загвар хуульд тендер шалгаруулалтын дараах журмыг заасан байна. Үүнд:¹³

- a. Нээлттэй тендер (open tendering)
- b. Хязгаарлагдмал тендер (restricted tendering)
- c. Үнийн санал авах (request for quotation)
- d. Хэлэлцээ хийхгүйгээр санал авах (request for proposal without negotiation)
- e. Хоёр үе шаттай тендер (two-stage tendering)
- f. Уулзалт хийж санал авах (request for quotation with dialogue)
- g. Удаа дараагийн хэлэлцээ хийж үнийн санал авах (request for proposal with consecutive negotiations)
- h. Өрсөлдөөнт хэлэлцээ (Competitive negotiation)
- i. Цахим үнийн санал дуудах ажиллагаа (electronic reverse auction)
- j. Нэг этгээдээс худалдан авах (single source procurement)
- k. Ерөнхий гэрээ (framework agreement).

Загвар хуулийн 29, 30 дугар зүйлд зааснаас бусад тохиолдолд захиалагч нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.¹⁴

Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмыг хуулийн 45 дугаар зүйлд зааснаар дараах нөхцөлд хэрэглэнэ:¹⁵

- a. Худалдан авах ажиллагааг зөвхөн цөөн тооны этгээд гүйцэтгэх боломжтой бөгөөд нарийн төвөгтэй, тусгай мэргэжлийн чадвар шаардлагатай бол
- b. Олон тооны тендерийг хянан үзэж, үнэлэх нь цаг хугацаа, өртөг зардлын хувьд тухайн худалдан авах ажиллагааны үнэ цэнд тэнцвэртэй биш бол.

Дээрх нөхцөлд захиалагч үнийн санал авах, хэлэлцээ хийхгүй санал авах аргыг ашиглана.

Захиалагч хуулийн 48 дугаар зүйлд зааснаар дараах нөхцөлд хоёр үе шаттай тендер шалгаруулалтыг явуулж болно:¹⁶

- a. Тендерт оролцогчтой хэлэлцэн худалдан авах зүйлийг гол чухал асуудлыг тодорхойлж, хуулийн 10 дугаар зүйлд заасан асуудлыг нарийвчлан тодруулснаар тухайн худалдан авах зүйлийн талаарх хангалттай шийдлийг олж чадна гэж захиалагч үзсэн.
- b. Нээлттэй тендер шалгаруулалтад нэг ч тендер ирээгүй эсхүл нээлттэй тендер дахин зарлахад адил нөхцөл үүсэх нь тодорхой гэж үзвэл.

Хуулийн 52 дугаар зүйлд зааснаар дараах нөхцөлийн үед захиалагч нэг этгээдээс худалдан авах ажиллагааг хэрэглэнэ:¹⁷

¹³ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 27.

¹⁴ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 28.1.

¹⁵ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 29.1.

¹⁶ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 30.1.

- a. Тухайн худалдан авах зүйлийг зөвхөн нэг этгээдээс авах боломжтой эсхүл тухайн зүйлийг орлуулах боломжгүй худалдан борлуулах онцгой эрхтэй этгээд байгаа, худалдан авах ажиллагааны бусад журмыг баримтлах боломжгүй нөхцөлд
- b. Онц чухал шаардлагатай бөгөөд тендер шалгаруулалтын бусад журмыг хэрэглэх цаг хугацааны хувьд боломжгүй гамшгийн нөхцөлд
- c. Захиалагчийн худалдан авсан бараа, тоног төхөөрөмж, технологи, үйлчилгээнд нэмэлт нийлүүлэлт шаардлагатай бөгөөд өмнөх нийлүүлэгчээс авах нь үнийн хувьд ашигтай, өөр этгээдээс худалдан авах бараа, үйлчилгээ нь таарахгүй байгаа нөхцөлд
- d. Улсын онц чухал аюулгүй байдлыг хамгаалах шаардлагаар тендер шалгаруулалтын бусад журмыг хэрэглэх нь тохиромжгүй гэж захиалагч үзсэн бол.

Тухайн улсын зөвшөөрөл олгосноор тус улсын нийгэм-эдийн засгийн бодлогыг хэрэгжилтийг хангахад тухайн нэг этгээд хэрэгжүүлэх нь тохиромжтой бөгөөд түүнээс бусад этгээд тухайн улсын бодлогыг хэрэгжүүлэх чадамжгүй гэж үзсэн бол.

Түүнчлэн гэнэтийн болон онцгой нөхцөл байдлын үед тендер шалгаруулалтыг хэрхэн зохион байгуулдаг талаар гадаад орнуудын хууль тогтоомжид гэрээ шууд байгуулах аргыг ашиглахаар нийтлэг зохицуулсан байна. НҮБ-ын Загвар хуульд гэнэтийн болон онцгой нөхцөл байдлын үед хуулийн 51 дүгээр зүйлд зааснаар захиалагч өрсөлдөөнд хэлэлцээг дараах нөхцөлд хэрэглэхээр заажээ. Үүнд:¹⁸

- a. Нээлттэй тендер шалгаруулалт болон бусад өрсөлдөөнд тендер шалгаруулалтын журмыг хэрэглэх хугацааны хувьд боломжгүй яаралтай шаардлагатай худалдан авах ажиллагааны үед,
- b. Нээлттэй тендер шалгаруулалт болон бусад өрсөлдөөнд тендер шалгаруулалтын журмыг хэрэглэх хугацааны хувьд боломжгүй гамшгийн нөхцөлийн үед,
- c. Улсын онц чухал аюулгүй байдлыг хамгаалах шаардлагаар өрсөлдөөнд аливаа журмыг хэрэглэх нь тохиромжгүй гэж захиалагч үзсэн бол.

Дээр дурдсан a, b-д заасан нөхцөлд болон онц чухал шаардлагатай бөгөөд тендер шалгаруулалтын бусад журмыг хэрэглэх цаг хугацааны хувьд боломжгүй гамшгийн нөхцөлийн үед тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэхийг хэрэгжүүлэхгүй байж болохоор заасан.¹⁹

Загвар хуульд зааснаар дараах нөхцөлд бараа, ажил, үйлчилгээг ерөнхий гэрээний журмын дагуу худалдан авдаг байна:

1. Захиалагчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох боломжгүй эсхүл тогтоосон хугацааны туршид байнгын давтамжтай худалдан авах бараа, ажил, үйлчилгээг бол;

2. Тогтоосон хугацааны туршид яаралтай худалдан авах хэрэгцээ шаардлага бүхий бараа, ажил, үйлчилгээ бол.

НҮБ-ын Загвар хууль, Эстони, ИБУИНВУ-ын хууль, АХБ болон ДБ-ын худалдан авах ажиллагааны журамд тендер шалгаруулалтын үнэлгээг ямар

¹⁷ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 52, 34.4, 36.6.

¹⁸ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 30.4.

¹⁹ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 34.6.

субъект гүйцэтгэх талаар тодорхой заагаагүй байхад Гүрж улсын худалдан авах ажиллагааны хуульд 3 хүний бүрэлдэхүүнтэй тендерийн хороо цахим тендерийг зохион байгуулахаар заасан байна. Захиалагч байгууллагын төлөөлөл тендерийн хорооны даргаар ажиллах бөгөөд хорооны дарга нь тухайн байгууллагын орлогч дарга эсхүл бүтцийн нэгжийн дарга байна. Хэрэв хорооны гишүүдийн тоо хангалтгүй байх тохиолдолд захиалагч байгууллагын ажилтнуудаас томилж болохоор заасан байна.²⁰

Манай улсын хууль заасан тендер шалгаруулалтын журам нь НҮБ-ын 1994 оны Загвар хуульд нийцүүлсэн боловсруулсан байх тул олон улсад нийтлэг хэрэглэж буй худалдан авах ажиллагааны журамтай нийцэж байна. Журмыг сонгоход босго үнийг баримталж байгаа жишиг мөн нийтлэг байна. Гэвч тендер шалгаруулалтын журам ялангуяа тендер шалгаруулалтын онцгой журам, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмыг ойлгомжтой тодорхой болгох шаардлага үүссэн байгаа нь захиалагчаас авсан судалгаанаас харагдаж байна. Тухайлбал зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмыг хуулийн 4 дүгээр бүлэгт тусгайлан заасан боловч уг журмын дагуу хэрэгжиж буй үе шат бүрд захиалагчийн шийдвэр гаргах, түүнд холбоотой хугацаа зэрэг нь тодорхойгүй байдаг. Тухайлбал, хуулийн 36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсэгт “Захиалагч энэ хуулийн 37-39 дүгээр зүйлийн дагуу техникийн болон санхүүгийн саналыг үнэлж, сонгосон зөвлөхтэй хийсэн хэлэлцээр амжилттай болсон тохиолдолд түүнд энэ хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу гэрээ байгуулах эрх олгоно.” гэж зааснаар захиалагч аливаа шийдвэрийг зөвхөн зөвлөхийн техникийн болон санхүүгийн саналыг үнэлсний дараа олгох агуулгатай байгаа нь зөвлөх үйлчилгээний тендерийн жишиг баримт бичгийн холбогдох заалтаас зөрүүтэй байдлыг үүсгэж байна. Нөгөө талаар тендерт оролцогчоос өөрийн тендерт холбоотой зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, захиалагчийн хууль бус гэж үзсэн үйлдэл, эс үйлдэхүйг шалгуулах эрхийг хэрэгжүүлэхэд цаг хугацааны төөрөгдөл үүсгэж байна.

Түүнчлэн тендер шалгаруулалтын онцгой аргыг зөв хэрэглэх нөхцөл үндэслэлийг нарийвчлан хуульд зааж өгөх шаардлагатай байна. Цаашид тендер шалгаруулалтын журмыг цахим системд нийцүүлэн боловсруулах нь зүйтэй байна. Захиалагчаас авсан судалгаанд тендер шалгаруулалтад оролцогчид оролцож сурсан тул тендер ирүүлэх хугацааг багасгах тухай санал болон гадаад орнуудын тендер илгээх хугацаа тогтоож буй жишигт үндэслэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсанаас хойш 1 сарын дотор цахим системээр нийтэд мэдээлж байгаа зэрэг мэдээллийн ил тод байдал хангагдсан байдал, тендерт оролцогчдын 94.5% нь цахим системээр дамжуулан мэдээлэл авдаг тухай тендерт оролцогчоос авсан судалгаанаас харахад зарим тендер шалгаруулалтын журмын дагуу тендер ирүүлэх хугацааг багасгах боломжтой байдлаар хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

6.3.Тендерийн урилга зарлах, тендерийн баримт бичиг, тэдгээртэй холбоотой мэдээллийг олгох хэлбэр

Хуульд тендер шалгаруулалтын мэдээллийг ил тод, нээлттэй зарлаж, сонирхсон этгээдэд саадгүй олгох, тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүнг нийтэд мэдээлж, цахим системд зарлах зохицуулалтыг тусгасны дагуу Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах

²⁰ Law of Georgia on Public Procurement, Гүржийн худалдан авах ажиллагааны тухай хууль. Бүлэг 11.

ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”, Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар баталсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендер оролцогчдод ил болгох журам”-аар эдгээр харилцааг тухайлан зохицуулж байна.

Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт тендерийн урилгад дараах мэдээллийг тусгахаар заасан байна. Үүнд:


- 21.5.1.захиалагч байгууллагын тодорхойлолт;
- 21.5.2.худалдаж авах бараа, ажил, үйлчилгээний товч агуулга;
- 21.5.3.тендерийн баримт бичиг, бусад мэдээлэл авах, тендер ирүүлэх хаяг;
- 21.5.4.тендерийн баримт бичгийн үнэ;
- 21.5.5.тендер шалгаруулалтад тавих тусгай шаардлага;
- 21.5.6.тендер хүлээн авах эцсийн хугацаа;
- 21.5.7.тендер нээх хугацаа;
- 21.5.8.гадаадын этгээдийг оролцуулах эсэх;
- 21.5.9.давуу эрх олгох эсэх.

Захиалагч техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд анхаарах асуудлыг хуулийн 11 дүгээр зүйлд тодорхой зааж өгсөн бөгөөд техникийн тодорхойлолтод барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихыг зөвшөөрөхгүй бөгөөд техникийн тодорхойлолтыг “тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлох” гэж тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуурыг тусгасан байна.

Түүнчлэн захиалагч техникийн тодорхойлолт бэлтгэхэд гол баримтлах зарчим бол өрсөлдөх тэгш боломжийг хангах асуудал тул техникийн тодорхойлолтыг боловсруулахад өрсөлдөөн хязгаарласан аливаа шалгуур үзүүлэлтийг тавихыг хуулиар хориглож байна.

Тендер оролцогчоос авсан судалгаанд захиалагч тендерийн баримт бичигт өрсөлдөөнийг дэмжсэн шалгуур үзүүлэлт тавьдаг эсэх тухай анкетын асуултад судалгаанд оролцогчдын 545 (57.1%) буюу олонх нь тийм гэж хариулсан байна. Түүнчлэн 2019, 2020 онд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт тендерийн баримт бичигт өрсөлдөөн хязгаарласан талаар ирсэн гомдол, маргааны 46%²¹ нь хууль зөрчсөн гэж шийдвэрлэснээс дүгнэхэд тендерийн баримт бичгийг боловсруулахад

Захиалагч өрсөлдөөнийг дэмжсэн шалгуур үзүүлэлт, шаардлагыг тендерийн баримт бичигт оруулдаг уу?



■ Тийм ■ Үгүй ■ Мэдэхгүй


²¹ ШӨХТГ-ын 2019, 2020 оны судалгаа. 2021.09.20-ны өдрийн 01/1789 тоот албан бичгийн хавсралт

өрсөлдөх тэгш боломжийг хангах асуудлыг захиалагч анхаарч байгаа гэж үзэх талтай ч нийт оролцогчдын 43% нь өрсөлдөөнийг дэмжсэн шалгуур үзүүлэлтийг заадаггүй буюу мэдэхгүй гэж хариулсан байгаа нь хуульд заасан өрсөлдөх тэгш боломжийг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод зүй зохистой тусгах асуудлыг анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Захиалагч хуульд заасны дагуу тендерийн баримт бичгийг бэлтгэх бөгөөд хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт “Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.” гэж заасан шаардлагыг хангуулах үүрэгтэй.

Тендерт оролцогчоос авсан судалгаанд захиалагчийн боловсруулсан тендерийн баримт бичиг ойлгомжтой, хялбар байдаг гэж судалгаанд оролцогчийн 754 (79%) буюу дийлэнх олонх нь үзсэн байхад 21% нь ойлгомжтой, хялбар байдаггүй тухай дурдсан байна.


Тендерт оролцогчид захиалагч тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтыг бүрэн боловсруулдаггүй, найруулгын алдаатай (хоёрдмол утгатай), ойлгомжгүй, тодорхой бус шалгуур үзүүлэлтийг заадаг нь заавал тодруулга авах нөхцөл үүсгэдэг талаар талаар дурдаж, шаардлагагүй хэт олон баримт бичиг, нотариатаар гэрчлүүлэх зэрэг шаардлага тавьдаг талаар санал ирүүлсэн байна. Түүнчлэн цахим хэлбэрт шилжсэн баримт бичгийг цаасаар шаардах тохиолдол гардаг талаар дурдаж, нийгмийн даатгалын дэвтэр шаардаж буйг жишээ болгон бичжээ. Оролцогчийн хариултыг доор графикт үзүүлэв.



Судалгаанд оролцогчид тендер шалгаруулалтын мэдээлэл, тендерийн урилгыг цахим системээс авдаг гэж дийлэнх олонх болох 902 (94.5%) оролцогч

хариулсан бол удаах эх сурвалжид захиалагч байгууллагын цахим хуудас 10.4%, сонин 10.1%, бусад 7.9% гэж тус тус хариулсан байна.

Сонирхож буй тендер шалгаруулалтын талаарх мэдээллийг аль сувгаар авч байна вэ?



Түүнчлэн тендер шалгаруулалтын үр дүн болох тендерт шалгарсан, шалгараагүй, татгалзсан тухай захиалагчийн шийдвэрийг цахим системээс авдаг гэж дийлэнх олонх болох 747 (78.1%) оролцогч хариулсан бол удаах хэлбэрт цахим шуудангаар 35.9%, очиж авдаг 16.1%, шуудангаар 16%, бусад 5% гэж тус тус хариулсан байна.

Тендерт шалгарсан болон шалгараагүй тухай захиалагчийн шийдвэрийг ямар хэлбэрээр хүлээж авдаг вэ?



Үүнээс харахад уламжлалт мэдээллийн хэрэгсэл болох сонин, шуудангийн байгууллагаар дамжуулан мэдээлэл авах байдал багасаж, нийгмийн чиг хандлага, техник технологийн ололтод тулгуурласан цахим хэрэглээ маш өндөр байгаа нь цахим хэлбэрээр тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүнг хүлээн авч, танилцаж байгаагаас тод харагдаж байна.

БНСУ, Эстони, ИБУИНВУ, Гүрж, Казакстан, Сингапур зэрэг улсын хуульд тендерийн урилга, тендерийн баримт бичгийг цахим системээр нийтэд зарлах талаар зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал, Гүрж улсын худалдан авах ажиллагааны тухай хуульд тендерийн хорооноос цахим тендерийн урилга, тендерийн баримт бичгийг захиалагч байгууллагын өмнөөс цахим системд Гүрж

хэлээр нийтлэхээр заасан байна.²² Хэрэв худалдан авах барааны төсөвт өртөг 2 сая гүрж лира болон дээш бол, ажил 4 сая гүрж лирагаас дээш бол цахим тендерийн урилгыг Англи хэлээр худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлдэг байна. Тендерийн үр дүн, гэрээний хэрэгжилтийн мэдээллийг мөн цахим системд нийтлэх зохицуулалттай байна.

Сингапур Улсын хувьд худалдан авах ажиллагааны www.gebiz.gov.sg цахим системд тендерийн урилгыг нийтэлдэг бөгөөд цахим системд бүртгүүлснээр тендерийн баримт бичиг татаж авах, тендер шалгаруулалтын дэлгэрэнгүй мэдээлэл авах, үр дүнтэй танилцах боломжтой байдгаараа онцлогтой байна. Тендерийн үр дүн, гэрээний хэрэгжилтийн мэдээллийг мөн системд нийтлэхээр зохицуулжээ.

Харин НҮБ-ын Загвар хуульд тендер шалгаруулалтын журмаас хамаарч тендерийн урилгыг олон нийтэд нийтлэх талаар зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал нээлттэй тендер шалгаруулалт, хоёр үе шаттай тендер болон хуулийн 53 дугаар зүйлд заасан цахим үнэ хаялцуулах ажиллагааны урилгыг нийтэд зарлан мэдээлнэ. Урилгыг гадаадын тендерт оролцогч оролцох боломжтой байдлаар олон улсад зарлана. Гэхдээ уг Загвар хуулийн 18 дугаар зүйлийн дагуу зохион байгуулж буй урьдчилан сонголтын ажиллагаанд урилга нийтлэхийг шаардахгүй. Түүнчлэн дотоодын оролцогчдын сонирхлыг татах бага үнийн дүнтэй худалдан авах ажиллагааны урилгыг олон улсад зарлан нийтлэхийг шаардахгүй байна.²³ Хязгаарлагдмал тендер шалгаруулалт, өрсөлдөөнт хэлэлцээ хийх, нэг этгээдээс худалдан авах ажиллагааны үед захиалагч худалдан авах ажиллагааны зарлалыг хэвлэлд нийтэлнэ гэж заажээ.²⁴

Гэрээ байгуулах эрх олгосон шийдвэр, ерөнхий гэрээ байгуулах шийдвэрийн талаар захиалагч нийтэд шалгарсан оролцогчийн нэр, гэрээний дүнгийн хамт нийтэлнэ. Хуульд заасан босго үнээс бага бол гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг тухай бүр нийтлэх шаардлагагүй бөгөөд захиалагч эдгээр мэдэгдлийг нэгтгэн жилд нэгээс доошгүй удаа нийтэлнэ.²⁵

Түүнчлэн Загвар хуульд цахим системд нийтлэх талаар тусгайлсан зохицуулалтыг тусгаагүй боловч загвар хуулийн удирдамжид цахим тендер шалгаруулалт, цахим хэлбэрээр урилга, тендерийн баримт бичгийн мэдээлэл олгохыг дэмжиж, нээлттэй зохицуулалтыг тусгасан байна.

Олон улсын байгууллага тухайлбал АХБ-ны худалдан авах ажиллагааны журамд шударга бус өрсөлдөөний улмаас үүсэж бий болох давуу нөхцөлийг бүрдүүлж болох бүхий л мэдээллийг нээлттэй байлгахаар заасан байна.²⁶ Худалдан авах ажиллагааны журмаас шалтгаалж тендерийн урилгыг зарлах нөхцөл хэлбэрийг өөрөөр заахаас гадна АХБ-ны цахим хуудаст нийтлэхээс гадна зээлдэгчийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэхээр заажээ. Түүнчлэн тендерийн баримт бичгийг түгээх явцад зээлдэгч цахим систем ашиглахыг АХБ-ны зүгээс дэмжих зохицуулалтыг тусгасан байна.²⁷

²² Law of Georgia on Public Procurement, Гүржийн худалдан авах ажиллагааны тухай хууль. Бүлэг 12.1.

²³ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 33.

²⁴ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 34.5.

²⁵ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 23.

²⁶ АХБ-ны зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журам.1.22-р хэсэг.

²⁷ АХБ-ны зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журам.25-р зүйл.

Хуульд заасан тендер шалгаруулалтын мэдээлэл (худалдан авах ажиллагааны төлөвлөгөө), урилга, үр дүн нийтлэх, олон нийтэд хүргэх талаар хуульд заасан зохицуулалт нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байгаа нь дээрх харьцуулах хэлбэрээр тодорхойлогдсон судалгааны үр дүнд харагдсан гэж дүгнэж байна.

Гэвч хуулийн хэрэгжилтийг үнэлэх шалтгаан болох тендер шалгаруулалтыг бүрэн цахим болгох, худалдан авах ажиллагааны хэмнэлттэй байх зарчмын хүрээнд хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.” гэж заасан сонинд хэвлэх шаардлагыг өөрчлөх нь зүйтэй байна.

Түүнчлэн гадаадын этгээд оролцох боломжтой тендер шалгаруулалтын урилгыг монгол хэлээс гадна гадаад хэлээр бэлтгэж, олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэлээр гардаг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийн хамт цахим системд урилгыг нийтэхээр хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, 21.4, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу цахим системд гадаад хэлээр бэлтгэсэн урилгыг оруулах талбар байхгүй байгааг анхаарч, цахим системд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

6.4.Тендер ирүүлэх хэлбэр

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуульд төрийн худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын үндэс суурийг хуульчлан тогтоож улмаар тус байгууллагаар дамжуулан төрийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах үндэс суурийг тавьсан.

“Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, түүний чиг үүрэг” 53 дугаар зүйлийг хуульд шинээр нэмж, хуулийн 53 дугаар зүйлийн 53.7 дахь хэсэгт “Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нийт зарлах тендерийн 20-оос доошгүй хувийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулна.” гэсэн хэсгийг оруулснаар Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 6 дугаар тогтоолоор байгуулсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар өөрийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг цахим худалдан авах ажиллагааны хэлбэрээр зохион байгуулж эхэлсэн Худалдан авах ажиллагааны газраас 2013 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 85 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг цахим систем (www.meps.gov.mn)-ээр зохион байгуулсан нь нийт худалдан авах ажиллагааны 25,6 хувийг эзэлсэн байна.²⁸

Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх асуудал үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдаж ирсэн байна. Тухайлбал, 2011 оны хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс хойш Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдлыг харахад: “Монгол Улсын Засгийн

²⁸ Худалдан авах ажиллагааны цахим хуудас, <http://www.e-tender.mn/n/421/>

газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”²⁹-т “Тендерийн будилаан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулж, захиалагч нь шийдвэрлэдэг өнөөгийн тендерийн тогтолцоог өөрчилж гүйцэтгэгч нь шийдвэрлэдэг болгох” заалт тусгагдсан байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”³⁰-ийн 5.2-д заасан эдийн засаг, бизнес, өмчийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох чиглэлийн 5.2.2-т “Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлнэ.” гэж заасан байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”³¹-ийн 3.1-д заасан “Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.” бодлогын хүрээнд 3.1.16-д “Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг хиймэл оюун ухаан, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгана.” гэж заажээ.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.4 дэх “Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх” заалтад худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлийн хүрээнд 4.1.4.1-д “тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх” үйл ажиллагааг 2016-2023 онд хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Дээр дурдсан улс төр, нийгэм, хууль эрх зүйн хүсэл эрмэлзэл, олон талын хүсэл зоригийн үр дүнд хуульд худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулахтай холбоотой хэд хэдэн удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон.

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.25 дахь заалтад “худалдан авах ажиллагааны цахим систем” гэж цахим программ хангамжийг ашиглан худалдан авах ажиллагааг төлөвлөх зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих цогц үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоог” гэж, 5.1.26 дахь заалтад “цахим худалдан авах ажиллагаа” гэж худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглан зохион байгуулах худалдан авах ажиллагааг” гэж, 5.1.27 дахь заалт “цахим дэлгүүр” гэж ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан худалдан авах ажиллагааны цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг” гэсэн тодорхойлолтуудыг шинээр нэмсэн бол хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг “худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийн төсөл, цахим тендер шалгаруулах журам, тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам, цахим худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан

²⁹ Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолын хавсралт, <https://www.legalinfo.mn/annex/details/5591?lawid=8722>

³⁰ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралт, <https://www.legalinfo.mn/annex/details/7409?lawid=12120>

³¹ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт, <https://www.legalinfo.mn/law/details/15586>

мэдээлэх журам, худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи, цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл, журам батлах” гэж өөрчлөн найруулсан байна.

Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулах болсонтой холбогдуулан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалын хавсралтаар баталж, энэ журмын хүрээнд захиалагч байгууллага Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэдээллийн систем (www.meps.gov.mn)-ийг ашиглан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулж ирсэн.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэдээллийн систем (www.meps.gov.mn)-ийн ашиглалтыг 2016 оноос зогсоож, тоон гарын үсгийг цахим тендер шалгаруулалтад ашиглах болсон мөн цахим худалдан авах ажиллагаатай холбоотой хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дүнд Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Одоогийн цахим системийг 2016 онд нэвтрүүлэхээс өмнө худалдан авах ажиллагааны цахим систем дараах байдлаар хувьсан өөрчлөгдөн байна. Үүнд:³²

- 2006 онд Засгийн газрын худалдан авах ажиллагааны портал (www.e-procurement.mn)-ыг нэвтрүүлсэн.
- 2011 онд худалдан авах ажиллагааны хяналт, үнэлгээ, шинжилгээний мэдээллийн систем (<http://pmmis.e-procurement.mn>)-ийг ашиглаж эхэлсэн.
- 2012 онд цахим худалдан авах ажиллагааны систем (www.meps.gov.mn)-ийг ашиглаж эхэлсэн бөгөөд анхны цахим тендер шалгаруулалт 2012 оны 5 дугаар сард уг системээр зохион байгуулагдсан юм. Тус системийг ашиглаж эхэлснээс хойш 2013 оны жилийн эцсийн байдлаар нийт 367 аж ахуйн нэгжүүдийг системд бүртгэж, цахим худалдан авах ажиллагааны тендер илгээх хувийн нууцлалын код (PKI)-ыг олгосон байна.³³
- Төрийн худалдан авах ажиллагаанд ашиглаж буй бие даасан системийг нэгтгэх санаачилгын хүрээнд цахим худалдан авах ажиллагааны өмнөх систем (www.meps.gov.mn)-д тулгарч байсан бэрхшээл, алдааг засварласан нэгдсэн цахим систем (www.tender.gov.mn)-ийг 2016 оноос ашиглаж эхэлсэн байна.

Цахим системийг ашиглаж эхлэхээс өмнө тендер шалгаруулалтын урилгыг Худалдан авах ажиллагааны газрын цахим хуудас (www.e-tender.mn), Сангийн яамны цахим хуудас (www.e-procurement.mn) болон цахим худалдан авах ажиллагааны систем (www.meps.gov.mn)-д тус тус нийтэлж, тендерийн үр дүнг цахим худалдан авах ажиллагааны систем (www.meps.gov.mn)-д байршуулан олон нийтэд хүргэдэг байсан байна.


Цахим систем нь мэдээллийн нэгдсэн цахим модуль, цахим тендер шалгаруулалтын модуль, нийлүүлэгчийн удирдлагын модуль, цахим дэлгүүрийн модуль, цахим шалгалт, цахим сургалтын модуль, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны мэдээлэл, гар утасны аппликейшн гэсэн үндсэн хэсгээс бүрдсэн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендер зарлах, хүлээн авах,

³² Н.Цэрэнсамбуу (2017). “Цахим худалдан авах ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын зорилт” илтгэл.

³³ Худалдан авах ажиллагааны цахим хуудас, <http://www.e-tender.mn/n/421/>


тендерийн үр дүнг мэдээлэх, гэрээ байгуулах, гомдол хүлээн авах гэсэн бүх үе шатыг хамарсан нэгдмэл систем юм.

2017-2020 онд цахимаар зохион байгуулсан тендер шалгаруулалтын хувь



Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны гүйцэтгэл /2014-2020/

Нийт худалдан авалт
/тендер шалгаруулалтын журам, арга/




Тендерт оролцогчоос авсан судалгаагаар цахим системээр зохион байгуулж буй цахим тендер шалгаруулалтад оролцоход хялбар байдлыг 1 буюу хүндрэлтэй гэснээс 5 буюу хүндрэлгүй гэж 1-5 оноогоор үнэлэхийг хүсэхэд хүндрэлгүй гэж 32.7%, хүндрэлтэй гэж 6.4% нь хариулсан байна. Цахим системийн хэрэглээний хялбар байдалд нийт судалгаанд оролцсон 955 тендерт оролцогчоос 3.8 гэсэн дундаж оноо өгсөн байна.


Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан тендер шалгаруулалтад оролцоход хялбар байдлыг 1-5 оноогоор үнэлнэ үү.



Түүнчлэн цахим системийн нууцлалд судалгаанд оролцогчдын дийлэнх олонх болох 650 (68.1%) тендерт оролцогч итгэлтэй байдаг гэж хариулсан нь иргэд, олон нийтээс цахим тендер шалгаруулалтад итгэх итгэл өндөр байгааг харуулж байна гэж дүгнэлээ.



Харин цахим системийн нууцлалд итгэлтэй бус эсхүл мэдэхгүй гэж хариулсан судалгаанд оролцогч 32%-аас шалтгааныг тодруулан асуусан хариултад шалтгааныг мэдэхгүй гэж 1.3%, системийн нууцлал, үнэлгээний хороо, захиалагчид итгэхгүй байна гэж 32.5%, мэдээлэл тарсан байдаг гэж 3.9% нь хариулсан байна. Дэлгэрэнгүй хариултыг доор байршуулав.



Тендер оролцогчоос авсан судалгааны хүрээнд цахим системийн хэрэглээг тендерт оролцогч ээлтэй гэж үзэж байгаа гэж дүгнэхийн зэрэгцээ цаашид худалдан авах ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлж, хүний оролцоог багасгах санаачилгад эерэг хандана гэж үзэж болохоор байна. Гэвч цахим системээр илгээж буй тендерийн нууцлалд эргэлзээтэй хандаж буй нийгмийн

тодорхой хэсэгт цахим системийн найдвартай байдал, тоон гарын үсэг, түүний нууцлалын талаар мэдээлэл, танилцуулга хүргэх нь зүйтэй байна.

БНСУ, Сингапур, Эстони, ИБУИНБУ, Гүрж, Казакстан зэрэг улсын худалдан авах ажиллагааны тогтолцоо цахим хэлбэрт шилжсэн байна. Эдгээр улсуудад худалдан авах ажиллагааны доорх системийг ашиглан тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж байна. Үүнд:

- БНСУ: Худалдан авах ажиллагааны цахим хуудас KONEPS /www.g2b.go.kr/
- Сингапур: <http://www.gebiz.gov.sg>
- Эстони: <https://riigihanked.riik.ee/rhr-web/#/>
- ИБУИНБУ: <https://www.contractsfinder.service.gov.uk/Search/Results>
- Гүрж: www.tenders.procurement.gov.ge
- Казакстан: www.egov.kz

Түүнчлэн Дэлхийн банкнаас боловсруулсан 180 улсын нийтийн худалдан авах ажиллагааны зохицуулалтын системд үнэлгээ хийсэн 2017 оны тайланд худалдан авах ажиллагааны цахим системтэй 154 (Монгол Улс багтсан) улс, цахим системгүй 26 улс байгаа талаар дурджээ.³⁴ Эдгээр улсуудаас 56 (Монгол Улс багтсан) улс тендерийг цахим системээр хүлээн авч, тендер шалгаруулалт зохион байгуулж байна.

Цахим худалдан авах ажиллагааны хүрээнд НҮБ-ын Загвар хууль нь худалдан авах ажиллагааны мэдээллийг интернэтэд нийтлэх, мэдээллийн технологийг тендер шалгаруулалтын процессын туршид мэдээлэл солилцох, харилцахад ашиглах, цахимаар тендер илгээх, мэдээллийн технологи, интернэтэд суурилсан тендер шалгаруулалтын арга (цахим үнэ дуудах арга, цахим ерөнхий гэрээ, цахим каталог)-ыг хэрэглэхийг дэмжсэн.³⁵ Түүнчлэн тендерийг цаасан хэлбэрээс гадна тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлж болохыг заасан.³⁶

Цахим худалдан авах ажиллагаа нь олон талын ашиг тустай болохыг НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс хүлээн зөвшөөрсөн бөгөөд цахим худалдан авах ажиллагаанаас нийтийн худалдан авах ажиллагаанд 5-аас дээш хувийн санхүүгийн ашиг гарах боломжтой тухай НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисст тайлагнасан байна.³⁷

АХБ-ны худалдан авах ажиллагааны журамд тендерт оролцогчтой харилцах, тендерийн урилга зарлан мэдээлэх, мэдэгдэл хүргүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, худалдан авах ажиллагааны баримт бичгийг тараах, тендер ба саналыг ирүүлэх, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлэх зэрэгт цахим худалдан авах ажиллагааны хэрэгслийг ашиглахыг зөвлөнө³⁸ гэж заасны хамт цахимаар дамжуулан мэдэгдэл хүргүүлэх, тендерийг хүлээн авах тохиолдолд цаг

³⁴ The World Bank (2016). Benchmarking Public Procurement 2017: Assessing Public Procurement Regulatory Systems in 180 Economies.

³⁵ The United Nations (2014), "Guide to Enactment of the UNCITRAL Model Law on Public Procurement", Vienna, Austria, Para.92. p.27.

³⁶ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 40.2.


³⁷ The United Nations (2014), "Guide to Enactment of the UNCITRAL Model Law on Public Procurement", Vienna, Austria, Para.31, p.10.

³⁸ АХБ-ны зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журам.1.35-1.36-р хэсэг.


мэдээлэх журам"-ын 5.2-т "Захиалагч хуулийн 22.2-т заасныг үндэслэн тендерийн баримт бичгийг үнэгүй олгох эсхүл 50,000.00 /тавин мянга/ төгрөгөөр худалдахаар зааж болно." гэж журамласан байна.

Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2020 онд зарласан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн баримт бичгийг нийт 1774 аж ахуйн нэгж цахим системээр дамжуулан худалдан авсан байна. Үүнээс 781 аж ахуйн нэгжээс ажил гүйцэтгэх тендерийн баримт бичгийг худалдсан авсан байна.

**Худалдан авсан тендерийн баримт бичгийн тоо
/тендер шалгаруулалтын төрлөөр/**



**Ажлын тендерийн баримт бичиг худалдан авсан тоо
/төсөвт өртгийн дүнгээр/**



Цахим системээр ажил гүйцэтгэх тендерийн баримт бичгийг худалдан авсан 781 аж ахуйн нэгжээс нийт 39,050,000 төгрөгийг зарцуулсан бол уг тендерийн баримт бичгийг тендер шалгаруулалтын цахим хэлбэрээр бус тендер шалгаруулалтын уламжлалт цаасан хэлбэрээр худалдан авахад 118,100,000 төгрөг зарцуулах байсан байна. Тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаа нь аж ахуйн нэгж байгууллагаас гарах бодит зардлыг хэд дахин бууруулсан байгаа нь зөвхөн Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2020 онд зарласан ажил гүйцэтгэх тендерийн баримт бичиг худалдан авсан дүнгээс харагдаж байна.




Тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулах нь зөвхөн тендерт оролцогчдод тендерийн баримт бичигтэй танилцах, тендерийн баримт бичиг

худалдан авах (өөрөөр хэлбэл цахим тендер шалгаруулалтын хураамж)-тай холбоотой бодит зардлыг бууруулаад зогсохгүй захиалагчийн албан хэрэгцээний урсгал зардал, тендерийн баримт бичиг архивлахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг мөн бууруулж, байгаль орчинд ээлтэй шийдэл болох нь харагдаж байна.

Жишээлбэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2017 онд 26000 гаруй тендерийн материал болох 253GB хэмжээтэй цахим тендерийн материалыг тендерт оролцогчдоос цахим системээр хүлээн авсан байна. Дунджаар 1 файл нь 50 хуудастай гэж үзвэл 1,300,000 хуудас цаастай тэнцэх бөгөөд хэрэв тендер шалгаруулалтыг уламжлалт цаасан хэлбэрээр зохион байгуулсан бол хуулбар хувийн тоотой нийлээд хамгийн багадаа 2,600,000 хуудас тендерийн материал болно. 1 хуудас цаасны жин 5г бол нийт 13тн цаас болох байсан байна.

Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.” гэж, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.4-т “Тендерийн урилга зарлан мэдээлсэн огноог цахим системд нийтэлсэн өдрөөр тооцно. Захиалагч хуулийн 21.1-д заасны дагуу өдөр тутмын сонинд нийтлэх тендерийн урилгад цахим системд нийтэлсэн огноо, бүртгэлийн дугаарыг заавал дурдана.” гэж тус тус заасан бөгөөд уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарч буй бүх түвшний захиалагч байгууллагууд тендер шалгаруулалт зохион байгуулахдаа уг тендерийн урилгыг Үндэсний өдөр тутмын сонинд нийтлүүлэх үүрэгтэй.

Тендер шалгаруулалт зохион байгуулж буй захиалагч байгууллагууд тендерийн урилга нийтлүүлэх өдөр тутмын сонин сонгохдоо харилцан адилгүй үнээр нийтлүүлдэг, тухайн нэг захиалагч байгууллагын хувьд жилийн турш өдөр тендерийн урилга нийтлүүлэх зардал нь шууд худалдан авалтын босго үнэ буюу 10 сая төгрөгт дийлэнх нь багтсан байдаг тул ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр зохион байгуулагдаж байсан байна.



Цахим системд 2020 онд **1238** захиалагч байгууллагаас нийт **22494** удаагийн тендер шалгаруулалтын урилга нийтлэгдсэн байх бөгөөд худалдан авах ажиллагааны журмаар нь авч үзвэл нээлттэй тендер шалгаруулалтын журмаар **7749**, тендер шалгаруулалтын онцгой журмаар **13267**, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар **1363**, олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар **113** удаагийн урилга тус тус нийтлэгдсэн байна.

Зөвхөн Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2020 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтын хувьд авч үзэхэд нийт 20.7 сая төгрөгийг уг зардалд санхүүжүүлсэн байх бөгөөд нийт 326 удаа тендерийн урилга нийтлүүлсэн

үүнээс 293 удаагийн урилгыг Монгол хэл дээр гарч буй сонинд, 33 удаагийн урилгыг олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр буюу Англи хэл дээр нийтлэгддэг сонинд нийтлүүлсэн байна. Энэ нь дунджаар нэг урилгыг 63,665 төгрөгөөр нийтлүүлсэн байх бөгөөд хамгийн хямдаар буюу 10,000 төгрөгөөр урилга нийтэлж байсан “Засгийн газрын мэдээ” үйл ажиллагаагаа зогсоосон тул уг тоог хасаж тооцвол дунджаар 75,972 төгрөгөөр нэг урилгыг нийтлүүлсэн байна. 2020 онд нийт зарлагдсан урилгын тоог Төрийн худалдан авах ажиллагааны газрын дунджаар тооцоолж үзвэл нийт 1.4-өөс 1.7 тэрбум төгрөгийн зарцуулалт улсын хэмжээнд уг зардалд зарцуулсан байхаар байна.

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.23, 53 дугаар зүйлийн 53.5.7 дахь заалт болон Сангийн сайдын 2017 оны 234 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий гэрээ зохион байгуулах журам”-ын дагуу тендерийн урилга нийтлүүлэх сонин шалгаруулах тендер шалгаруулалтыг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах нь захиалагч байгууллага үр ашигтай, хэмнэлттэй, ил тод, өдөр тутмын сонины үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд өрсөлдөх тэгш боломжийг хангасан худалдан авах ажиллагааны оновчтой хэлбэр болно гэж үзэж 2021 оноос нийт 8 нийлүүлэгчтэй ерөнхий гэрээ байгуулж, цахим дэлгүүрт байрлуулсан байна. 1/8 хэмжээтэй сонины урилгын ерөнхий гэрээний босго үнэ 29,000-30,000 төгрөг, 1/4 хэмжээтэй сонины урилгын ерөнхий гэрээний босго үнэ 50,000 төгрөг гэж цахим дэлгүүрт бүртгэгдсэн байна. Энэ нь цахим системийн цахим дэлгүүрийг ашиглан ерөнхий гэрээний дагуу худалдан авалт хийхэд захиалагчид гарч буй төсвийн бодит хэмнэлтийг харуулж байна.

Дээр дурдсан судалгаанд үндэслэн дүгнэхэд мэдээллийн технологи, интернэтэд суурилсан цахим тендер шалгаруулалттай холбоотой хуульд орсон өөрчлөлт нь захиалагч, тендерт оролцогчдоос гарах зардлыг бууруулж байна гэж дүгнэж байна.

Тендерт оролцогчоос авсан судалгаанаас үзэхэд 804 (84.1%) тендерт оролцогчоос цахим тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааг ил тод, шударга зохион байгуулах хэрэгсэл гэж үзсэн байна. Харин судалгаанд оролцогч аж ахуйн нэгж, иргэний 15.9% нь худалдан авах ажиллагааг ил тод, шударга зохион байгуулах гол хэрэгсэл биш эсхүл мэдэхгүй гэж хариулсан ч яагаад болохгүй байгаа тухай шалтгааныг мэдэхгүй гэж 38.2% нь хариулсан байна.

Мөн тодорхой саналгүй талаар 15.1%, тендер шалгаруулалтын үр дүнг тодорхой, дэлгэрэнгүй зарлах нь худалдан авах ажиллагааны ил тод, шударга зохион байгуулах гол хэрэгсэл гэж 11.8% нь хариулсан байна. Оролцогчоос ирүүлсэн дэлгэрэнгүй хариултыг доор байршуулав.


Цахим тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааг ил тод, шударга зохион байгуулах гол хэрэгсэл биш гэж үзсэн шалтгаан



Тендерт оролцогчоос тендер шалгаруулалтад оролцоход хамгийн бэрхшээлтэй зүйлийн талаар асуусан нээлттэй асуултад дараах хариултыг ирүүлсэн байна. Хамгийн хүндрэлтэй байгаа 3 асуудалд:

1. Төрийн байгууллагууд, банкнаас шаардлагагүй олон төрлийн тодорхойлолт шаарддаг, түүнийг нь дахин тендерт явуулах боломжгүй байдаг
2. Тендерийн баримт бичиг дэх шалгуур үзүүлэлтүүд ойлгомжгүй, шаардлагагүй хэт олон материал шаарддаг
3. Тендерийн баримт бичигт өрсөлдөөнийг хязгаарласан заалтууд оруулдаг, шинэ компанид боломж олгодоггүй.

Тендерт оролцогчид тулгарч буй бэрхшээл



Тендерт оролцогчоос авсан судалгаанд оролцсон 955 оролцогчийн 20.4% нь хуулийн хэрэгжилт, цахим системтэй холбогдуулан санал өгснөөс дараах саналууд нийтлэг байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтыг ойлгомжтой, тодорхой боловсруулах
2. Төрийн байгууллага, банкны тодорхойлолт, тендерийн баталгааг цахим болгох Цахим системийг хөгжүүлж, илүү хялбарчлах



Иймд хуулийн нэгдүгээр бүлэгт хамаарах тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолт боловсруулах, хоёрдугаар бүлгийн тендерт оролцогчийн ерөнхий нөхцөл, санхүүгийн чадавх, техникийн чадавх болон туршлагыг үнэлэх, зургаадугаар бүлгийн цахим систем, түүний программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах талаар тусгагдсан зохицуулалтыг тендерт оролцогчдод хялбар, ойлгомжтой байх шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн боловсронгуй болгох нь зүйтэй гэж дүгнэж байна.

6.5.Тендерт оролцогчийн чадварын үнэлгээ

Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавх болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлна.” гэж заасан бөгөөд хуулийн 14-16 дугаар зүйлд нийцүүлэн тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй тендерээс татгалзахаар хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасан байна.

Хуулийн 14 дүгээр зүйлд заасан дараах нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзэж тендерээс татгалзана. Үүнд:

14.1.1.төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;

14.1.2.Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;

14.1.3.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;

14.1.4.сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, энэ хуулийн 52^{1.1}-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон;

14.1.5.тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

14.1.6.илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг энэ хуулийн 52^{1.1}-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон.

Шүүхийн шийдвэрийн судалгаанаас харахад хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан ерөнхий нөхцөлөөс 14.1.3 дахь “Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй” заалтыг хангаагүй гэж тендерээс татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрсөнтэй холбоотой маргаан нийтлэг гарсан байна.

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтад үндэслэн тендерт оролцогчийн тендерээс татгалзсан нь мөн татварын илүү төлөлт болон татвар төлөх хуулийн хугацаа дуусаагүй байх шалтгаантай холбоотой байна. Татварын нэг төрөлд илүү төлөлттэй байхад нөгөө төрөлд татварын өртэй байгаа асуудлыг үнэлгээний хороо болон Захиргааны хэргийн шүүх харилцан адилгүй өөрөөр тодорхойлж байна. Тодруулбал, анхан шатны шүүх дээрх маргааныг шийдвэрлэхдээ нэхэмжлэгч татварын өртэй байсан гэж дүгнэж байхад давж заалдах⁴⁰ болон хяналтын шатны шүүх⁴¹ “татварын өргүй гэж үзнэ.”, татварын өртэй гэж үзэх нь шударга ёсонд нийцэхгүй гэж дүгнэсэн байна.

Өөрөөр хэлбэл, хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтад “Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй” гэж заасныг хэрхэн ойлгох, татварын өртэй гэж үзэх талаар шүүхийн практикт ч төлөвшөөгүй байна.

Хэрэв үнэлгээний хороог илүү төлсөн татварыг анхааран суутган тооцох үүрэгтэй гэж үзвэл татварын байгууллагын эрх хэмжээнд халдсан үйлдэл болох буюу энэ нь бүрэн эрхийн хүрээнд гаргаагүй илт хууль бус захиргааны акт болно. Учир нь татвар төлөгчийн илүү төлсөн татварыг суутган тооцох асуудал нь татварын байгууллагын эрх хэмжээний асуудал бөгөөд үнэлгээний хороо нь илүү төлсөн татварыг өөр татварын дутуу төлөлтөд шилжүүлэх эрх хуулиар олгогдоогүй байна.

Тендерт оролцогч татварын өрийн зэрэгцээ татварын илүү төлөлттэй байгаа бол эрх бүхий этгээд болох харьяа татварын байгууллагаар суутган тооцуулаад татварын өргүй болсны үндсэн дээр тендерт оролцох нь эрх зүйт ёсонд нийцнэ. Гэтэл үнэлгээний хороо болон шүүх харилцан адилгүй шийдвэрлэж байгаа нь

⁴⁰ УДШ-ийн 2014.09.29-ны өдрийн 192 тогтоол

⁴¹ ЗХДЗШШ-ийн 2014 .07.23-ны өдрийн 0298 тогтоол

хуулийн дээрх заалтыг тодорхой болгож өөрчлөх болон бусад байдлаар энэ нөхцөл байдлыг арилгах бодит шаардлага үүссэн байна.

Түүнчлэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтад заасан “гэрээний үүргээ ноцтой зөрчсөн” гэснийг харилцан адилгүй ойлгож байгаагийн зэрэгцээ Захиргааны хэргийн шүүхийн практикт ч нэг мөр хэрэглэхгүй байгааг шүүхийн шийдвэрийн судалгаанаас харагдсан.

Гэрээний үүргээ ноцтой зөрчсөн асуудал нь тухайн тендерт оролцогчийн хувийн байдлыг тогтоох шалгуур үзүүлэлт байхаар хуульчлагдсан. Энэ шалгуур бол ерөнхий нөхцөлийг магадлах чухал шалгуур боловч өмнө нь гэрээний үүргээ зөрчиж байсан эсэхийг үнэлгээний хороо шүүхийн шийдвэр шаардахгүйгээр тогтоох нь хүндрэлтэй нөхцөл бий болгосон.

Гэрээний үүргээ ноцтой зөрчсөн нь шүүхээс тогтоогдсон байх ёстой гэдэг утгаар хэрэглэвэл үнэлгээний хороонд хялбар болно. Гэвч тус заалтыг харвал шууд шүүхээс тогтоогдсон байх ёстой гэж хэрэглэх боломжгүй байна. Учир нь хуулийн бичвэр, томъёолол нь “Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, **энэ хуулийн 52.1-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон**” гэж заасан. Өөрөөр хэлбэл гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, үүргээ биелүүлээгүйг шүүх тогтоох бус үнэлгээний хороо тогтоох, харин мэргэжлийн үйл ажиллагааны алдааг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоох байдлаар зохицуулсан гэж ойлгож болохоор байна.

Хоёрдмол утга агуулгатай уг заалтыг шүүхийн практикт мөн харилцан адилгүй хэрэглэсэн байна. Тухайлбал, анхан шатны шүүх эрх бүхий байгууллага болон шүүхээр тогтоогдсон байх ёстой гэж үзэж байхад давж заалдах шатны шүүх эрх бүхий байгууллага болон шүүхээр тогтоох шаардлагагүй гэж үзсэн байна.

Хуулийн энэ зохицуулалт нь тендер сонгон шалгаруулах эрх бүхий этгээдэд нэг талаас хүндрэл учруулсан нөгөө талаас хэт субъектив байдлаар хандах буюу дур зоргоор хандах боломж бий болгосон зохицуулалт болжээ.

Үнэлгээний хороо гэрээний үүргээ зөрчсөнийг тогтоохдоо зарим тохиолдолд гэрээний үүргээ ноцтой зөрчсөн талаар шүүхийн шийдвэр байхгүй гэх үндэслэлээр шийдвэрлэхэд үнэлгээний хорооны шийдвэрийг буруутгах боломжгүй. Мөн зарим тохиолдолд гэрээний үүргийн биелэлтэд субъектив дүгнэлт хийх байдлаар гэрээний үүргээ ноцтой зөрчсөн байна гэж үзэж болно. Нэн ялангуяа шүүх магадлан шалгах ажиллагааны цар хүрээг үнэлгээний хорооны шийдвэрийг мэргэжил ур чадварын үндсэн дээр дотоод итгэлээр үнэлсэн асуудалд оролцохгүй гэх байдлаар тодорхойлох тохиолдолд гэрээний үүргээ зөрчсөнийг “зөрчөөгүй” байдлаар, зөрчөөгүйг “зөрчсөн” байдлаар тодорхойлох дур зоргоор хандах нөхцөл бий болгожээ. Иймд тус заалтыг тодорхой болгон найруулах шаардлагатай байна.

Гадаад орнуудын худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн харьцуулсан судалгаанаас дүгнэхэд тендерт оролцогч эрх бүхий байхыг магадлах дараах ерөнхий шаардлагыг хуульд заасан байна. Тухайлбал, БНСУ-ын хуульд

томоохон хэмжээний төслүүд дээр тендерт оролцогчийн чадавхыг дараах байдлаар урьдчилан хянан үздэг байна.⁴²

- Ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлага
- Техник тоног төхөөрөмжийн чадавх
- Санхүүгийн чадавх
- Найдвартай байдал

Эстони Улсын хувьд тендерт оролцогчийн чадавхын талаар бүртгэлийг хөтөлж болохоор зааж, тендерийн урилгыг уг бүртгэлд хамрагдсан оролцогчдод илгээх зохицуулалтыг Худалдан авах ажиллагааны хуульд заасан байна.⁴³ Түүнчлэн дараах ерөнхий нөхцөлийг хангаагүй бол тендерээс татгалзахаар зохицуулсан байна. Үүнд:

1. гэмт хэрэг, терроризм, мөнгө угаалт ... гм үйлдсэн;
2. тухайн улсад албан ёсны эрхгүйгээр бизнес эрхэлсэн;
3. хүүхдийн хөдөлмөр мөлжсөн эсхүл хүний наймаа эрхэлсэн;
4. татвар хураамж, НДШ төлөөгүй; ба
5. Олон улсын хар жагсаалтад орсон.

Дээр дурдсан 1-аас 3-д заасан шалтгааны хувьд “Гэмт хэргийн үндэсний дата бааз”-аас мэдээлэл нь устаагүй гэхдээ тухайн хэрэг үйлдсэнээс хойш 5 жилийн дотор бол тендерээс татгалзана. Мөн гэрээ байгуулахаас өөр арга байхгүй, тухайн тендерт оролцогчийг хасвал гэрээ байгуулах өөр ямар ч боломжгүй тохиолдолд захиалагч дээрх 5 шалтгаанаар тендерээс татгалзахгүй байж болох өвөрмөц зохицуулалтыг хуульд мөн тусгасан байна.

ИБУИНВУ-ын хувьд тендерт оролцогч нь дараах ерөнхий нөхцөлийг хангаагүй бол тендер шалгаруулалтад тухайн оролцогчийг оруулахгүй байна. Үүнд:

1. гэмт хэрэг үйлдсэн, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэгтэй холбоотой;
2. авлигын хэрэгт холбогдсон;
3. авлига өгсөн;
4. орлогоо нуусан, хулгай хийсэн, хуурамч худалдаа арилжаа хийсэн, татвар төлөхөөс зайлсхийсэн, гэмт хэргийг нотлох баримтыг устгасан, нуусан, залилантай холбоотой хуульд заасан аливаа залилан гэх мэтийг үйлдсэн;
5. терроризмтой тэмцэх хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн;
6. мөнгө угаасан;
7. эрүүгийн гэмт хэргийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн;
8. цагаачлалын тухай хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн;
9. сексийн гэмт хэргийн эсрэг хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн;
10. хар тамхитай тэмцэх хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн;

Эдгээр зөрчил нь зөвхөн тухайн тендерт оролцогч аж ахуйн нэгж болон түүний эсхүл түүнийг удирдах байгууллагын удирдлага, захиргааны гишүүдэд мөн хамаатай гэж нэлээд өргөн хүрээнд зохицуулсан байна.

Татварын өр төлбөргүй байх нь тендерт оролцогчийн ерөнхий нөхцөлийг тогтоох шалгуур байх бөгөөд энэ тохиолдолд тендерээс татгалзах талаар Эстони, Казакстаны хууль тогтоомжид заасан байхад ИБУИНВУ-ын хувьд зөвхөн татвар,

⁴² <https://www.pps.go.kr/eng/content.do?key=01158>

⁴³ Худалдан авах ажиллагааны хуулийн 164-р хэсэг.

хураамж, нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй нь шүүх хяналтын байгууллагаар тогтоогдсон бол, захиалагч тухайн тендерт оролцогч нь татвар, хураамж, нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй гэдгийг зохих ёсны нотолгооны дагуу мэдэж байгаа бол, эсхүл дээр дурдсан зөрчил нь тухайн оролцогч татвар, хураамж, нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр хүчингүй болох буюу тухайн оролцогчийг хасах үндэслэл болохгүй бол гэсэн 3 үндэслэлээр татвартай холбоотой асуудлаар тендерээс татгалзахаас бусад тохиолдолд тухайлбал өчүүхэн хэмжээний татвар, хураамж, нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй, тендер нээхээс өмнө шахуу хугацаанд энэ төлбөрийн мэдээллийг мэдсэн зэрэг татвар, хураамж, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой нөхцөлийн нөлөөлөл нь хэт бага гэж үзсэн тохиолдолд захиалагч түүнийг харгалзахгүй байж болохоор заасан байна.

НҮБ-ын Загвар хуулийн хувьд тухайн улсын хуулиар улсын харьяалалд үндэслэн тендер шалгаруулалтад оролцохыг тухайлан зааснаас бусад тохиолдолд захиалагч тендер шалгаруулалтад аль ч улсын харьяалалтай тендерт оролцогчийг оролцохыг зөвшөөрөхөөр заасан.⁴⁴ Захиалагчаас тухайн тендер шалгаруулалтын нөхцөл шаардлагад тохиромжтой гэж үзсэн дараах ерөнхий шаардлагыг тендерт оролцогчид тавихаар заасан байна. Үүнд:⁴⁵

- a. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн, техникийн болон байгаль орчны мэргэшил, мэргэжлийн болон техникийн чадвар, санхүүгийн нөөц, тоног төхөөрөмж болон бусад биет байгууламж, менежерийн чадвар, найдвартай байдал, туршлага, хүний нөөцтэй байх.
- b. Тухайн улсад мөрдөж буй ёс зүй, бусад стандартад нийцсэн байх.
- c. Гэрээ байгуулах эрх зүйн чадамжтай байх.
- d. Төлбөрийн чадваргүй болоогүй байх, аливаа этгээдийн өмнө өр төлбөр хүлээх үүрэг хүлээсэн этгээд биш байх, дампуурсан эсхүл татан буугдаж байгаа нөхцөл үүсээгүй байх, хэрэг нь шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа нөхцөл үүсээгүй байх, бизнесийн үйл ажиллагааг түр зогсоогоогүй байх бөгөөд дээр дурдсан асуудлаар аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч биш байх.
- e. Татвар төлөх болон тухайн улсын нийгмийн хариуцлагатай холбоотой төлбөрийн үүргийг бүрэн гүйцэтгэсэн байх.
- f. Тендерт оролцогч, түүний удирдлага эсхүл ажилтан нь мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасны улмаас эрүүгийн хариуцлага хүлээсэн, эсхүл тендерт оролцогч тухайн улсын хуульд заасан хугацаанд тендер шалгаруулалтад оролцоход өөрийн ерөнхий нөхцөлийн талаар худал мэдээлэл бүхий тендер ирүүлсэн, эсхүл захиргааны шийдвэрээр ерөнхий нөхцөл хангахгүй болохгүй тогтоосон, эсхүл эрхээ хязгаарлуулсан зэрэг нөхцөл үүсээгүй байх.

Дээр дурдсан тендер оролцогчийн чадварын ерөнхий нөхцөлийг тодорхойлох үндсэн шаардлагаас гадна тендерт оролцогч бусад тендерт оролцогчоос хамааралгүй бие даан нэг тендер ирүүлсэн гэдгийг тогтоох талаар гадаад орнуудын хуульд тогтоомжид тусгайлан зохицуулсан зохицуулалт Эстони, ИБУИНВУ, Гүрж, Казакстан Улсын хууль тогтоомжид тусгагдаагүй байна.

Харин БНСУ-ын хувьд 1 тендерт оролцогч 2 болон түүнээс олон тендерийн материалыг 1 тендерт илгээвэл хүчингүйд тооцдог. 1 төлөөлөх эзэнтэй 2 болон

⁴⁴ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 8.1.

⁴⁵ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 9.

түүнээс дээш тооны компани тендер илгээсэн бол мөн адил 1 тендерт оролцогч гэж үзнэ гэж заасан байна.⁴⁶

Түүнчлэн Дэлхийн банкны судалгааны судалгаанд хамрагдсан 180 улсаас 46 улсад зөвхөн бүртгэлд бүртгэгдсэн этгээд тендерт оролцох эрхтэй байдаг талаар дурдсан байна.⁴⁷

Тендерт оролцогчийн ерөнхий чадварыг тогтоох, үнэлэхтэй холбоотой хуулийн зарим зохицуулалт нь хууль хэрэгжүүлэхэд хоёрдмол утгатай, зөрүүтэй байдлыг үүсгэдэг нь дээрх судалгаанаас харагдаж байгаа тул хуулийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахгүй байна гэж дүгнэж байна.

Түүнчлэн хуульд тендерт оролцогч нэг тендер ирүүлэхийг заасан ч тендерт оролцогч гэдгийг тодорхойлсон хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалт нь тендерт оролцогч этгээдийн харилцан хамаарлыг бүрэн тодорхойлж чадаагүй нь харилцан хамаарал бүхий тендерт оролцогчид нэг тендер шалгаруулалтад оролцож, тендер илгээж байгаа нь өрсөлдөх тэгш боломжтой байх хуулийн зарчмыг алдагдуулсан ноцтой нөхцөл үүсгэж байгааг онцгой анхаарч тендерт оролцогчийн ерөнхий шаардлагыг тогтооход Өрсөлдөөний хууль, Татварын ерөнхий хуульд нийцүүлэн тодорхойлох шаардлагатай байна.

6.6.Тендерийг хянан үзэх шат, тендерийн үнэлгээ

Хуулийн 27 дугаар зүйлд тендерийг хянан үзэх, 28 дугаар зүйлд тендерийг үнэлэх талаарх зохицуулалтыг хуульчилсан байна.

Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт зааснаар тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзэхээр заажээ:

27.1.1.энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага;

27.1.2.техникийн тодорхойлолт;

27.1.3.тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага.

Хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ гэж хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасан ба хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзахаар заасан байна. Шаардлагад нийцсэн бүх тендерт үнэлгээ хийхийг хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасан байна.

Хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт зааснаар тендерийн үнэлгээг тендер хүчинтэй байх хугацаанд багтааж аль болох богино хугацаанд хийх бөгөөд шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байхыг хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт заасан байна.

Шаардлагад нийцсэн тендерийг дараах байдлаар харьцуулж үнэлэхээр хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсэгт заасан байна. Үүнд:

⁴⁶ <https://www.lexology.com/library/detail.aspx?q=9e39c3ae-8893-45d0-969f-e9de75c5d550>

⁴⁷ The World Bank (2016). Benchmarking Public Procurement 2017: Assessing Public Procurement Regulatory Systems in 180 Economies.

28.7.1.тендерийн үнэд арифметик алдаа болон орхигдуулсан жижиг хэмжээний зөрүүг залруулах, үнийн хөнгөлөлтийг харгалзан тендерийн үнийг бууруулах, захиалагч энэ хуульд заасныг үндэслэн үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож тендерийн харьцуулах үнийг тодорхойлно;

28.7.2.давуу эрх олгохоор тендерийн баримт бичигт заасан бол давуу эрх эдлэх этгээдийн ирүүлсэн тендерийн харьцуулах үнэд энэ хуулийн 10.2-т заасан хувь хэмжээг тооцно;

28.7.3.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж, энэ хуульд заасны дагуу үнэлэгдсэн тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно;

28.7.4.хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

28.7.5.эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад чанар ба үнэлгээний харьцуулалтаар өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

Өөрөөр хэлбэл хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үзэж, гэрээ байгуулах эрх олгодог байна.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасан харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулахыг хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан. Хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт үнэлгээний хорооны чиг үүргийг тодорхойлсон байна. Үүнд:

1. техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх;
2. тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

Хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалтад “үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах” гэж захиалагчийн эрх, үүргийг зааж, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 6 дугаар зүйлд захиалагч үнэлгээний хорооны дүгнэлтээс татгалзах асуудлыг нарийвчлан зохицуулсан байна.

Дээр дурдсан журмын 6.2-т “Захиалагч үнэлгээний хорооны дүгнэлт нь хууль, тогтоомж болон тендерийн баримт бичигтэй нийцээгүй, тэдгээрийг илт зөрчсөн болохыг захиалагч олж тогтоосон бол үнэлгээний хорооны дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор зөрчлийг арилгах тухай шаардлагыг үнэлгээний хороонд бичгээр мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдэлд зөрчлийн үндэслэл, тайлбарыг заавал дурдсан байна.”; 6.3-т “Үнэлгээний хороо нь мэдэгдлийг хүлээн авсан даруй буюу ажлын 3 хоногт багтаан хуралдаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргаж, захиалагчид хүргүүлнэ. Үүнд:

6.3.1.Захиалагчаас ирүүлсэн шаардлага үндэслэлтэй бол түүнийг хууль тогтоомжид нийцүүлэн залруулж, захиалагчийн шийдвэрийг үндэслэн дахин дүгнэлт гаргах.

6.3.2.Захиалагчаас ирүүлсэн шаардлага үндэслэлгүй бол өмнө гаргасан дүгнэлтийн үндэслэлийг тодорхой нотолж, өмнөх шийдвэрийг захиалагчид дахин хүргүүлнэ.” гэж заасан байна.

Дээр дурдсан хууль, журмын хүрээнд гаргасан үнэлгээний дүгнэлт болох үнэлгээний хорооны шийдвэрийг шүүхийн практикт хянаж байгаа асуудал харилцан адилгүй байгаа нь шүүхийн шийдвэрийн судалгаанаас харагдаж байна.

Захиргааны хэргийн шүүх тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийг хянах хяналтын хүрээ нь эрх зүйн хувьд тодорхой байх нь хуулийн болон шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга ёсны зарчимд нийцнэ. Гэтэл захиргааны шийдвэр (үнэлгээний хороо)-ийг захиргааны хэргийн шүүх хэрхэн хянах, хяналтын цар хүрээний хязгаарыг өөр өөрөөр ойлгож, энэ асуудлаар нэгдмэл үзэл бодол төлөвшөөгүй байна. Тухайлбал, мөрдөн шалгах зарчмын үүднээс захиргааны хэргийн шүүх бодит үнэнийг тогтоох зорилготой гэдэг агуулгаар үнэлгээний хороо хэрхэн ажилласан, тендерийг хянахдаа алдаа гаргасан эсэхийг нотлох баримтын хүрээнд хянах хандлага практикт давамгайлсан байдаг. Гэтэл захиргааны хэргийн шүүх зарим тохиолдолд үнэлгээний хорооны дотоод итгэлээр шийдсэн асуудлыг шүүх шалгахгүй, зөвхөн хууль тогтоомж, журам зөрчсөн эсэх асуудлын хүрээнд хянана гэж тайлбарлан шийдвэрлэж байна. Захиргааны хэргийн шүүх үнэлгээний хорооны шийдвэрийг хэрхэн хянах нь практикт тодорхойгүй байгааг тодорхой хэргийн хүрээнд авч үзье.

- Захиргааны хэргийн анхан шатны шүүх “Тендерийн үнэлгээний хорооны дотоод итгэлээрээ шийдвэрлэсэн асуудлыг шүүх хөндөхгүй” гэж шийдвэрлэсэн байна.
- Давж заалдах шатны шүүх “Үнэлгээний хороо нь хууль болон тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан үзэх ба шаардлагад нийцсэн тендерт үнэлгээ хийх үүрэгтэй. Захиргааны хэргийн шүүх үнэлгээний хороог дээрх чиг үүргээ зохих ёсоор биелүүлсэн эсэхийг шалгаж тогтоох нь нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэх гол үндэслэл болох учиртай”⁴⁸ гэж тайлбарлан тендерт оролцогч нь шаардлага хангаж байгаа эсэхийг дахин хянаж үнэлгээний хорооны ажлаа зохих ёсоор хийсэн эсэхийг шалган шийдвэрлэж байна.
- Улсын дээд шүүхийн хувьд “Тендерийн үнэлгээний хорооны өөрийн эрх хэмжээний хүрээнд тендерийг хянан үзэж, сонгон шалгаруулж үнэлэх эрхтэй бөгөөд захиргааны хэргийн шүүхээс энэхүү сонгох эрхийн асуудлыг хянан үзэхдээ зөвхөн үнэлгээний хороо нь тендер шалгаруулах ажиллагааны журам зөрчсөн эсэх, эсхүл адил тохиолдолд өөр өөр үнэлгээ өгч, тэгш бус хандсан эсэхийг хянах чиг үүрэгтэй тул үнэлгээний хорооны гишүүний өөрийн дотоод итгэл, мэдлэг чадвар дээр суурилсан үнэлгээнд хууль зүйн дүгнэлт өгөх боломжгүй”⁴⁹ гэж шийдвэрлэж байна. Гэтэл хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт заасан “удаах хамгийн сайн тендер ирүүлсэн этгээдтэй гэрээ байгуулахыг даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг

⁴⁸ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны 2016 оны 10 сарын 27-ны өдрийн 0699 дугаар магадлал

⁴⁹ Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2017 оны 01 сарын 30-ны өдрийн 34 дугаар тогтоол

үнэлгээний хороо нэгэнт “удаах хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогч” гэж тогтоосон байхад шүүх дахин хянан үзэж хянан шалгах шатанд тэнцэх боломжгүй байсан тул удаах гэж үзэхгүй гэж үзэж нэхэмжлэлийг нь хэрэгсэхгүй болгож Улсын дээд шүүхээс шийдвэрлэсэн байна.

Үнэлгээний хорооны шийдвэрийг шүүхээс хянах цар хүрээ нь тодорхой бус байгаа нь хуулийг хэрэглэхэд хүндрэл учирч, улмаар шүүх өөрөөр тайлбарлан хэрэглэж, тендерт оролцогчдын хуулийн болон шүүхийн өмнө тэгш байх эрх зөрчигдөж байна. Иймд энэ асуудлыг нэг мөр болгосон зохицуулалтыг хуулийн зохицуулалтын хүрээнд эсхүл холбогдох хуульд өөрчлөлт оруулж тодорхой болгох шаардлагатай байна.

Түүнчлэн тендерийн үнийн саналыг тодорхойлохтой холбоотой маргаан шүүхийн практикт нийтлэг байгаа нь шүүхийн шийдвэрийн судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, худалдааны нөхцөл инкотермсийг сонгож ирүүлэхээр заасан тендерийн хувьд хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь “Тендерийн баримт бичигт өөрөөр заагаагүй бол тендерийн үнэд татвар, даатгал, тээвэрлэлтийн болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бусад бүх зардлыг багтааж тооцох бөгөөд эдгээр зардлыг тендерийн үнэд тусгайлан тооцоогүй бол захиалагч тухайн зардлыг тендерийн үнэд багтсан гэж үзнэ.” гэж заасныг үнэлгээ хороо болон захиргааны хэргийн шүүх харилцан адилгүй тайлбарлан хэрэглэж байна.

Тендерийн баримт бичигт худалдааны нөхцөлийг сонгож тендерийн үнийн санал ирүүлэхийг заасан тохиолдолд инкотермсийн ямар нөхцөлөөр үнийн санал өгснөөс хамаараад үнэд “татвар хураамж, тээвэрлэлтийн зардал” багтсан гэж үзэх эсэх нь эргэлзээтэй байдлыг бий болгож байна.

Энэ нөхцөлд гурван шатны шүүх хууль хэрэглээний талаар өөр өөр тайлбар хийсэн байна. Тухайлбал Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх⁵⁰-ээс “Инкотермсийн ямар нөхцөлөөр үнийн санал өгсөн нь хамаагүй, хуульд заасны дагуу тендерт ирүүлсэн үнийн саналд холбогдох татвар хураамжууд багтсан гэж үзнэ” гэж тайлбарлаж байхад Улсын дээд шүүхийн зүгээс “Инкотермсийн бараа нийлүүлэх суурь нөхцөлөөс хамаарч зардал, эрсдэлийг хариуцах тал тогтоогдож, энэ нь барааны үнэ бүрдэлтэд шууд нөлөөлөхөөр байдаг тул тендер шалгаруулалтад ирүүлсэн үнийн саналыг харьцуулахдаа талуудын үнэ тооцож ирүүлсэн нөхцөлүүдийг үнэлгээний хороо зайлшгүй харгалзан үзэх ёстой” гэж тайлбарлаж байна. Иймд хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсгийг илүү тодорхой болгож зохицуулах шаардлагатай байна.

Гадаад орнуудын худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн харьцуулсан судалгаанаас үзэхэд тендер шалгаруулалтын үнэлгээнд тендерийн үнэ нь үнэлгээнд харгалзан үзэх нийтлэг шалгуур үзүүлэлт байна.

БНСУ-ын хувьд үнэлгээг хийхэд эцсийн хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг нэн тэргүүнд тавихаар зааж, шаардлагатай тохиолдолд тендерийг хянан үзэхэд захиалагч байгууллагын төлөөллийг оролцуулахаар зохицуулсан байна. Мөн техникийн үнэлгээний дүгнэлтээр дараах 3 төрлийн шийдвэр гарч, тендерийн

⁵⁰ Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2014 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 156 дугаар тогтоол

үнэлгээг хийдэг байна. Үүнд: Зөвшөөрсөн /техникийн үзүүлэлттэй нийцсэн, илүү давуу үзүүлэлттэй бүтээгдэхүүн санал болгосон, нотлох баримт бичиг хангалттай/

- Хүлээн зөвшөөрөх боломжтой /техникийн үзүүлэлттэй нийцсэн, илүү давуу үзүүлэлттэй бүтээгдэхүүн санал болгосон, гэвч нотлох баримт бичиг хангалттай биш/
- Хүлээн зөвшөөрөх боломжгүй.

НҮБ-ын Загвар хуульд зааснаар үнэлгээний шалгуурт дараах асуудлыг оруулж болохоор заасан байна.⁵¹ Үүнд:

- a. Үнэ
- b. Үйл ажиллагаа, засварын өртөг, бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ дуусах хугацаа, барааны, барилга байгууламжийн, байгаль орчны зэрэг тухайн тендер шалгаруулалтын онцлогтой холбоотой шинж чанар, төлбөрийн нөхцөл, баталгаа
- c. Хуулийн 47, 49, 50 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулсан тендер шалгаруулалтын хувьд тендерт оролцогчийн туршлага, найдвартай байдал, мэргэжлийн, менежерийн чадвар, гэрээг хэрэгжүүлэх хүний нөөц.

Дээр дурдсанаас гадна дараах шалгуурыг нэмэлтээр үнэлгээнд тогтоож болно:

- a. Тухайн улсын хуульд заасан эсхүл заавал анхаарахыг заасан шалгуур.
- b. Тухайн улсын хууль тогтоомжид заасан бол дотоодын тендерт оролцогчдод эсхүл дотоодод үйлдвэрлэсэн бараанд давуу байдал олгох давуу эрхийн зөрүү эсхүл бусад давуу байдлыг олгох. Давуу байдлын зөрүүг хуульд заасан хэмжээгээр тооцно.

Эстони, ИБУИНВУ-ын худалдан авах ажиллагааны хууль болон АХБ-ын худалдан авах ажиллагааны журамд тендерийн хүчинтэй хугацааг тендерийн баримт бичигт заах бөгөөд түүнд заасан хугацаагаар тендер хүчинтэй байх талаар зохицуулсан байна. НҮБ-ын Загвар хуульд мөн тендерийн баримт бичигт заасан хугацаанд тендер хүчинтэй байх, хүлээн авах талаар дурдсан байна.⁵²

Худалдан авах ажиллагааны журмаас хамаарч тендер хүлээн авах хугацааг тодорхойлж байгаа нийтлэг зохицуулалт судалсан гадаад орны худалдан авах ажиллагааны хууль тогтоомжид туссан байна. Тухайлбал, ИБУИНВУ-ын хувьд нээлттэй тендер шалгаруулалтын хувьд тендер зарласнаас хойш 35-аас доошгүй хоногийн хугацаанд тендер хүлээн авахаар заасны зэрэгцээ дараах нөхцөлд уг хугацааг дараах байдлаар өөрчлөн зохицуулсан байна.⁵³ Үүнд:

1. Тендерийн урьдчилсан мэдэгдэлд тендерийн мэдээлэл бүрэн багтсан, тэр нь 35 хоногоос 12 сарын өмнө нийтлэгдсэн бол хугацааг 15 хоног болгон бууруулж болно.
2. Яаралтай гүйцэтгэх гэнэтийн нөхцөл үүсэж 35 хоногийн хугацааг дагах боломжгүй болсон бол хугацааг 15 хоног хүртэл бууруулж болно.
3. Цахимаар тендер хүлээн авч байгаа бол хугацааг 5 хоногоор бууруулж болно.

⁵¹ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 11.

⁵² UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 41.

⁵³ Худалдан авах ажиллагааны хуулийн 27-р хэсэг.

Хязгаарлагдмал тендер болон өрсөлдөөнт хэлэлцээрийн арга (competitive procedure with negotiation)-ын хувьд тендер зарласнаас хойш 30 хоногоос доошгүй гэж заасны зэрэгцээ дараах нөхцөлд тендер ирүүлэх хугацааны доод хязгаарыг тогтоосон байна. Үүнд:⁵⁴

1. Тендерийн урьдчилсан мэдэгдэлд тендерийн мэдээлэл бүрэн багтсан, тэр нь 35 хоногоос 12 сарын өмнө нийтлэгдсэн бол хугацааг 10 хоног болгон бууруулж болно.
2. Яаралтай гүйцэтгэх гэнэтийн нөхцөл үүсэж 30 хоногийн хугацааг дагах боломжгүй болсон бол хугацааг 10 хоног хүртэл бууруулж болно.
3. Орон нутгийн захиалагч нар нийт оролцогч нартай тохиролцон хугацааг тогтоож болно, тохиролцоо хийгдээгүй бол хамгийн багадаа 10 хоног байна.

Захиалагчийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах тендерийн хороонд хөндлөнгийн буюу төрийн бус байгууллагын төлөөлөл оруулдаг жишээ Гүрж улсын худалдан авах ажиллагааны хуульд тусгагдсан байна.

Харин тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр нийтэд мэдээлэх, аливаа этгээдийн хүсэлтээр захиалагчийн шийдвэрийн талаар мэдээлэл авах, тендер шалгаруулалтын тэмдэглэлийг олон нийтэд заавал нээлттэй байлгах зэргээр худалдан авах ажиллагаа дахь олон нийтийн оролцоог хангагдах талаар НҮБ-ын Загвар хуульд заасан байна.

Гүрж Улсын Аудитын газар худалдан авах ажиллагааны хяналтыг гүйцэтгэх⁵⁵ бол Эстони Улсын хувьд Сангийн яам худалдан авах ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй ба худалдан авалтын явцад хууль зөрчигдсөн тухай баттай нотолгоо байгаа эсхүл санамсаргүйгээр захиалагч байгууллагыг сонгож тендер шалгаруулалт дуусахаас өмнө хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэдэг. Захиалагчийн гаргасан шийдвэр хуульд нийцсэн эсэхийг л шалгах аас бус уг шийдвэр нь эдийн засгийн үр нөлөөтэй эсэх, амьдралд хэрэгжих боломжтой эсэх зэргийг нягтлан шалгахгүй байна.⁵⁶

Тендерийг хянан үзэх, үнэлэхтэй холбоотой хуулийн зарим зохицуулалт нь хууль хэрэгжүүлэхэд хоёрдмол утгатай, зөрүүтэй байдлыг үүсгэдэг нь дээрх судалгаанаас харагдаж байгаа тул хуулийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахгүй байна гэж дүгнэж байна.

6.7. Худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

Улс орнуудын худалдан авах ажиллагааны тогтолцоо ихэвчлэн төвлөрсөн, төвлөрсөн бус тогтолцоонд хуваагддаг. Төвлөрсөн тогтолцооны хувьд тодорхой тооны эсхүл дийлэнх худалдан авах ажиллагааг тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн байгууллага зохион байгуулдаг бол төвлөрсөн бус тогтолцооны хувьд төсөв батлагдсан байгууллага бүрийн дарга нь худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг. Хэдийгээр дээрх 2 тогтолцоонд өөр өөрийн давуу тал байгаа хэдий ч мөн сул талтай. Жишээ нь аль ч тогтолцооны үед авлигад өртөх эрсдэл байдаг.

⁵⁴ Худалдан авах ажиллагааны хуулийн 28-р хэсэг.

⁵⁵ Law of Georgia on Public Procurement, Гүржийн худалдан авах ажиллагааны тухай хууль. Бүлэг 22.1.

⁵⁶ Худалдан авах ажиллагааны хуулийн 203-212-р хэсэг.


Тиймээс дийлэнх улс орнууд худалдан авах ажиллагааны хосолмол тогтолцоог сонгон хэрэгжүүлдэг байна⁵⁷.

Монгол Улсын худалдан авах ажиллагааны тогтолцоо дараах үе шатыг дамжиж өнөөгийн худалдан авах ажиллагааны бүрэн төвлөрсөн бус тогтолцоонд шилжсэн байна. Үүнд:

2000 оны 4 дүгээр сар	- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль батлагдсан.
2000 оны 7 дугаар сар	- Худалдан авах ажиллагаа хариуцсан албыг Сангийн Яамны бүтцэд байгуулсан.
2000 он	- Худалдан авах ажиллагаа хариуцсан албыг газар болгон өргөжүүлсэн.
2000 оны 5 дугаар сар	- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг шинэчлэн найруулсан хууль батлагдсан.
2000-2005 он	- Худалдан авах ажиллагааны хагас төвлөрсөн тогтолцоонд шилжсэн. - Сангийн яамны ахалсан Яам дундын Тендерийн хороо өндөр өртөг бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар болсон.
2006-2011	- Бүрэн төвлөрсөн бус тогтолцоотой болсон. - Яамд, аймаг, агентлаг өөрсдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар заасан. - Сангийн яам өндөр өртөг бүхий худалдан авах ажиллагааг хянаж, зөвшөөрөл олгохоор заасан.
2012 оноос хойш	- Хагас төвлөрсөн тогтолцоонд шилжсэн. - Улсын болон бүс нутгийн чанартай худалдан авах ажиллагааг Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлж эхэлсэн.

⁵⁷ Korean public procurement, Dae-in Kim, page 6, 2021

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТОГТОЛЦОО



Өнгөрсөн хугацаанд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийгдэж байгаа худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, төсвийн мөнгийг илүү хэмнэлттэй, үр ашигтай, хариуцлагатай, ил тод байдлаар, өрсөлдөх тэгш боломжтой, түргэн шуурхай явуулах хэрэгцээ шаардлагын үүднээс Засгийн газрын Худалдан авах ажиллагааны төвлөрсөн шинэ тогтолцоо байгуулах шаардлага үүссэн байна. Иймээс өөрийн орны худалдан авах ажиллагааг эрхлэн хэрэгжүүлдэг байгууллагын онцлог, дэлхийн зарим улс орны тухайлбал БНСУ, Казахстан, Европын холбооны ихэнх улс орнууд тухайлбал, Болгар, Кипр, Бүгд найрамдах Чех Улс, Эстони, Унгар, Латви, Литви, Мальта, Польш, Румын, Бүгд найрамдах Словак Улс зэрэг төвлөрсөн худалдан авах ажиллагааны тогтолцоо бүхий улс орнуудын худалдан авах ажиллагааны байгууллагуудын бүтэц, чиг үүргийг, худалдан авах ажиллагааны хагас төвлөрсөн бүтэц бүхий Европын холбооны улсууд болох Австри, Франц, Герман, Ирланд, Итали, Люксембург, Словени, Швед болон ИБУИНВУ зэрэг улс орнуудын худалдан авах ажиллагааны бүтэц, чиг үүргийг харьцуулан судалж, Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх зүйн үндсийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар бий болгосон байна.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 14 дүгээр тогтоол, Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 6 дугаар тогтоолоор Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах мэргэжлийн байгууллага болох Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Худалдан авах ажиллагааны газар анх байгуулагдаж, 2013 оны 10 дугаар сарын 4-ний өдрөөс нийт 65 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор тус газрыг татан буулгаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай нэгтгэн өөрчлөн байгуулсан бол Монгол Улсын Их Хурлын 2019 оны 10

дугаар сарын 25-ны өдрийн 84 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 438 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газрыг дахин байгуулсан байна.

Улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас худалдан авах ажиллагааг нь зохион байгуулах улсын болон бүс нутгийн чанартай бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газраас баталж, уг жагсаалтад орсон бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгох ажиллагааг тус байгууллага зохион байгуулж байна. Харин дээрх жагсаалтад багтаагүй бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг хуульд заасан төсвийн ерөнхийлөн захирагч нар зохион байгуулж байна.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байхаар хуулийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэгт заасан байна.

2021 оны байдлаар улсын хэмжээнд 7,458.0⁵⁸ тэрбум төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөгдсөнөөс 1,531.6 тэрбум төгрөг буюу ойролцоогоор нийт төсвийн 20 хувийн худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулахаар төлөвлөгджээ. Түүнчлэн хуулийн 53 дугаар зүйлийн 53.5.7 дахь заалтад заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газар нь төрийн бүхий л байгууллагын байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээр дамжуулан зохион байгуулах үүрэгтэй. Тус үүргийн хүрээнд 2017 онд 10 гаруй нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг цахим дэлгүүрт байршуулан, ерөнхий гэрээг хэрэгжүүлж эхэлсэн бол өдгөө 632 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, сурах бичиг хэвлэх үйлчилгээг хамарч, өргөжөөд байна. Цаашид цахим дэлгүүрээр худалдан авах бараа, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэх хандлагатай байна.

Мэргэшсэн байгууллага нь томоохон худалдан авалт болон нийтлэг бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээр дамжуулан зохион байгуулж байгаа нь нэг талаас ашиг сонирхлын зөрчилгүй, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай худалдан авалт хийх боломжтой хэдий ч бодлого баригчдын зүгээс тус газрын мэргэшсэн, бие даасан байдалд анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн орон нутаг дахь худалдан авах ажиллагааны нэгжийн чиг үүрэг, үйл ажиллагаа худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын талаарх хуульд орсон өөрчлөлтөөс хамаарч тогтворгүй, тодорхой байдал орон нутагт байна.

Хуулийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байна.” гэж заасан бөгөөд уг нэгжийн даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөхөөр хуульд заасан байна. Гэвч хуульд орон нутаг дахь худалдан авах ажиллагааны нэгжийн чиг үүргийн талаар тусгаагүй байдаг байна.

⁵⁸ <https://www.tender.gov.mn/mn/plan/index>

Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоолоор Худалдан авах ажиллагааны газрыг татан буулгаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай нэгтгэн өөрчлөн байгуулсны дагуу аймагт өмчийн болон худалдан авах ажиллагаа хариуцсан Орон нутгийн өмчийн газар гэж өөрчлөн байгуулагдсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд аймаг нийслэлд төрийн өмчийн төлөөлөгч ажиллахаар заасан бол хуульд аймаг, нийслэлд худалдан авах ажиллагааны нэгж ажиллахаар заасан байдаг.

Хуулийн 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн өөрчлөлтөөр зөвхөн Ховд аймагт Худалдан авах ажиллагааны нэгжийг өмчийн эрхлэх асуудлаас салгаж, бие даасан нэгж байхаар өөрчлөн байгуулсан байна. Мөн хуулийн 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсэгт зааснаар худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргатай бус Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргатай зөвшилцөн хуульд зөрчиж томилсон тохиолдол гарсан байна.

БНСУ-ын худалдан авах ажиллагаа төвлөрсөн тогтолцоотой бөгөөд Санхүү эдийн засгийн яамны харьяа Худалдан авах ажиллагааны бодлого боловсруулах хороо худалдан авах ажиллагааны бодлогын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Дунд болон урт хугацааны төрийн худалдан авах ажиллагааны бодлого болон тогтолцоог бий болгох
- Технологийн шинэчлэл, нийтийн хэрэгцээнд нийцүүлэн төрийн худалдан авах ажиллагааг сайжруулах
- Төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой үнэлгээ, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
- Худалдан авах ажиллагааг хялбаршуулах бусад асуудал.

Тус хороо нь дарга, гишүүдээс бүрдсэн 20 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хорооны даргаар Сангийн сайд ажилладаг бөгөөд Сангийн яамны албан хаагчдыг гишүүдээр томилдог. Мөн технологийн шинэчлэл, эдийн засаг, шинжлэх ухаан, төрийн худалдан авах ажиллагааны чиглэлийн туршлагатай хүмүүсийг олон нийтийн төлөөллөөр томилдог.

Тус улсын төрийн худалдан авах ажиллагааны хэрэгжүүлэгч агентлаг болох Солонгосын төрийн худалдан авах үйлчилгээний газар⁵⁹ нь төрийн нийт худалдан авалтын 30 гаруй хувийг хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь "Korea On-Line Procurement System (KONEPS)" системийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг бөгөөд тус системээр дамжуулан тендер шалгаруулалтыг зохион байгуулдаг байна.⁶⁰

Солонгосын төрийн худалдан авах үйлчилгээний газрын чиг үүрэг нь⁶¹:

- Цахим систем /koneps/ менежмент, үйл ажиллагаа
- Бараа материалын нөөцийн удирдлага
- Засгийн газрын өмчийн асуудал зохицуулах, аудит
- Засгийн газрын томоохон барилгын төслүүдийн гэрээний удирдлага

⁵⁹ Public Procurement Service of Korea (PPS).

⁶⁰ https://www.researchgate.net/publication/348618992_Korean_Public_Procurement_Law

⁶¹ Korea On-Line Procurement System (KONEPS) <https://www.pps.go.kr/eng/content.do?key=01155>

- Дотоод болон гадаад худалдан авах ажиллагаа

Захиалагч гадаадаас бараа худалдаж авах тохиолдолд Солонгосын төрийн худалдан авах үйлчилгээний газарт захиалга өгч, уг захиалгыг худалдан авах ажиллагааны цахим систем /KONEPS/-ээр зохион байгуулдаг онцлогтой байна. Энэ тохиолдолд захиалагчаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч Солонгосын төрийн худалдан авах үйлчилгээний газар тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг боловсруулж тендерийг урьдчилсан сонгон шалгаруулалтын аргаар 7 хоногийн хугацаатай зарладаг байна. Ирүүлсэн саналыг захиалагчид танилцуулж тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолт, гэрээний нөхцөлд эцсийн байдлаар санал авч Солонгосын төрийн худалдан авах үйлчилгээний газраас тендер зарладаг байна.

Эстони⁶², ИБУИНВУ⁶³-ын хувьд БНСУ-ын нэгэн адил худалдан авах ажиллагааны төвлөрсөн байгууллагатай байх бөгөөд уг байгууллага нь худалдан авах ажиллагааны цахим систем, ерөнхий гэрээг хариуцан зохион байгуулах нийтлэг чиг үүрэгтэй байна.

Худалдан авах ажиллагааны удирдлага тогтолцооны хүрээнд аймаг, нийслэл дэх худалдан авах ажиллагааны нэгжийн чиг үүрэг тодорхойгүй, Төрийн худалдан авах ажиллагааны газраас орон нутаг дахь худалдан авах ажиллагааны нэгжтэй харилцаж хяналт тавих зэрэг хуульд заасан чиг үүргийг ямар хүрээнд гүйцэтгэх нь тодорхойгүй, хүндрэлтэй байдаг нөхцөл байдал байна. Иймд хуулийн зургаадугаар бүлгийн холбогдох зохицуулалт нь хуулийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахгүй байна гэж дүгнэж байна.

6.8.Маргаан шийдвэрлэлт

Тендер шалгаруулалттай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хянан шийдвэрлэхээр хуулийн 7 дугаар бүлэгт тодорхой заасан байна.

Шүүхийн өмнөх шатанд тендер шалгаруулалттай холбоотой маргааныг захиалагч, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, шүүхийн шатанд захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр зохицуулсан байна.

Шинэчлэн найруулсан Өрсөлдөөний тухай хуулийг 2010 оноос дагаж мөрдөхтэй зэрэгцэн хуульд орсон 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн өөрчлөлтөөр захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хүлээн авч, хянах зохицуулалтыг тусгасан байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар дээр дурдсан үндэслэлийн хүрээнд гомдлыг хянан шийдвэрлэж байгаад хуульд орсон 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, гэрээ байгуулах эрх

⁶² Худалдан авах ажиллагааны хуулийн 42-р хэсэг.

⁶³ Худалдан авах ажиллагааны хуулийн 37-р хэсэг.

олгосон тухай гомдлыг хянан шийдвэрлэхээр тусгаж, уг өөрчлөлтийг 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт “Тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ захиалагч зөрчсөн гэж үзвэл тендерт оролцогч энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд зөрчлийг нотлох баримтыг хавсаргана.” гэж зааж уг гомдлыг хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор захиалагч хянан шийдвэрлэхээр мөн зүйлийн 55.4 дэх хэсэгт заасан байна.


Захиалагч тендерийн баримт бичигт өрсөлдөөн хязгаарласантай холбоотой гомдлыг тендерт оролцогч Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө гаргахаар хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан байна.

Харин захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 5 хоногийн дотор гаргахаар хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан байна.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан хянан шийдвэрлэх бөгөөд хуулийн 55 дугаар зүйлд үндэслэн захиалагчийн шийдвэр, үйл ажиллагаатай холбогдуулан тендерт оролцогчоос гаргасан гомдлыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэх ба гаргасан шийдвэрийг захиалагч Захиргааны ерөнхий хуулийн 98 дугаар зүйлийн 98.2 дахь хэсэгт заасны дагуу заавал биелүүлэхээр Сангийн сайдын 2019 оны “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-ын 1.3-т заасан байна.

Хэрэв Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гарсан шийдвэрийг эс зөвшөөрвөл тендерт оролцогч шүүхэд гомдол гаргана гэж хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт заасан байна.

Тендер шалгаруулалтад холбоотой Сангийн яамны гомдол шийдвэрлэлтийн 2014-2020 оны статистик мэдээг доор оруулав.



Хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 33.2.1-д заасан үнийн санал ирүүлэх хугацааг урилга зарласан өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно.”, хуулийн 36 дугаар зүйлийн 36.10 дахь хэсэгт “Санал ирүүлэх хугацаа нь ... хувь хүний хувьд 7-оос дээш хоногоор тогтоож саналын урилгад тодорхой заана.”, 36.17 дахь хэсэгт “Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд зөвлөхийн хураангуй жагсаалтыг дахин гаргаж, санал ирүүлэх хугацааг ажлын 5 ба түүнээс дээш өдрөөр тогтооно.” гэж заасан тендер шалгаруулалтад хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан “ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө” Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гомдол гаргах боломжгүй байна. Энэ нөхцөлд захиалагч өрсөлдөөн хязгаарласантай холбоотой гомдлыг хянан эсэх нь хуульд мөн тодорхойгүй байна.


Захиалагч гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн хугацаанд гомдлыг шийдвэрлээгүй тухай сонирхогч этгээдийн гомдлыг Сангийн яам хүлээж авч шийдвэрлэх эсэх нь мөн хуульд тодорхойгүй тул уг заалтыг хоёрдмол агуулгаар тайлбарлаж, хэрэглэх нөхцөл бодитой оршиж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой маргааныг анхан шатны шүүх 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ гэж Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан тусгай журмаар хянан шийдвэрлэх маргааны төрөлд оруулсан байна.

Улсын дээд шүүхийн судалгааны төвөөс болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа мэдээллийн төвөөс гаргасан Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүнгийн тухай танилцуулга⁶⁴ тайланд⁶⁵ 2005-2020 онд Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг маргаанаас тендертэй холбоотой маргааныг тоон үзүүлэлтийг гаргахад нийт хэрэг маргааны дунджаар 3.9 хувийг эзэлж байна.

⁶⁴ Улсын дээд шүүх. <http://www.supremecourt.mn/c/29> (сүүлд үзсэн 2021.08.04)


⁶⁵ Шүүхийн ерөнхий зөвлөл. <http://www.judiciary.mn> (сүүлд үзсэн 2021.08.05)




Дээрх судалгаа нь захиргааны хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн тоонд үндэслэсэн байх тул нийт зохион байгуулсан тендер шалгаруулалтын хэдэн хувьд шүүхийн шатанд нэхэмжлэл гаргаж байгааг тодорхойлох боломжгүй байна.

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Сангийн яаманд 2020 онд хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр тендерт оролцогчоос гаргасан нийт 1009 гомдол ирснээс 28.2%-ийн гомдлыг хуульд заасан хугацаанд гаргаагүй, гомдлын харьяалал буруу, гомдлын бүрдүүлбэр хангаагүй гэсэн хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1, 55 дугаар зүйлийн 55.1, 55.2 дахь хэсэг болон Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-д зааснаар гомдлыг буцааж, гомдлын 71.7%-ийг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэж, хариуг өгсөн байна.

Сангийн яам 2020 онд 724 (71.7%) гомдлыг хянан шийдвэрлэсэн бол Захиргааны хэргийн шүүхээс 2020 онд хянан шийдвэрлэсэн нийт 1524 хэрэг маргааны 108 (7.1%) маргаан нь тендерийн маргаан байна.



Дэлхийн банкнаас хийсэн 180 улсыг хамарсан судалгаагаар тендер шалгаруулалттай холбоотой гомдол хянах эрх зүйн орчин байхгүй 7 (3.8%) улс байгаа бол захиалагчийн гаргасан шийдвэрт гомдол гаргах хоёр дахь шатны гомдол хянан шийдвэрлэх байгууллагын тогтолцоотой 152 (84.4%) улс байна.⁶⁶



Гадаад орнуудын худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн харьцуулсан судалгаанаас үзэхэд шүүхийн өмнөх шатанд тендер шалгаруулалттай холбоотой маргааныг шийдвэрлэж байгаа нийтлэг зохицуулалт байна. Мөн шүүхийн өмнөх шатны байгууллагад гомдол гаргах хугацааг хуульд тодорхой зааж өгсөн байдгаараа онцлогтой байна.

БНСУ-ын хувьд захиалагчийн шийдвэртэй санал нийлэхгүй бол 15 өдрийн дотор гомдол гаргадаг бөгөөд тухайн гаргасан шийдвэрт мөн санал нийлэхгүй бол дараагийн шатны байгууллагад 10 өдрийн дотор гомдол гаргадаг байна.⁶⁷ Харин олон улсын тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг Сангийн яамны дэд сайд,

⁶⁶ The World Bank (2016). Benchmarking Public Procurement 2017: Assessing Public Procurement Regulatory Systems in 180 Economies.

⁶⁷ <https://www.pps.go.kr/eng/content.do?key=01156#none>

Засгийн газрын харьяа байгууллагуудын эрх бүхий албан тушаалтан болон хөндлөнгийн гишүүдээс бүрдсэн 14 хүний бүрэлдэхүүнтэй Арбитрын хороо хянаж шийдвэрлэдэг байна. Тус арбитрын хороо нь гомдлыг 50 өдрийн дотор хянаж шийдвэрлэх бөгөөд гомдлыг хянаж шийдвэрлэх хүртэл гэрээ байгуулахыг түр түдгэлзүүлдэг байна. Гомдол гаргасан тал арбитрын хорооны зардлыг төлөхөөр заажээ.

Эстони улсын хувьд тендерт оролцогч нь Засгийн газраас байгуулж, удирдлага ажилтнуудыг нь томилдог, цалин хөлс үйл ажиллагааны зардал нь Сангийн яамнаас төлөгддөг Төрийн худалдан авах ажиллагааны гомдлын хороо⁶⁸-д тендертэй холбоотой зөрчил, шийдвэрийг мэдсэнээс хойш 10 хоногийн дотор гомдол гаргахаар заажээ. Хэрэв тендерийн баримт бичигтэй холбоотой гомдол байвал худалдан авах ажиллагааны арга, босго үнээс хамаарч тендер нээхээс 2-10 хоногийн өмнө, хохирол нөхөн төлүүлэх бол гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор гаргана. Уг байгууллага гомдлыг ажлын 30 хоногийн дотор хянаж шийдвэр гаргах ба гомдлыг 2 аргаар хянаж шийдвэрлэж болно:

- 1.Холбогдох баримтад тулгуурлан бичгээр харилцаж шийдвэрлэх; эсхүл
- 2.Захиалагч, гомдол гаргагч этгээд, Төрийн худалдан авах ажиллагааны байгууллагын төлөөллийг байлцуулсан биечлэн уулзалт хийж шийдвэрлэх.

Дэлхийн банкнаас хийсэн 180 улсыг хамарсан судалгаагаар хоёр дахь шатны гомдол хянан шийдвэрлэх байгууллагад захиалагчийн шийдвэрийг хянуулахаар гомдол гаргахад 62 (34.4%) улс төлбөр, хураамж авдаггүй байхад 88 (48.8%) улс улсын тэмдэгтийн хураамж, гэрээний үнийн дүнгийн тодорхой хувь (ихэнх тохиолдолд 0.5-3.0 хүртэл хувь), гомдлын шаардлагын тодорхой хувь (ихэнх тохиолдолд 1-6 хүртэл хувь) заах эсхүл хураамжийн хэмжээг мөнгөн дүнгээр заах байдлаар тогтоосон байна.⁶⁹

Тухайлбал тухайлан судалсан Дани Улсын хувьд "Тендер шалгаруулалтын гомдол шийдвэрлэх зөвлөл"-ийн тухай хуулиар гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулдаг бөгөөд тус зөвлөл гомдол хүлээн авахад 10,000-20,000 кроны төлбөр авдаг ба гомдлыг хянаад үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол буцаан олгох зохицуулалттай байна. Эстони Улсын хувьд гомдол мэдүүлэхэд олон улсын тендерийн босгоос доош бол 640 евро, түүнээс дээш бол 1,280 еврогийн төлбөр төлөхөөр заасан⁷⁰ бол Гүрж улсад хураамжгүй⁷¹, харин Казакстан Улсад 6 ам.долларын⁷² хураамж төлөхөөр заасан байна.

Итали Улсад гомдлыг шууд шүүхэд гаргах эрх зүйн зохицуулалттай бөгөөд тус улсын 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 115 дугаартай хуульд зааснаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах үндсэн төлбөрийн хэмжээ 650 евро байна. Тус хуульд 2012 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 228 дугаар хуулиар

⁶⁸ Төрийн худалдан авах ажиллагааны гомдлын хороо – Public Procurement Review Committee. (<https://www.rahandusministeerium.ee/en/objectivesactivities/public-procurement-policy/public-procurement-review-committee> сүүлд үзсэн 2021.07.27).

(<https://www.riigiteataja.ee/akt/120072017001> сүүлд үзсэн 2021.07.27)

⁶⁹ The World Bank (2016). Benchmarking Public Procurement 2017: Assessing Public Procurement Regulatory Systems in 180 Economies.

⁷⁰ Худалдан авах ажиллагааны хуулийн 189-202-р хэсэг.

⁷¹ The World Bank (2016). Benchmarking Public Procurement 2017: Assessing Public Procurement Regulatory Systems in 180 Economies. p.111

⁷² The World Bank (2016). Benchmarking Public Procurement 2017: Assessing Public Procurement Regulatory Systems in 180 Economies. p.135

нэмэлт, өөрчлөлт оруулж, тендер шалгаруулалттай холбоотой маргааныг шийдвэрлэхэд ялгаатай төлбөрийн хэмжээг тогтоосон:

- 200,000 евро, эсхүл түүнээс бага үнийн дүнтэй гэрээ бол 2,000 евро,
- 200,000-1,000,000 еврогийн үнийн дүнтэй гэрээ бол 4,000 евро,
- 1,000,000 еврогоос дээш үнийн дүнтэй бол 6,000 евро тус тус шүүхэд төлөхөөр заасан.

НҮБ-ын Загвар хуульд шүүхийн өмнөх шатанд гомдол шийдвэрлэх бие даасан байгууллага байх зохицуулалтыг тусгасан бөгөөд тендерт оролцогч захиалагчийн шийдвэр, мөн хуулийн 66 дугаар зүйлд зааснаар гаргасан гомдлыг захиалагч шийдвэрлээгүй бол гомдол шийдвэрлэх бие даасан байгууллагад хандан гомдол гаргаж болохоор тусгасан байна.⁷³

Түүнчлэн Дэлхийн Худалдааны Байгууллагын Засгийн газрын худалдан авалтын хэлэлцээрт тендер шалгаруулалтын шийдвэрийг хянан шийдвэрлэх бие даасан маргаан шийдвэрлэх зөвлөлийн бүтэцтэй байхыг улс орнуудаас шаарддаг байна.⁷⁴

Тендер шалгаруулалтыг шүүхээс өмнөх шатанд шийдвэрлүүлэх нь дараа ач холбогдолтой гэж үздэг:

- Шийдвэр гаргах үйл явц нь шүүхтэй харьцуулбал энгийн хялбар бөгөөд түргэн шуурхай байдаг бөгөөд тендер шалгаруулалтад холбогдох маргааны хувьд хамгийн чухал үзүүлэлт юм.
- Тухайн маргаан таслах байгууллагын гишүүд нь зөвхөн худалдан авах ажиллагааны маргаан хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй. Ингэснээр гишүүд нь худалдан авах ажиллагааны эрх зүйн чиглэлээр мэргэших ба гаргах шийдвэр нь үндэслэл бүхий байна.
- Маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэх нь хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлэхээс зардал чирэгдэл багатай байх боломжийг бүрдүүлдэг.

Монгол Улсад төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жилд тогтмол 1000 гаруй гомдлыг хүлээн авч, шаардлага хангасан гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж байгаа нь урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх давуу талыг бий болгож байна. Тиймээс урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журамгүйгээр маргааныг шууд харьяалан шийдвэрлэвэл одоогоор шүүхэд жилдээ 30 гаруй тоогоор шийдвэрлэгдэж байгаа захиргааны хэргийн тоо огцом өсөх, шүүхийн ачаалал шаардлагагүй асуудлаар тэр хэмжээгээр өсөх, гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах нөхцөл байдлыг бүрдүүлэх юм.

Маргаан таслах байгууллагыг хуулиар байгуулж, байнгын ажиллагаатай байх бөгөөд дараах шинжийг хангасан байх шаардлагатай:

- (1) Улс орны төрийн байгууламжаас шалтгаалж маргаан таслах хэдэн байгууллага байгуулах зэрэг нь ялгаатай боловч тухайн байгууллагыг зөвхөн хуулийн дагуу байгуулах нь нэгдмэл ойлголт юм. Өөрөөр хэлбэл, маргаан таслах байгууллагын хэлбэр, бүтэц, эрх хэмжээг худалдан авах

⁷³ UNCITRAL 2011 Model Law on Public Procurement, Article 67.1.

⁷⁴ Дэлхийн Худалдааны Байгууллагын Засгийн газрын худалдан авалтын хэлэлцээр. 20-р зүйл. Маргаан шийдвэрлэх журам

- ажиллагааны хуулийн нэг бүлэг болж тусгах, эсхүл бие даасан хууль батлах аль ч хувилбараар байгуулах боломжтой
- (2) Маргаан таслах байгууллага нь байнгын үйл ажиллагаатай явуулах ба түүний гишүүдийг тодорхой хугацаагаар томилдог. Маргаан таслах байгууллага нь дотооддоо бүтэц, зохион байгуулалтын хувьд мэргэшсэн чиглэлээр хуваагддаг байх боломжтой.
 - (3) Маргаан таслах байгууллага нь шийдвэрийн биелэлтийг хангах зорилгоор тендер шалгаруулалтыг түдгэлзүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулах талаар арга хэмжээ авах, тендер шалгаруулалтын баримт бичгээс өрсөлдөөнд харш техникийн, санхүүгийн болон бусад шаардлага, шалгуур үзүүлэлтийг хасах эрхийг эдэлдэг.
 - (4) Маргаан таслах байгууллагын хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох талууд өөрийн тайлбар, үндэслэл, нотлох баримтыг гаргаж өгөх бололцоогоор хангагдсан байх шаардлагатай. Энэхүү эрхийг эдлүүлэхийн тулд оролцогчдыг байлцуулан сонсгол хийх, эсхүл бичгээр тайлбар, тодруулга авах боломж, бололцоог бүрдүүлэх шаардлагатай юм. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид холбогдох баримт бичиг, материалтай танилцах эрхтэй боловч оролцогчийн бизнесийн нууцыг хамгаалах болон өрсөлдөөнд сөрөг нөлөөлөл учруулахгүй байх зорилгоор зарим баримт бичигтэй танилцуулахгүй байж болно.
 - (5) Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл, журмыг тусгайлан зааж өгсөн байх. Маргаан таслах байгууллагад хэрэг хуваарилах дүрэм журам зэргийг хуульд тусгайлан заасан байх.
 - (6) Маргаан таслах байгууллага бие даасан, хараат бус байх. Энэхүү шалгуур нь харьяалал, санхүүгийн хувьд бие даасан байхыг ойлгохоос гадна түүний гишүүд томилогдсон этгээдээс хараат бусаар үйл ажиллагаа явуулж, хариуцлагаа бие даан хүлээдэг байхыг ойлгоно.

Тендерийн маргаан шийдвэрлэхтэй холбоотой процесс нь тендерт оролцогчийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн бөгөөд тендер шалгаруулалтын үе бүрд холбогдох гомдол шийдвэрлэх этгээдийг хуульд зааж өгснөөрөө онцлогтой бөгөөд хуулийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа ч маргаан шийдвэрлэхтэй холбоотой зарим зохицуулалт нь практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахгүй байна гэж дүгнэж байна.

6.9.Хариуцлага

Хууль зөрчсөн гэр буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны шийтгэл ногдуулах 23 заалтыг Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх болсонтой холбогдуулан 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хуулийн 57 дугаар зүйлд заасан хууль зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг доорх байдлаар өөрчлөн найруулсан байна.

57.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

57.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээх этгээд нь төрийн албан хаагч байх хуулийн хамрах хүрээгээр хариуцлага механизм нь хязгаарлагдах бол Зөрчлийн тухай хуульд хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцон шийтгэл оногдуулах талаар зохицуулалт тусгагдаагүй байна.

Шүүхийн шийдвэрийн судалгаанаас харахад захиалагчийн эс үйлдэхүйн улмаас үүссэн маргаан нэлээдгүй гардаг байна. Тухайлбал, тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулахгүй байх захиалагчийн эс үйлдэхүйг тогтоолгож, гэрээ байгуулахыг даалгах нэхэмжлэлийн шаардлагатай маргаан байна.

Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт “Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 30 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна.” гэж зааснаас харахад тендер шалгаруулалтын болон тендерт оролцогчийн ирүүлсэн тендер нь нэгэн адил 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх тухай хуульд заасан байна. Мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт “Тендерийн үнэлгээг тендер хүчинтэй байх хугацаанд багтааж аль болох богино хугацаанд хийнэ.”, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.” гэж заасан байна.

Тендерийн хүчинтэй байх хугацаанд захиалагч тодорхойгүй шалтгаанаар хариу өгөхгүй, гэрээ байгуулахгүй байснаас шалтгаалж тендер шалгаруулалтын хүчинтэй байх хугацааг дуусгаж байгаа тохиолдол түгээмэл байна. Хэргийн нөхцөл байдлаас хамаарч гэрээ байгуулаагүй эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, гэрээ байгуулахыг даалгаж шийдвэрлэж байхад зарим тохиолдолд гэрээ байгуулах нь захиалагчид ач холбогдолгүй болсон гэсэн үндэслэлээр гэрээ байгуулахыг даалгах нэхэмжлэлийг шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр байна. Энэ тохиолдолд гэрээ байгуулаагүй захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хууль зүйн хариуцлага хүлээлгэдэг механизмыг бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн хуульд зааснаар захиалагч нь Төрийн албаны хуульд хамаарах субъект болохгүй байх тохиолдол байгаа тул төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой үйлдвэрийн газар, компанийн хувьд хуульд заасан хариуцлага хүлээхгүй байхаар зохицуулсан байна.

Мөн тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажиллаж буй төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн байгууллагын төлөөлөл, иргэдийн хурлаас томилсон иргэн хууль зөрчсөн ч хариуцлага хүлээлгэх боломжгүй байна.

Өмнө дурдсанчлан зөвхөн хууль зөрчсөн бол хариуцлага хүлээлгэхээр хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасан тул худалдан авах ажиллагаатай холбоотой захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд тухайлбал журам зөрчсөн бол аливаа хариуцлага хүлээлгэх хууль зүйн боломж байхгүй байна.

Иймд хуулийн долоодугаар бүлэгт заасан хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх зохицуулалт нь хуулийн зорилтод нийцээгүй, уг харилцааг бүрэн зохицуулж чадаагүй байх тул хуулийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахгүй байна гэж дүгнэж байна.

Долоо.Үнэлгээний зөвлөмж

Хуулийн нэгдүгээр бүлгийн хуулийн үйлчлэх хүрээ, зарчим, нэг, хоёрдугаар бүлгийн худалдан авах ажиллагааны журам, тэдгээрийн хэрэглээ, хоёрдугаар бүлгийн тендерийн урилга зарлах, тендерийн баримт бичиг, тэдгээртэй холбоотой мэдээлэл олгох хэлбэр, тендер ирүүлэх хэлбэр, нэг, хоёрдугаар бүлгийн тендер оролцогчийн чадварын үнэлгээ, хоёр, дөрөвдүгээр бүлгийн тендерийг хянан үзэх шат, тендерийн үнэлгээ, зургаадугаар бүлгийн худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, долоодугаар бүлгийн маргаан шийдвэрлэлт, хариуцлага ногдуулахтай холбогдох зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж үзэхэд тендерийн урилга зарлах, тендерийн баримт бичиг, тэдгээртэй холбоотой мэдээлэл олгох хэлбэр, тендер ирүүлэх хэлбэртэй холбоотой хуулийн зохицуулалт нь хуулийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үнэлэгдсэн бол үнэлгээ хийхээр тогтсон бусад асуудлыг зохицуулсан хуулийн зохицуулалт нь бодит байдалтай нийцээгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, хуулиар зайлшгүй зохицуулах харилцааг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулсан, эсхүл хуулийн зохицуулалтаас гадна үлдсэн, тэдгээрээс улбаалан сөрөг үр дагавар бий болсон, бусад хуультай болон зарим зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилтэй, хоёрдмол агуулгатай зэрэг асуудлууд гарсан байна.

Тус хууль батлагдсанаас хойш нийт 28 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь зарим талаар хуулийн үндсэн зарчим, үзэл баримтлалаас хазайсан, нөгөө талаар хуулийн зүйл, хэсэг, заалт хоорондоо агуулгын хувьд холилдсон нь хуулийн бүтцийн системчлэл алдагдахад хүргэсэн асуудал байна.

Хууль анх 58 зүйлтэй батлагдсан бол шинээр 7¹ дүгээр зүйл “Худалдан авах ажиллагаа дахь олон нийтийн оролцоо”, 10¹ дүгээр зүйл “Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах”, 52¹ дүгээр зүйл “Худалдан авах ажиллагааны улсын байцаагч” гэсэн 3 зүйл нэмэгдсэнээс гадна 2 дугаар зүйлд 2 удаа, 3 дугаар зүйлд 14 удаа, 4 дүгээр зүйлд 1 удаа, 5 дугаар зүйлд 10 удаа, 7 дугаар зүйлд 5 удаа, 8 дугаар зүйлд 8 удаа, 9 дүгээр зүйлд 2 удаа, 10 дугаар зүйлд 13 удаа, 10¹ дүгээр зүйлд 3 удаа, 11 дүгээр зүйлд 2 удаа, 14 дүгээр зүйлд 5 удаа, 16 дугаар зүйлд 1 удаа, 20 дугаар зүйлд 2 удаа, 21 дүгээр зүйлд 5 удаа, 22 дугаар зүйлд 2 удаа, 24 дүгээр зүйлд 2 удаа, 28 дугаар зүйлд 3 удаа, 29 дүгээр зүйлд 7 удаа, 32 дугаар зүйлд 2 удаа, 33 дугаар зүйлд 3 удаа, 34 дүгээр зүйлд 12 удаа, 36 дугаар зүйлд 3 удаа, 39 дүгээр зүйлд 2 удаа, 42 дугаар зүйлд 1 удаа, 43 дугаар зүйлд 2 удаа, 44 дүгээр зүйлд 1 удаа, 45 дугаар зүйлд 18 удаа, 46 дугаар зүйлд 4 удаа, 47 дугаар зүйлд 7 удаа, 48 дугаар зүйлд 8 удаа, 52 дугаар зүйлд 11 удаа, 52¹ дүгээр зүйлд 1 удаа, 53 дугаар зүйлд 25 удаа, 55 дугаар зүйлд 18 удаа, 56 дугаар зүйлд 2 удаа, 57 дугаар зүйлд 34 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна. Энэ нь тус хуулийн 38 зүйлд буюу 65.6 хувьд нэмэлт, өөрчлөлт оржээ.

Өнгөрсөн 16 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн байдал хурдацтай хөгжин өөрчлөгдөж, техник, технологийн дэвшлийг нийгмийн харилцаанд өргөнөөр ашиглах шаардлага үүссэн энэ үед худалдан авах ажиллагаа ч шинэ шатанд гарах шаардлагатай байна. Улмаар хүний эрх, эрх зүйн суурь зарчимд тулгуурласан, өрсөлдөөн, ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн орчин үеийн хөгжлийн чиг хандлага болох хүний оролцоог бууруулан худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх зүйн орчин боловсронгуй болгохыг цаг үе шаардаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зайлшгүй шинэчлэн найруулах, мөн холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

АЖЛЫН ХЭСЭГ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль, тогтоомж:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996)
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль (2000)
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль (2002)
- Иргэний хууль (2002)
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005)
- Төлбөр, тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009)
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (2010)
- Төсвийн тухай хууль (2011)
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011)
- Хууль тогтоомжийн тухай хууль (2015)
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)
- Татварын ерөнхий хууль (2019)
- “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоол
- “Ногоон хөгжлийн бодлого” Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоол
- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол
- “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол
- “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоол
- “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол
- ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол
- НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын 2011 оны Нийтийн худалдан авах ажиллагааны загвар хууль (2011 Model Law on Public Procurement)
- Дэлхийн Худалдааны Байгууллагын Засгийн газрын худалдан авалтын хэлэлцээр (Agreement on Government Procurement)
- Азийн хөгжлийн банкны зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журам (2017) (Procurement Regulations for ADB Borrowers, 2017)
- Дэлхийн банкны зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журам (2020) (The World Bank Procurement Regulations for IPF Borrowers, 4th ed. 2020)
- Европын холбооны удирдамж (2014) (EU Public Procurement Directives, 2014),
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын худалдан авах ажиллагааны зарчим (2009) (OECD Principles for Integrity in Public Procurement, 2009)
- Дани Улсын Нийтийн худалдан авах ажиллагааны хууль (2015) (The Public Procurement Act No.1564 of Dec 15, 2015)
- БНСУ-ын Засгийн газрын худалдан авах ажиллагааны хууль (Government Procurement Act No.4697 of Jan 5, 1994)

- Эстони Улсын Нийтийн худалдан авах ажиллагааны хууль (2017) (Public Procurement Act, 2017)
- ИБУИНВУ-ын Нийтийн худалдан авах ажиллагааны хууль (2015) (The Public Contracts Regulations 2015)
- Сингапур Улсын Засгийн газрын худалдан авах ажиллагааны хууль (1998) (Government Procurement Act, Chapter 120, 1998)
- Гүрж Улсын Нийтийн худалдан авах ажиллагааны хууль (2005) (Law of Georgia on Public Procurement, 2005)
- Казакстан Улсын Нийтийн худалдан авах ажиллагааны хууль (2015) (Law of the Republic of Kazakhstan "On Public Procurement" No.434-V ЗРК of Dec 4, 2015)
- Итали Улсын Нийтийн худалдан авах ажиллагааны хууль (2016) (Public Contracts Code No.50 of Apr 18, 2016).

Бусад:

- Partnership for Action on Green Economy, UNEP (2016). Review of the Public Procurement Legal Framework of Mongolia. Ulaanbaatar, Mongolia.
- The World Bank (2016). Benchmarking Public Procurement 2017: Assessing Public Procurement Regulatory Systems in 180 Economies.
- The United Nations (2014), "Guide to Enactment of the UNCITRAL Model Law on Public Procurement", Vienna, Austria.

Цахим хуудас:

- Улсын дээд шүүх. <http://www.supremecourt.mn>;
- Шүүхийн ерөнхий зөвлөл. <http://www.judoinstitute.mn>;
- Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. <https://shuukh.mn>;
- Худалдан авах ажиллагааны цахим хуудас. www.tender.gov.mn;
- Public Procurement Service of Korea. <https://www.pps.go.kr>;
- БНСУ-ын худалдан авах ажиллагааны цахим хуудас. www.g2b.go.kr
- Сингапур Улсын худалдан авах ажиллагааны цахим хуудас. <http://www.gebiz.gov.sg>
- Эстони Улсын худалдан авах ажиллагааны цахим хуудас. <https://riigihanked.riik.ee/rhr-web/#/>
- ИБУИНВУ-ын худалдан авах ажиллагааны цахим хуудас. <https://www.contractsfinder.service.gov.uk/Search/Results>
- Гүрж Улсын худалдан авах ажиллагааны цахим хуудас. www.tenders.procurement.gov.ge
- Казакстан Улсын худалдан авах ажиллагааны цахим хуудас. www.egov.kz

ХАВСРАЛТ-1

Захиалагчаас авсан судалгаанд оролцогчоос хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг нэн тэргүүнд өөрчлөх шаардлагатай гэж ирүүлсэн байна. Үүнд:

Хуулийн зүйл, хэсэг, заалт	Агуулга
1	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт
2	2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж
3	3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ
3.1	3.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.
4	4 дүгээр зүйл.Захиалагч
5	5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо
10	10 дугаар зүйл.Тендерт оролцогчдод давуу эрх олгох
14	14 дүгээр зүйл.Ерөнхий нөхцөлийг магадлах
16	16 дугаар зүйл.Техникийн чадавх болон туршлагыг үнэлэх
24.5	24.5.Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 30 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна.
30	30 дугаар зүйл.Бүх тендерээс татгалзах
31	31 дүгээр зүйл.Тендер шалгаруулалтын онцгой журам хэрэглэх
32	32 дугаар зүйл.Хязгаарлагдмал тендер шалгаруулалт
33	33 дугаар зүйл.Харьцуулалтын арга
34	34 дүгээр зүйл.Гэрээ шууд байгуулах арга
34.2	34.2.Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.
36.7	36.7.Дэлгэрэнгүй жагсаалтад хамрагдсан зөвлөхүүдээс энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлага болон захиалагчаас тогтоосон чадавхын үзүүлэлтийг хангасан 3 ба түүнээс дээш зөвлөхийг захиалагч сонгож, хураангуй жагсаалт гаргана.
43	43 дугаар зүйл.Гүйцэтгэлийн баталгаа, түүний хэмжээ, гүйцэтгэлийн баталгаа гаргах
44	44 дүгээр зүйл.Урьдчилгаа төлбөр, түүний баталгаа
47.1	47.1.Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.
51	51 дүгээр зүйл.Бүртгэлийн тогтолцоо
55.2	55.2.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар энэ хуулийн 55.1-д заасан гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ. Шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар тендерт оролцогч дахин гомдол гаргасан тохиолдолд хүлээн авахаас татгалзана.

28.7.3	28.7.3.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж, энэ хуульд заасны дагуу үнэлэгдсэн тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно;
30.4.2	30.4.2.энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах;
30.4.3	30.4.3.энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах.
31.1.3	31.1.3.гэрээ шууд байгуулах.

ХАВСРАЛТ-2

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн агуулгын талаарх судалгаа

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн огноо	Нэмэлт, өөрчлөлт орсон зүйл, хэсэг, заалт	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга
1.	2007.02.06	8.10, 28.16, 34.1.6, 34.4, 47.8, 53.6, 56.3, 45.2.1, 5.1.21, 8.3, 9.2, 16.1.1, 45.2.2, 45.2.3, 45.3.1, 45.3.2, 14.2	Худалдан авах ажиллагааны журам сонгох, холбогдох журам батлах, захиалагч этгээдийг тогтоох, гадаадын этгээд гэсэн нэр томьёо, тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцуулах, тендерт оролцогч 3 удаа тендерт шалгарсан бол тухайн жилд тендер шалгаруулалтад дахин оролцуулахыг хязгаарлах зэрэг.
2.	2009.07.16	10.1.5, 9.3	Давуу эрх тооцох, тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцуулах
3.	2010.06.10	55.1, 55.2, 55.3, 55.4, 55.5	Өрсөлдөөний тухай /шинэчилсэн найруулга/ хуульд нийцүүлэн гомдол хянан байгууллагыг өөрчилсөн.
4.	2011.02.10	3.5	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нийцүүлэн нэмэлт орсон.
5.	2011.06.09	5.1.23, 8.11, 8.12, 28.7.5, 34.1.7, 36.6, 36.17, 39.15, 44.3, 46.1.9, 47.5, 52.1.15, 52.3, 52 ¹ дүгээр зүйл /52 ¹ .1, 52 ¹ .2, 52 ¹ .2.1-52 ¹ .2.4/, 29.1, 52.1.11, 55.3, 55.4, 24.5, 29.4, 29.5, 32.2, 45.2-45.7, 47.2.2, 47.4, 47.9, 48.1-48.6, 53.1-53.7, 55.1, 55.2, 56.1, 57.1-57.5, 14.1.4, 14.1.6, 14.5, 20.1, 21.3, 39.6, 46.1.8, 47.5, 21.4, 55.3, 55.4, 8.1.4, 34.1.6, 34.4, 42.1.1, 52.1.9, 52.1.10, 55.5-55.8	Ерөнхий гэрээ байгуулах журам, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагаанд баримтлах үнэлгээ, зөвлөх үйлчилгээ зохион байгуулах, гомдол хянан шийдвэрлэх, худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагатай холбоотой болон худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн талаар шинэ зүйл тусгагдсан.
6.	2011.06.16	3.3, 3.4, 3.5, 3.6, 2.1	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт орсон.
7.	2011.11.30	хугацаа	Хууль дагаж мөрдөх хугацааг өөрчилсөн
8.	2011.12.23	7.1.4, 7 ¹ дүгээр зүйл /7 ¹ .1-7 ¹ .4/, 7.2	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам
9.	2012.05.22	10.1.6	Инновацийн тухай хуульд нийцүүлэн нэмэлт орсон.
10.	2014.07.01	2.1, 3.3	Шилэн дансны тухай хуульд нийцүүлэн нэмэлт орсон.
11.	2015.02.18	4.1.3	Өрийн удирдлагын тухай хуульд нийцүүлэн өөрчлөлт орсон.
12.	2015.07.09	10 ¹ дүгээр зүйл /10 ¹ .1-	Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд

		10 ¹ .3/, 57.1.4	нийцүүлэн нэмэлт орсон.
13.	2015.12.04	57 дугаар зүйл /57.1, 57.1.1-57.1.23, 57.2-57.5/	Зөрчлийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөлт орсон.
14.	2016.02.04	3.7	Сонгууль зохион байгуулахтай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.
15.	2016.02.05	10.1.7, 10.2, 10.3, 10.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт орсон.
16.	2016.02.05	3.8	Ирээдүйн өв сан, Ирээдүйн өв сан корпорацийн үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.
17.	2016.02.05	43.6, 43.7	Барилгын тухай хууль /шинэчлэн найруулга/-д нийцүүлэн нэмэлт орсон.
18.	2016.07.21	53.1, 48.4, 45.4, 45.5, 53.3, 53.4, 53.5, 53.6, 53.7, 53.5.2, 53.5.6	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлэн өөрчлөлт орсон.
19.	2017.02.09	3.7	Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд нийцүүлэн өөрчлөлт орсон.
20.	2017.05.12	10.1.1	Хог хаягдлын тухай хууль /шинэчлэн найруулга/-д нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт орсон.
21.	2017.06.09	34.1.8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /шинэчлэн найруулга/-д нийцүүлэн нэмэлт орсон.
22.	2017.12.08	34.1.9	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нийцүүлэн нэмэлт орсон.
23.	2018.01.12	3.9	Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлэн нэмэлт орсон.
24.	2019.03.22	3.10, 5.1.24-5.1.29, 7.4- 7.6, 8.7.5, 8.13, 10 ¹ .4, 20.7.3, 29.6, 29.7, 34.1.10, 36.18, 52 ¹ .3, 55.9, 10.3, 10.4, 21.1, 22.4, 55.1, 5.1.23, 10 ¹ .2, 11.1.1, 11.1.2, 21.3, 22.2, 28.7.3, 33.2.1, 45.7, 46.1.6, 47.5, 52.1.3, 52.1.7, 55.2, 5.1.7, 8.1.5, 21.4, 32.2, 52.1.12, 53.5.4, 10.1, 10.2, 10.1.7, 10 ¹ .1, 14.3, 24.5, 29.2, 29.4, 33.3, 34.1.1, 34.1.2, 46.1.5, 45.4, 48.4, 53.1, 53.5, 53.7, 45.5, 53.3, 53.4, 53.5.2, 53.5.6, 53.6, 3.6, 3.7, 3.8, 33.4, 52.1.15, 52.2, 52.3	Худалдан авах ажиллагааны цахим систем, цахим худалдан авах ажиллагаа, цахим дэлгүүр, ногоон худалдан авах ажиллагаа, урьдчилсан худалдан авах ажиллагаа зэрэг шинэ нэр томъёог тодорхойлж, Засгийн газрын худалдан авах ажиллагаа эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байх болон цахим худалдан авах ажиллагаатай холбоотой тендер шалгаруулалтын урилга, үр дүн нийтлэх талаар холбогдох заалтуудад өөрчлөлт орсон.

74

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

Нэг. Шалгуур үзүүлэлт	1
Хоёр. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох	2
Гурав. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх	2
3.1. Зорилгод хүрэх байдал	2
3.2. Хүлээн зөвшөөрөгдөх байдал	4
3.3. Зардал	10
3.4. Харилцан уялдаа	10
Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх	12
4.1. Баримтжуулалт	12
4.2. Дүгнэлт	12
4.3. Зөвлөмж	13

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-д Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан үр нөлөөний үнэлгээ хийж, зөвлөмж гаргах зорилгоор Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д зааснаар уг тайланг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийхэд сонгогдсон холбогдох шалгуур үзүүлэлтийг шалгаж, тогтоох зорилгоор тандан судалгааг нээлттэй, хаалттай анкетын асуулгаар худалдан авах ажиллагааны цахим систем (цаашид “цахим систем” гэх)-ээр худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын төлөөллийг хамруулан 2021 оны 9 дүгээр сарын 24-28-ны өдрийн хугацаанд цахим хэлбэрээр зохион байгуулсан. Түүвэр судалгаанд нийт 1,078 оролцогч оролцсоноос захиалагч байгууллагын 458, тендерт оролцогчийн 798, төрийн бус байгууллагын 22 төлөөлөл хамрагдсан байна. Цахим системд бүртгэлтэй нийт 2,528 захиалагч байгууллага, 15,156 тендерт оролцогчоос¹ судалгаанд захиалагч байгууллагын 18.1 хувь, тендерт оролцогчийн 3.9 хувь нь оролцсон байна.

Нэг. Шалгуур үзүүлэлт

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-ийн үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэллээ. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
3. Зардал
4. Харилцан уялдаа.

Зорилгод хүрэх байдал:Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт нь хуулийн төслийг шинэчлэн найруулах болсон зорилго, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцсэн эсэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэсэн эсэхийг үнэлэх зорилгоор уг шалгуур үзүүлэлтийг сонгосон.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал:Хуулийн үр дагаварт шууд өртөх захиалагч болон тендерт оролцогч этгээд хуулийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэхийг тогтоох зорилгоор уг шалгуур үзүүлэлтийг сонгосон.

Зардал:Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн байгууллага, тендерт оролцогч этгээдэд нэмэлт зардал үүсгэх эсэхийг тогтоох зорилгоор уг шалгуур үзүүлэлтийг сонгосон.

Харилцан уялдаа:Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх, төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардаж байгаа эсэхийг шалгах зорилгоор уг шалгуур үзүүлэлтийг сонгосон.

¹ Цахим системд 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар бүртгэгдсэн захиалагч, тендерийн оролцогчийн тоо

Хоёр. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Захиалагч, тендерт оролцогчоос хуулийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах
3	Зардал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардах эсэх, тендерт оролцогчоос нэмэлт зардал гарах эсэхийг шалгах
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах

Гурав. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх

Энэ тайлангийн 2 дугаар зүйлд урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлт, тэдгээрт хамаарах шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийлээ.

3.1. Зорилгод хүрэх байдал

Хуулийн төслийн батлагдсан үзэл баримтлалд тусгагдсан дараах зорилтыг хуулийн төсөл хангах эсэхийг үзэл баримтлал, хуулийн төслийг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ:

1. худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүй орчныг бүрдүүлэх,
2. ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт хариуцлагыг дээшлүүлэх,
3. тендер шалгаруулалт дахь хүний оролцоог бууруулах,
4. тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулах.

Зорилт 1: Худалдан авах ажиллагааны бүх үе шатыг цахим хэлбэрээр зохион байгуулах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Хуулийн төслийн 45 дугаар зүйлд худалдан авах ажиллагааг төлөвлөх асуудлыг худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэхээр заасан. Уг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах (хуулийн төслийн 10 дугаар зүйл), тендер шалгаруулалтын зарлалыг нийтлэх (хуулийн төслийн 17 дугаар зүйл), тендер хүлээн авах (хуулийн төслийн 19 дүгээр зүйл), тендерийг хянан үзэх (хуулийн төслийн 27 дугаар зүйл), тендер шалгаруулалтын үр дүнг нийтлэх (хуулийн төслийн 30 дугаар зүйл), худалдан авах ажиллагааг тайлагнах (хуулийн төслийн 47 дугаар зүйл) зэргийг цахим хэлбэрээр гүйцэтгэх талаар тус тус зохицуулсан байна.

Зорилт 2: Худалдан авах ажиллагааны бүх шатанд ил тод, нээлттэй байдлыг хангах зорилтын хүрээнд хуулийн төслийн 5 дугаар зүйлд ил тод байдлыг хангах, хариуцлагатай байх гэсэн одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зарчмыг хадгалсан байна. Хуулийн төслийн 26 дугаар зүйлд тендерт оролцогчийн тендерээс Байгууллагын болон Хувь хүний нууцын тухай хуульд зааснаас бусад нууцлаагүй хэсгийг бусад оролцогчдод худалдан авах ажиллагааны цахим системээр танилцуулах боломжийг хуулийн төсөлд тодорхой зохицуулсан байна. Ингэснээр тендер шалгаруулалтад бусад оролцогчид хөндлөнгийн хяналт тавих нөхцөл боломжийг хуулиар олгосон байна.

Түүнчлэн тендер шалгаруулалтад оролцогч ажилтан, албан хаагч нь тендер шалгаруулалтын явцад илэрсэн тендерт оролцогчийн ерөнхий нөхцөлийн шаардлагад нийцээгүй аливаа мэдээллийг холбогдох дээд шатны байгууллага, худалдан авах ажиллагааны улсын байцаагчид заавал хүргүүлэх талаар үүргийг хуулийн төслийн 52 дугаар зүйлд тусгасан нь худалдан авах ажиллагааны хууль тогтоомж зөрчсөн тухай асуудлыг нуун дарагдуулах, ашиг сонирхлоос хамаарч тендерт оролцогчийн хууль тогтоомжид нийцээгүй мэдээллийг худалдан авах ажиллагааны улсын байцаагчид мэдээлэх, мэдээлэхгүй байх зэргээр ялгавартай хандах захиалагчийн субъектив хүсэл зоригийг хааж байгаа сайн талтай байна.

Мөн хуулийн 62 дугаар зүйлд заасан хариуцлага хэсгийн холбогдох зохицуулалтаар одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хариуцлагын тогтолцоонд хамаардаггүй төрийн албан хаагч бус захиалагч этгээдийн хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд хариуцлага ногдуулахаар заасан байна.

Зорилт 3: Хуулийн төслийн 54 дүгээр зүйлд тендерт оролцогч нь худалдан авах ажиллагааны цахим системд хуулийн 6 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага, 14-16 дугаар зүйлд заасан чадавх, туршлагыг хангах талаар мэдээлэл, баримт бичгийг агуулсан мэдээллийн цахим сан үүсгэхээр заажээ. Түүнчлэн хуулийн төслийн 14 дүгээр зүйлд тендерт оролцогчтой холбоотой төрийн эрх бүхий байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг тендерт оролцогчоос шаардахгүй байх зохицуулалтыг тусгасан байна. Дээр дурдсан цахим мэдээллийн санд үндэслэн тендерийг хянан үзэх шатыг худалдан авах ажиллагааны цахим системээр хийх боломжийг бий болгосноор тендер шалгаруулалт дахь хүний оролцоо буурах боломжтой байхаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Зорилт 4: Тендер шалгаруулалтад мэдээллийн технологи, цахим системийн мэдээллийг ашиглах боломжийг бүрдүүлснээр тендер шалгаруулалтыг шуурхай, хялбар зохион байгуулах боломж нээгдсэн байна.

Хуулийн төсөлд нээлттэй тендер шалгаруулалтын аргаас гадна өрсөлдөөнт хэлэлцээ (хуулийн төслийн 35 дугаар зүйл), үнийн санал цахимаар дуудах (хуулийн төслийн 36 дугаар зүйл), нэг үүсвэрээс худалдан авах (хуулийн төслийн 37 дугаар зүйл) зэрэг шинэчилсэн аргыг хэрэглэхээр заасан. Худалдан авах ажиллагааны бараа, ажил, үйлчилгээ гэсэн төрөлд үндэслэн тендер шалгаруулалтын аргыг сонгох байдлаас татгалзаж хуульд заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд тохирсон аргыг хэрэглэхээр тусгасны зэрэгцээ тендер хүлээн авах, тендерийн үнэлгээ хийх үе шат дахь хугацааг харгалзан бууруулахаар тусгасан байна.

Тухайлбал нээлттэй тендер шалгаруулалтын аргын үед тендер хүлээн авах доод хугацааг тендер зарласнаас хойш 30 хоног байсныг ажил гүйцэтгэх, үйлчилгээ

үзүүлэх тендер шалгаруулалтад ажлын 15 хоног, бараа нийлүүлэх тендер шалгаруулалтад ажлын 7 хоног байхаар хуулийн төслийн 33 дугаар зүйлд тусгасан байна.

Тендерийн үнэлгээг тендер нээснээс хойш ажлын 15 хоногийн хугацаанд хийхээр заасны хамт захиалагч тендер шалгаруулалтын хүчинтэй байх хугацааг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч сунгаж байсныг халж захиалагч ажлын 10 хүртэл хоногийн хугацаагаар сунгахаар хуулийн төслийн 24 дүгээр зүйлд заасан нь тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулахад шууд нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн үнийн санал цахимаар дуудах ажиллагааг урилга хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 3-аас доошгүй хоногийн дараа зохион байгуулахаар, өрсөлдөөнт хэлэлцээний аргаар хэлэлцээ хийх хугацааг урилга нийтэлснээс хойш ажлын 3-аас доошгүй хоног байхаар тус тус хуулийн төсөлд тусгасан байна.

Хуулийн төсөл нь хуулийн үзэл баримтлалд туссан зорилгод нийцсэн гэж дүгнэж байна.

3.2. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Хууль хэрэгжсэнээр захиалагч байгууллага, тендерт оролцогч холбогдох хуулийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэхийг хуулийн төслийн тандан судалгаанд үндэслэн шалгасан.



Нээлттэй тендер шалгаруулалтад тендер хүлээн авах хугацааг 30 ба түүнээс дээш хоног байхаар хуульд заасан бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд уг хугацааг бууруулах талаар судалгаанд оролцогчдын өгсөн саналд үндэслэн тендер шалгаруулалт цахим хэлбэрээр зохион байгуулахтай уялдуулан тендер хүлээн авах доод хугацааг хуулийн төсөлд ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтад ажлын 15, бараа нийлүүлэх тендер шалгаруулалтад ажлын 7 хоног байхаар тусгасан байна.

Ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх нээлттэй тендер шалгаруулалтад тендер хүлээн авах доод хугацаа “ажлын 20 хоног” гэсэн сонголтыг судалгаанд оролцогчдын 25 хувь нь, харин ажлын 20-оос доош хоног гэсэн хугацааг нийт оролцогчдын 75 хувь нь сонгосон байна.

Бараа нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалтад тендер хүлээн авах доод хугацаа “ажлын 15 хоног” гэсэн сонголтыг судалгаанд оролцогчдын 29 хувь нь, харин ажлын 15-аас доош хоног гэсэн хугацааг нийт оролцогчдын 71 хувь нь сонгосон байна.




Судалгаанд оролцогч захиалагч байгууллага, тендерт оролцогч, төрийн бус байгууллагын төлөөлөл тус бүрээс тендер хүлээн авах хугацааг бууруулахтай холбоотой өгсөн хариултыг доорх графикт үзүүлэв.



Хуулийн төсөлд тусгасан тендер хүлээн авах хугацааг бууруулсан зохицуулалт нь худалдан авах ажиллагаанд оролцогчдын хүсэл зоригт нийцсэн гэж дүгнэж, хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

Судалгаанд оролцогчдын 56.7 хувь буюу олонх нь захиалагч тендерийн үнэлгээ хийх боломжтой хугацаа “ажлын 10 хоног” гэж хариулсан байна. Доорх графикт судалгаанд оролцогч захиалагч байгууллага, тендерт оролцогч, төрийн бус байгууллагын төлөөлөл тус бүрээс өгсөн хариултыг харна уу.




Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “Захиалагч аль болох богино хугацаанд тендерийг хянан үзэх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох ажиллагааг хийх ба тендер нээснээс хойш ажлын 15 хоногоос хэтрэхгүй байна.” гэж заасан нь худалдан авах ажиллагаанд оролцогч бүх талуудын хүлээн зөвшөөрөх байдалд нийцсэн гэж үзэж байна.


Гадаадын этгээд оролцохыг зөвшөөрөх тендер шалгаруулалтын босго үнийг эдийн засаг, нийгмийн амьдралд гарсан өөрчлөлт, бараа, үйлчилгээний үнийн инфляц, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшны өөрчлөлт зэрэгтэй уялдуулан хуулийн төсөлд 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 300 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцоно гэж шинэчлэн тогтоосон байна.

Төрийн болон орон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 2005 онд шинэчлэн найруулж батлахад 1 тэрбум 1 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 100 сая 1 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээнд гадаадын этгээд оролцохыг зөвшөөрсөн байна. Тус хуульд 2007 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцох босго үнийг 10 тэрбум 1 төгрөг гэж өөрчилсөн байна.

Монгол Улсын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн инфляцын өсөлтийн графикаас харахад үнийн жилийн инфляц тасралтгүй хэлбэлзэлтэйгээр өссөн байна.²



Монголбанкнаас гаргасан судалгаанаас харахад төгрөгийн ам.доллартой харьцах ханш тасралтгүй өссөн байгаа нь харагдаж байна.³



² Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. www.1212.mn

³ Монголбанк. Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн судалгааны зургийн багц. 2020 оны 4 дүрээр улирал. http://stat.mongolbank.mn/stats/pdfRender?i=chartPack_2020Q4

Гадаадын этгээд оролцохыг зөвшөөрөх тендер шалгаруулалтын босго үнийг судалгаанд оролцогчдын 36.3 хувь нь нэмэх шаардлагатай, 31.9 хувь нь нэмэх шаардлагагүй, 31.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бөгөөд нэмэх шаардлагатай гэж хариулт өгсөн оролцогчдоос гадаадын этгээд оролцох тендер шалгаруулалтын босго үнийг ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтад “15 тэрбум төгрөг” гэж 45.9 хувь нь, 15 тэрбум төгрөгөөс дээш гэж 54.1 хувь нь, бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтад “400 сая төгрөг” гэж 43.6 хувь нь, 400 сая төгрөгөөс доош гэж 56.4 хувь нь тус тус хариулсан байна.




Иймд худалдан авах ажиллагаанд оролцогчид гадаадын этгээд оролцох тендер шалгаруулалтын босго үнийг нэмэхээр хуулийн төсөлд тусгасныг хүлээн зөвшөөрсөн гэж дүгнэж болохоор байна.


Хуулийн төслийг баталж хэрэгжүүлснээр төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд захиалагчийн шийдвэрт гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим тус бүрийн 3 гишүүний төлөөлөл бүхий 9 гишүүний бүрэлдэхүүнтэй, байнгын ажиллагаатай тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх зөвлөлийг бий болгохоор хуулийн төслийн 59 дүгээр зүйлд тусгасан байна.

Судалгаанд оролцогчдоос шүүхийн өмнөх шатанд тендерт оролцогчдын гомдол маргааныг хянан шийдвэрлэх хамгийн тохиромжтой байгууллагаар Сангийн яам гэж нийт оролцогчдын хамгийн олон буюу 36.4 хувь нь сонгосон бөгөөд судалгаанд оролцогч захиалагч, тендерт оролцогч, төрийн бус байгууллагын төлөөллүүдээс мөн Сангийн яамыг бусад сонголт болох захиалагч байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, Маргаан таслах бие даасан зөвлөлөөс хамгийн олон удаа сонгосон байгааг доорх графикт үзүүлэв.

Гомдол, маргаан шийдвэрлэх тохиромжтой байгууллага



Гомдол, маргаан шийдвэрлэх тохиромжтой байгууллага



- Захиалагч
- ШӨХТГ
- Сангийн яам
- Авлигатай тэмцэх газар
- Үндэсний аудитын газар
- Маргаан таслах зөвлөл

Судалгаанд оролцогчдоос Сангийн яамыг сонгосон шалтгаанд худалдан авах ажиллагааны бодлого эрхэлсэн байгууллага, холбогдох дүрэм журмыг баталдаг, санхүүжүүлэгч байгууллага учраас хяналт тавих нь зүйтэй, дээд шатны байгууллага, худалдан авах ажиллагаа нь санхүү төсөвтэй холбоотой, Сангийн яаманд бүх мэдээлэл төвлөрдөг, туршлагатай бөгөөд мэргэшсэн, одоо гомдол хянан шийдвэрлэж байгаа, улсын байцаагч шийдвэрлэх нь зөв, үндэслэлтэй шийдвэр гаргадаг зэрэг тайлбар өгсөн байна.

Дараагийн тохиромжтой байгууллагаар захиалагч байгууллагыг сонгосон шалтгаанд цаг хугацаа хэмнэх, түргэн шуурхай

шийдвэрлэх, тендер шалгаруулалтын талаар хамгийн сайн мэдээлэлтэй, захиалагч өөрөө хэрэглэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах учраас, тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтыг боловсруулдаг, захиалагч учраас зэрэг тайлбар өгсөн байна.

Түүнчлэн тендер шалгаруулалтын гомдол, маргааныг хянан шийдвэрлэх бие даасан зөвлөл байгуулахыг судалгаанд оролцогчдын дийлэнх олонх буюу 64.7 хувь нь дэмжсэн байна. Харин мэдэхгүй буюу бусад гэсэн хариултыг сонгосон судалгаанд оролцогчид (35.2 хувь)-ын 62.1 хувь нь дэмжихгүй байгаа шалтгаанд хариулт өгсөн байна. Зөвлөл байгуулах нь хүнд суртал, илүү шат дамжлага үүсгэж, цаг хугацаа удаашрах хурдан шуурхай шийдвэр гаргахгүй байх талтай гэж 29.7 хувь нь, ашиг сонирхлын зөрчил үүсэх, авлига нэмэгдэх талтай, найдвартай бус, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимд итгэл хүлээлгэх боломжгүй

гэж 13.1 хувь нь, одоогийн хуульд заасан байгууллага Сангийн яам, улсын байцаагч хянах нь зүйтэй өөрчлөх шаардлагагүй гэж 12.7 хувь нь хариулжээ.

Түүнчлэн хуулийн төслийн 54 дүгээр зүйлд тендерт оролцогчийн ерөнхий шаардлага, чадавх туршлагыг үнэлэхэд шаардаж буй олон төрлийн баримт бичгийг бууруулах, тендер хянан үзэх үе шатыг цахим системээр хийхэд шаардлагатай мэдээллийн цахим санг үүсгэх талаар тусгажээ. Уг мэдээллийн санг тендерт оролцогч цахим системд үүсгэх тухай хуулийн төсөлд заасан чиг үүргийг худалдан авах ажиллагаанд оролцогчид хэрхэн үнэлж байгааг шалгахад судалгаанд оролцогчдын 86.9 хувь нь дэмжсэн байна.

Харин мэдээллийн санг тендерт оролцогч цахим системд үүсгэх нь тохиромжгүй байгааг судалгаанд оролцогч 13.1 хувиас шалтгааныг тодруулахад 63 хувь нь тайлбар өгсөн байна. Цахим мэдээллийн санд компанийн мэдээлэл үүсгэх боломжгүй, мэдээлэл байнга өөрчлөгдөж байдаг тул бодитой бус мэдээлэл байх талтай гэж 16.5 хувь нь, өрсөлдөөн хязгаарлах, шинэ аж ахуйн нэгжийн тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжийг хязгаарлах талтай гэж 14 хувь нь, компанийн мэдээллийн нууцлал алдагдах эрсдэлтэй, төрөөс хэт хувийн компанийн мэдээлэлд оролцож байгаа нь зохистой бус гэж 11.4 хувь нь, ашиг сонирхлын зөрчил үүсэх, шийдвэр шударга байх эргэлзээтэй гэж 7.6 хувь нь тус тус хариулсан байна.

Дээрх судалгааны хариултаас дүгнэхэд төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд захиалагчийн шийдвэрт гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх байнгын ажиллагаатай тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх зөвлөлийг байгуулах, уг зөвлөлийн бүрэлдэхүүнд захиалагч, төрийн бус байгууллагын төлөөллийг оруулах эсэх асуудлыг сайтар судлах шаардлагатай байна.

3.3. Зардал

Хуулийн төслийн хэлэлцүүлэг болон төрийн байгууллагаас ирүүлсэн саналын дагуу хуулийн төсөлд тусгасан тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх зөвлөлийг хуулийн төслөөс хассан тул тус зөвлөлтэй холбогдох зардал үүсэхгүй болсон.

Иймд Зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу шинэчлэн боловсруулахад улсын төсөвт шинээр зардал үүсээгүй болно.

Түүнчлэн захиалагч, тендерт оролцогчдод нэмэлт зардлын ачаалал үүсэхгүй.

3.4. Харилцан уялдаа

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулж, хуулийн төслийн харилцан уялдаа холбоог бүхэлд нь шалгалаа:

№	Асуулт	Хариулт
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм

2.	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Хуулийн төслийн 2.1 дэх хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.”, 2.3 дахь хэсэгт “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбоотой асуудлаар Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуульд заасан журмыг мөн баримтална.” гэж тус тус тусгасан.
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм. Хуулийн нэр томьёо нь холбогдох салбарын хуульд заасан нэр томьёотой зөрчилдөөгүй болно.
4.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм. Хуулийн төсөлд Монгол Улсын Үндсэн Хууль болон бусад холбогдох хуулийн зүйл заалттай зөрчилдөх агуулгатай зүйл, заалт тусгагдаагүй болно.
5.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төслийн зүйл, заалтууд хоорондоо болон бусад хуулийн зүйл заалттай давхардсан агуулгатай зүйл, заалт тусгагдаагүй болно.
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм. Хуулийн төслийн 3.1.8 дахь хэсэгт захиалагч, 3.1.11-д оролцогч, 3.1.13-т сонирхогч этгээдийг тодорхойлж, хуулийн төслийн 49 дүгээр зүйлд захиалагч, 55 дугаар зүйлд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 56 дугаар зүйлд худалдан авах ажиллагааны улсын байцаагч, 57 дугаар зүйлд худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын хэрэгжүүлэх чиг, үүргийг тодорхой тусгасан байна.
7.	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй. Хуулийн төсөлд одоогийн нийгэм, эдийн засаг, хөгжлийн явцтай уялдуулан зайлшгүй зохицуулах шаардлагатай асуудлуудыг хуулийн төсөлд бүрэн тусгасан. Орхигдуулсан болон ойлгомжгүй болгосон аливаа зохицуулалт байхгүй.
8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй. Хуулийн төсөлд давхардал үүсгэх, шинэ чиг үүргүүдийг давхардуулан тусгасан зүйл үгүй.
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм. Хуулийн төслийн 57.7 дахь хэсэгт “Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.” гэж заасан.
10.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд ямар нэгэн албан татвар, төлбөр, хураамжтай холбоотой зохицуулалт агуулагдаагүй болно.
11.	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусаагүй болно.

	үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	
12.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй. Монгол Улсын Үндсэн Хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан агуулга бүхий зохицуулалт уг хуулийн зүйл, заалтад тусгагдаагүй болно.
13.	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг зөрчих ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй.
14.	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй. Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгох, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй.
15.	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй. Хуулийн төсөлд аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно.
16.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд тусгагдсан хэм хэмжээг зөрчигчид хүлээлгэх хариуцлага Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу шийдэгдэнэ.

Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх

4.1. Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг ашиглалаа.

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан;
- Сангийн сайд, Хууль зүйн дотоод хэргийн сайдын хамтран баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал;
- Батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх тандан судалгаа.

4.2. Дүгнэлт

Хуулийн төсөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд

дурдсан хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалд нийцсэн байна.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын Хоёрдугаар бүлэгт заасан хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлагыг хангасан гэж үзэж байна.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхээр сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд зохих шалгах хэрэгслээр хуулийн төслийн холбогдох зохицуулалтыг шалгаж үнэлэхэд хуулийн төсөл нь зорилгод хүрэх байдал эерэг, хуулийн төслийг хэрэглэх, хэрэгжүүлэх байгууллага, сонирхогч этгээдүүд хүлээн зөвшөөрч хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэлээ. Мөн хуулийн төслийн холбогдох зохицуулалт нь Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан харилцан уялдааг хангах 16 асуултаар шалгахад хуулийн төсөл нь харилцан уялдааг бүрэн хангасан байна.

4.3. Зөвлөмж

Тендер шалгаруулалтыг зохион байгуулах хугацааг харгалзан бууруулах асуудлыг хуулийн төслийг хэлэлцүүлгийн хүрээнд тусгайлан санал авч саналд үндэслэн хуулийн төсөлд тусгах хэрэгцээ байна.

АЖЛЫН ХЭСЭГ

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу тооцлоо.

Хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэнэ.

Нэг. Иргэнд үүсэх зардал

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль батлагдсанаар иргэдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна.

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь иргэнд зардал үүсгэхгүй болно.

Хоёр. Хуулийн этгээдэд үүсэх зардал

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар хуулийн этгээд тодорхой төрлийн үүрэг гүйцэтгэхийг даалгасан буюу шаардсан бол үүний дагуу хуулийн этгээдэд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргах юм.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу нэг бүрийн зардлыг тооцох, тоон үзүүлэлтийг тооцох, нийт зардлын дүнг тооцож гаргах, хялбарчлах боломжийг шалгах, нэмэлт зардлыг тооцож үзэхэд хуулийн этгээдэд шууд үүрэг бий болгосон заалт, түүнтэй уялдан зардал шинээр үүсэх зохицуулалт байхгүй байна.

Гурав. Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал

Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тооцоолохдоо шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар шинээр төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, уг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, гарах зардлыг тодорхойлохыг зорьсон.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинэ төрлийн буюу зардал үүсгэх боломжтой үүргийг шинээр бий болгоогүй. Хуулийн төсөлд тусгагдсан Засийн газар, төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн байгууллагуудын одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд үндсэн чиг үүрэг хэвээр байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийн нэгдсэн сан үүсэх, иргэн, төр, хувийн хэвшил цахимаар мэдээлэл солилцох, ашиглах, техник технологийн дэд бүтэц бий болох тул түүнтэй уялдан зардал буурах боломж бүрдэх бөгөөд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар шинээр зардал бий болохгүй болно.

--o0o--

СҮҮЛИЙН МЭДЭЭЛЭЛ

VACANCY ANNOUNCEMENT
ОНЦЛОХ МЭДЭЭ | 2021-09-24

НОТАРИАТААР ГЭРЧЛҮҮЛЭХ
ШААРДЛАГАТҮЙ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ
ОНЦЛОХ МЭДЭЭ | 2021-09-24




СҮРГАЛТЫН БАР
ОНЦЛОХ МЭДЭЭ | 2021-09-24

"ТӨРИЙН ӨМЧИЙН ЭМНЭЭЛЭГ, ЭРҮҮД
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМЭЭР

ХҮҮЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВАХ ТУХАЙ

2021-09-24



Санал авах тухай

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 2005 онд шинэчлэн найруулсан.